

ХУУЛЬЧИЙН МЭРГЭЖЛИЙН ШАЛГАЛТЫН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ХОРОО

Нэг. Хуульчийн мэргэжлийн шалгалтын асуудал эрхэлсэн хорооны хурал

Хуульчийн мэргэжлийн шалгалтын асуудал эрхэлсэн хороо 2025 онд нийт 6 удаа хуралдсан.

2025 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн хурлаар:

1. 2025 оны Хуульчийн мэргэжлийн шалгалтын тов;
2. 2025 оны Хуульчийн мэргэжлийн шалгалт зохион байгуулалтын комисс байгуулах;
3. Хуульчийн мэргэжлийн шалгалтын хураамжийн хэмжээг нэмэгдүүлэх саналыг Зөвлөлд хүргүүлэх тухай асуудлыг хэлэлцэж тогтоол гаргав.



2025 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн хурлаар:

1. 2025 оны Хуульчийн мэргэжлийн шалгалт зохион байгуулалтын комиссын шийдвэрээр 2025 оны Хуульчийн мэргэжлийн шалгалтад оролцох эрх олгохоос татгалзсан шийдвэрт гомдол гаргасан 116 гомдыг хүлээн авч, тус хурлаар хэлэлцэж, 71 гомдол гаргагчийн гомдлыг хангаж, 14 гомдол гаргагчийн гомдлыг хангахаас татгалзаж шийдвэрлэсэн.

2025 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн хурлаар:

1. Хуульчийн мэргэжлийн шалгалтын бодлогын шалгалтыг дүгнэх комисс байгуулах;
2. Сорилын шалгалтын дүнд гомдол гаргасан оролцогчдын гомдлыг хэлэлцэх; гэх 2 асуудлаар хуралдаж тус тус тогтоол гаргасан.

2025 оны 10 дугаар сарын 29-ний өдрийн хурлаар:

1. 2025 оны Хуульчийн мэргэжлийн шалгалтад оролцож, сорилгын болон бодлогын шалгалтын үнэлгээний нийлбэр дүнгээр 70 ба түүнээс дээш оноо авсан оролцогчдыг баталгаажуулах; асуудлаар хуралдаж нийт 52 оролцогчдын нэрсийг баталгаажуулав.

2025 оны 11 дүгээр сарын 03-ны өдрийн хурлаар:

1. Гомдлын дараах дүнгээр 70 ба түүнээс дээш оноо авсан оролцогчдыг баталгаажуулах; асуудлаар хуралдаж 100 оролцогчдын нэрсийг баталгаажуулав.

Хоёр. Хуульчийн мэргэжлийн шалгалтыг зохион байгуулах бэлтгэл ажлын хүрээнд

Хуульчийн мэргэжлийн шалгалтын 2025 оны жишиг сорилгын хураамж бэлтгэн гаргах ажлын хүрээнд 2024 оны тестүүдэд хяналт хийж, нэмэлт өөрчлөлт орсон, хүчингүй болсон хуулийн зохицуулалттай холбоотой тестүүдийг хасах, засварлах ажлыг хийж дууссан. 2025 оны сорилгын ном 3 хэсэг бүхий 4741 сорилгоос бүрдсэн 1072 хуудас бүхий номыг бэлтгэн гаргасан. Нийт 1000 ширхэгийг хэвлэж худалдаанд гаргасан.

Бодлого бодох аргачлалтын хураамж номыг “Эрх зүйн тохиолдол шийдвэрлэх аргачлал 2023” номыг 2 дахь удаагаа 500 хувь хэвлүүлж худалдаанд гаргасан.

Гурав. Хуульчийн мэргэжлийн шалгалтын тов зарлах, шалгалтын бүртгэл эхэлснийг олон нийтэд мэдээлэх ажлын хүрээнд

Шалгалтын зохион байгуулалтын комисс байгуулах бэлтгэл ажлын хүрээнд шүүгч, прокурор, өмгөөлөгчдийн хороо, хууль зүйн их, дээд 8 сургуульд 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдөр албан бичиг хүргүүлж, нэр дэвших хүмүүсийн мэдээллийг нэгтгэж, 2025 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн хорооны хурлаар хэлэлцүүлж, 2025 оны Хуульчийн мэргэжлийн шалгалт зохион байгуулах комиссыг 14 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан.

Шалгалтын тов тогтоох саналыг Шалгалтын хорооны 06 дугаар сарын 09-ний өдрийн хурлаар хэлэлцэж, 10 дугаар сарын 22-24-ний өдрүүдэд зохион байгуулах тухай саналыг Зөвлөлд хүргүүлсэнээр 2025 оны хуульчийн мэргэжлийн шалгалтын товыг тогтоосон.

2025 оны 07 дугаар сарын 03-ны өдрийн Хэвлэлийн хурлаар Хуульчийн мэргэжлийн шалгалтын тов тогтоох, сорилго болон бодлогын ном худалдаанд гаргаж байгаа талаар болон өнгөрсөн оны бодлогын сургалтын үнэлгээний тайлан, өнгөрсөн жил сорилгын шалгалтад нэмэгдэж орсон бодомжит сорилгын тайлан зэрэг мэдээллийг нийтэд нээлттэй мэдээллэх, түүнчлэн 2024 оны хуульчийн мэргэжлийн шалгалтад тэнцсэн оролцогчдын дэлгэрэнгүй статистик үзүүлэлт зэрэг мэдээллийг өгсөн.

Дөрөв. Хуульчийн мэргэжлийн шалгалтын арга зүйг шинэчлэх төслийн хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажил

АНУ-ын Фүллбрайт төслийн хүрээнд Калифорния их сургуулийн профессор Мей Лин Спенсертэй хамтран “Хуульчийн мэргэжлийн шалгалтын арга зүйг шинэчлэх нь” төслийг 05 дугаар сарын 28-наас 06 дугаар сарын 28-ны өдөр хүртэл хугацаанд хэрэгжүүллээ. Дээрх хугацаанд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн:


1. Хуульчдын холбооны удирдлагууд, Шалгалтын хорооны гишүүд 05 дугаар сарын 27-ны өдөр профессор Мей Лин Спенсертэй уулзалт зохион байгуулж, хамтран хэрэгжүүлэх төслийн төлөвлөгөө болон цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний талаар ярилцсан.
2. Улсын дээд шүүх, Шүүхийн Ерөнхий зөвлөлтэй 05 дугаар сарын 30-ны өдөр уулзалт зохион байгуулж, Дээд шүүхийн уулзалтад УДШ-ийн Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн Ч.Хосбаяр, шүүгч Б.Батцэрэн, Б.Амарбаясгалан, Захиргааны хэргийн танхимын шүүгч Г.Банзрагч, П.Соёл-Эрдэнэ, Гадаад харилцаа, хамтын ажиллагааны албаны дарга Д.Тулга нар, Шүүхийн Ерөнхий зөвлөлийн уулзалтад Хуульчдын холбооны Тамгын газрын дарга Ш.Жолбарс, Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч Э.Золзаяа, Шүүхийн Ерөнхий зөвлөлийн гишүүн Р.Онончимэг, Э.Зоригтбаатар, Шүүхийн сургалт, хүний нөөц хариуцсан гишүүн А.Отгонцэцэг, Гадаад харилцааны газрын дарга Н.Ганбаатар, Шүүгчийн сонгон шалгаруулалт хариуцсан газрын дарга Г.Насанжаргал нар оролцсон.



Улсын Ерөнхий прокурорын дэргэдэх Сургалт, судалгааны хүрээлэнтэй хийсэн уулзалт 05 дугаар сарын 29-ний өдөр болж Хуульчийн мэргэжлийн шалгалтын хорооны гишүүн, Нийслэлийн давж заалдах шатны шүүхийн шүүгч Э.Золзаяа, Улсын Ерөнхий Прокурорын газрын сургалт судалгааны хүрээлэнгийн Сургалтын албаны дарга О.Алтангэрэл, Судалгааны албаны дарга Б.Мөнхдорж, Бодлого төлөвлөлт, хяналт

шинжилгээ, үнэлгээний хэлтсийн ахлах прокурор Б.Эрхэмбаяр, Хяналтын прокурор, доктор Б.Өнөрмаа нар оролцсон.

Өмгөөлөгчдийн төлөөлөлтэй 05 дугаар сарын 31-ний өдөр хийсэн уулзалтад өмгөөлөгч Г.Давааням, С.Тэгшжаргал, С.Гантогтох, О.Чулуунцэцэг, Ч.Жадамба нар тус тус уулзаж салбар бүрийн хуульчийн мэргэжлээр ажиллахад тавигдах шаардлага, прокурор, шүүгчийн сонгон шалгаруулалтын талаар санал, мэдээлэл солилцов.



06 дугаар сарын 03-06-ны өдрүүдэд “Тестийн асуултыг боловсруулах”, “Бодлогын шалгалтын асуултын төсөл боловсруулах”, “Эссэ бичихэд зориулсан рубрик бий болгох”, “MCQs, Esse-г баталгаажуулах сургалт” сэдвүүдээр шүүгч, прокурор, өмгөөлөгч, шалгалтын хорооны гишүүдэд сургалт зохион байгуулав. Мөн 06 сарын 10, 11-ний өдрүүдэд хууль зүйн их, дээд сургуулийн багш нар, хуульчийн үргэлжилсэн сургалтын сургагч багш нарт хуульчийн мэргэжлийн шалгалтын арга зүйн талаар сургалт зохион байгуулсан. Дээрх сургалтад Хуульчдын холбооны Ерөнхийлөгч П.Одгэрэл, Улсын дээд шүүхийн шүүгч Б.Батцэрэн, Г.Банзрагч, Нийслэлийн Иргэний хэргийн Давж заалдах шатны ерөнхий шүүгч Г.Даваадорж, тус шүүхийн шүүгч Э.Золзаяа, Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Д.Халиуна, С.Мөнхжаргал, Эрүүгийн хэргийн Давж заалдах шатны шүүхийн шүүгч Т.Өсөхбаяр, Эрүүгийн хэргийн Давж заалдах шатны шүүхийн шүүгч Г.Ганбаатар, БЗД-ийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.Мандалбаяр, УЕПГ-ын дэргэдэх Сургалт судалгааны хүрээлэнгийн хяналтын прокурор Б.Өнөрмаа, н.Бат-Эрдэнэ, Шалгалтын хорооны гишүүн В.Оюумаа, Д.Дамдинсүрэн, Б.Эрхэмбаяр, Хуульчдын холбооны ёс зүйн хорооны дарга Д.Батболд, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн судлаач Р.Хатансайхан, Хуульчдын холбооны ахлах мэргэжилтэн Ж.Бариаширсүрэн, судлаач Г.Оюунболд, мэргэжилтэн Г.Бямба-Оюун, Г.Сарангэрэл нар оролцсон.



2024 оноос эхлэн “Хуульчийн мэргэжлийн шалгалтын сорилго” гарын авлагыг 3 хэсэгт хуваасан бөгөөд нэгдүгээр хэсэгт зөв хариулт нь өгөгдсөн сорилго, хоёрдугаар хэсэгт зөв хариулт нь өгөгдөөгүй буюу шалгалтад бэлтгэгч өөрөө бие даан хууль судалж зөв хариултыг олох сорилго, гуравдугаар хэсэгт бодомжит сорилго буюу профессор Мэй Лин Спенсерийн заасан аргачлалын дагуу зохиосон сорилго гэсэн хэсгүүдээр бэлтгэн гаргасан. Цаашид хуульчийн мэргэжлийн шалгалтад орох сорилгын сангийн хувийг нэг, хоёрдугаар хэсгээс хувьчлан авч, зөв хариулт өгөгдсөн сорилгыг хасах, хариулт өгөгдөөгүй сорилгын хувийг нэмэх байдлаар шалгуулагчийн мэдлэгийг сорих зорилгыг тавин ажиллах болно.

Тав. Хуульчийн мэргэжлийн шалгалт зохион байгуулах ажлын хүрээнд

Хуульчийн мэргэжлийн шалгалтын асуудал эрхэлсэн хорооноос Шалгалт зохион байгуулах “Зохион байгуулалтын комисс”, бодлогын шалгалтын даалгаварыг дүгнэх “Дүгнэх комисс”-ыг тус тус байгуулж энэ жилийн шалгалтыг зохион байгууллаа.

Энэ жилийн Шалгалт зохион байгуулалтын комиссын даргаар Шалгалтын хорооны дарга Б.Амарбаясгалан, гишүүдээр ХЗДХЯамны төлөөлөл Т.Зул, Шүүгчдийн хорооны төлөөллөөс Т.Жавхлантөгс, Т.Ганчимэг, Прокурорын хороог төлөөлж Н.Эрдэмбилэг, Ц.Ариунжаргал, Өмгөөлөгчдийн хороог төлөөлж Ч.Отгонбаатар, Б.Батцэнгэл, Хуульч профессорын төлөөллөөс МУИС-ийн Хууль зүйн сургуулийн багш С.Батбаяр, Шихихутуг Их сургуулийн багш Ё.Болормаа, С.Мөнхнаран, Отгонтэнгэр Их сургуулийн багш М.Наранцэцэг нар ажилласан.

2025 оны Хуульчийн мэргэжлийн шалгалтын бүртгэлийг 2025 оны 08 дугаар сарын 08-ны өдрөөс 09 дүгээр сарын 21-ний өдрийн 00:00 цаг хүртэлх нийт 45 хоногийн хугацаанд зохион байгуулсан. Энэ хугацаанд нийт 1271 хүн шалгалтад бүртгүүлсэн. Шалгалтын зохион байгуулалтын комисс шалгалтад бүртгүүлэгчдийн баримт бичгийг Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 9, 11 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан эсэхийг хянаж нийт 1228 хүнд шалгалтад оролцох эрх олгосон.

Шалгалтыг 2025 оны 10 дугаар сарын 22-24-ний өдрүүдэд нийт 7 газарт 70 гаруй хүний бүрэлдэхүүнтэйгээр зохион байгуулсан бөгөөд бүрэлдэхүүнд шалгалт зохион байгуулалтын комиссын гишүүд болон хөндлөнгийн хянагч, улсын бүртгэлийн ажилтан, Хуульчдын холбооны Тамгын газрын ажилтан, нийтийн хэв журам сахиулах цагдаагийн албан хаагч гэсэн бүрэлдэхүүнтэйгээр амжилттай зохион байгуулсан. 2025 оны Хуульчийн мэргэжлийн шалгалтад нийт 100 оролцогч тэнцсэн бөгөөд Хуульчийн мэргэжлийн шалгалтын асуудал эрхэлсэн хорооноос тэнцсэн 100 оролцогчдод 2025 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр шалгалтад тэнцсэн “Батламж” олгож, Хуульчдын холбооны ерөнхийлөгчид албан бичгээр тэнцсэн 100 оролцогчийн мэдээллийг тус тус хүргүүлснээр энэ жилийн хуульчийн шалгалт зохион байгуулах ажил албан ёсоор дуусгавар болсон.

ХУУЛЬЧИЙН ҮРГЭЛЖИЛСЭН СУРГАЛТЫН АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ХОРОО

Нэг. Удирдлага зохион байгуулалтын талаар

Хуульчийн үргэлжилсэн сургалтын асуудал эрхэлсэн хороо /цаашид Сургалтын хороо гэх/ нь Хуульчийн үргэлжилсэн сургалтын асуудал эрхэлсэн хороо нь Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1.3-д “хуульчийн үргэлжилсэн болон албан бус сургалтыг зохион байгуулах, багц цагийг тооцох”, Монголын Хуульчдын холбооны зөвлөлийн 2014 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн хурлын 27 дугаар тогтоолын хавсралтаар баталсан Хуульчийн үргэлжилсэн сургалт зохион байгуулах, багц цаг тооцох журамд заасан бүрэн эрхийн дагуу үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллаж байна.

Сургалтын Хороо нь 2025 онд хуульчдад зориулсан сургалтын бодлого, үндсэн чиглэл, хэлбэрийг тодорхойлж, хуульчийн үргэлжилсэн сургалтад зориулан боловсруулсан сургалтын хөтөлбөрийг хянан хэлэлцэх, сургалт явуулах багш нарын талаар санал өгөх, сургалтын явц үр дүнгийн талаар дүгнэлт гаргах, үргэлжилсэн сургалтын багц цагийг тооцох аргачлал, журмыг боловсруулж, Зөвлөлөөр батлуулах болон энэ дүрэм, Хуульчдын холбооноос тогтоосон бусад дүрэм, журамд заасан чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллалаа.

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1.3-д “хуульчийн үргэлжилсэн болон албан бус сургалтыг зохион байгуулах, багц цагийг тооцох”, 53 дугаар зүйлийн 53.2-д заасан чиг үүргийн дагуу Сургалтын хороо нь хуульчдад зориулсан сургалтын бодлого, үндсэн чиглэл, хэлбэрийг тодорхойлж, хуульчийн үргэлжилсэн сургалтад зориулан боловсруулсан сургалтын хөтөлбөрийг хянаж хэлэлцэн, сургалт явуулах багш нарын талаар санал өгч, сургалтын явц үр дүнгийн талаар дүгнэлт гарган ажилласан.

Хорооны төлөвлөгөөг 2025 оны байдлаар гаргаж, Тамгын газарт хүргүүлсэн ба онцгой /сонгуулийн/ жилтэй холбоотой зарим албан бус сургалт болон орон нутгийн сургалтууд хугацааны хувьд хойшлогдсон. Мөн сургалт явуулах танхим байхгүй байгаа тул танхимын сургалт зохион байгуулагдахгүй байна.

Мөн Сургалтын хороо нь албан бус сургалт болон онлайн /зүүм/ сургалтыг 7 хоногийн давтамжтайгаар зохион байгуулж ажиллахаас гадна, сургалтын хорооны үйл ажиллагааг хуульчдад таниулах үүднээс танилцуулга видео болон тодорхой подкаст зэргийг хийж хэрэгжүүлсэн. Мөн сургалтын хөтөлбөрт мониторинг хийж, сургагч багш нарыг шинэчлэн, хороодтой тодорхой байдлаар хамтран ажиллаж сургалтын үйл ажиллагааг тасралтгүй хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хоёр. Сургалтын хорооны хурал

Сургалтын хороо нь 2025 онд нийт 7 удаа хуралдсан бөгөөд хурлаар дараах хүсэлтүүдийг шийдвэрлэсэн байна.

Хуульчийн үргэлжилсэн сургалт зохион байгуулах хугацаа, хөтөлбөрт мониторинг хийх зэрэг сургалтын хөтөлбөр төлөвлөгөө боловсруулж, хороод болон бусад байгууллагатай хамтран ажиллах төлөвлөгөө боловсруулахаас гадна хуульчдаас ирүүлсэн нийт 308+ хүсэлтийг шийдвэрлэж хариуг олгосон. Мөн сургалтын хорооны нэг гишүүн чөлөөлөгдөж, сул орон тоонд шинэ гишүүн хуульчийн сонгон Зөвлөлийн хуралд танилцуулж батлуулсан.

Гурав. Хуульчийн үргэлжилсэн сургалт зохион байгуулах хүрээнд

2025 онд 33 сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 2050 хуульч хамрагдснаас 10 сургалтыг танхимаар, 8 сургалтыг цахимаар бусад байгууллагатай хамтарсан 15 сургалт зохион байгуулжээ.

Хуульчийн үргэлжилсэн танхимын сургалт

2025 онд 10 удаагийн танхимын сургалт зохион байгуулсан нийт 1600 хуульчийг хамруулсан байна.

1. 01 дүгээр сарын 31-ний өдөр “Цахим эрх зүйн ОУ-ын чиг хандлага” сэдэвт хэлэлцүүлгийг хамтран зохион байгуулж хуульчдад 0,5 багц цагийг олгосон ба нийт 27 хуульч хамрагдсан.

2. 02 дугаар сарын 14-ний өдөр EQ - Сэтгэл хөдлөлийн чадамж сэдэвт 0,5 багц цагийн сургалтад Сургагч багш-Г.Баярмаа хичээл заасан бөгөөд уг сургалтад 15 хуульч хамрагдсан.

3. 03 дугаар сарын 27-ны өдрүүдэд Орчин үеийн хуулийн салбар дахь нарийн төвөгтэй байдлыг хэрхэн даван туулах стратегиуд сургалтаар хуульчдад 0,5 багц цагийг олгосон ба нийт 14 хуульч хамрагдсан.

4. 04 дүгээр сарын 18-ны өдөр “Эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагаа” сэдэвт 0,5 багц цагийн сургалт зохион байгуулж нийт 19 хуульч хамрагдсан ба тус сургалт нь прокуроруудад зориулагдсан сургалт.

5. 06 дугаар сарын 20-ны өдөр “Хуульчдын орчин цагийн сургалтын арга зүй” сэдэвт 0,5 багц цагийн уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулж нийт 30 хүн хамрагдсанаас 8 хуульчид багц цаг олгосон.

6. 06 дугаар сарын 23-ны өдөр “Америкийн нэгдсэн улс дахь баривчлах, цагдан хорих, албадлагын арга хэмжээний онцлог” сэдэвт 0,5 багц цагийн уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулж нийт 25 хүн хамрагдсанаас 10 хуульчид багц цаг олгосон.

7. 06 дугаар сарын 26-ны өдөр “Эрүүгийн хэргийг тохиролцоогоор шийдвэрлэх ажиллагаа” АНУ-ын туршлага судлах 0,5 багц цагийн сургалт зохион байгуулж 53 хуульчид багц цаг олгосон.

8. 10 дугаар сарын 16-ны өдөр “Хуульд зааснаар өв залгамжлах, Гэрээслэлээр өв залгамжлах, Өмчлөх эрхийг зөрчих, Өвлөх харилцаа, Өвлөх харилцаа хууль хэрэглээ /процесс

ажиллагаа/" сэдэвт 1,5 багц цагийн сургалтыг Орхон аймгийн хуульчдад зохион байгуулж нийт 53 хуульч хамрагдсан.

9. 10 дугаар сарын 31-ний өдөр "Технологи үйлдэгдэж ашиглагдаж буй жендерт суурилсан хүчирхийлэл, Ялгаварлан гадуурхах гэмт хэргийн ойлголт сэдэвт 2024 онд тангараг өргөсөн шинэ хуульчдад зориулсан сургалтыг зохион байгуулж, хуульчдад 1 багц цаг олгосон.

10 "Эрүүгийн хэргийн хууль зүйн дүгнэлт", "Үйлчлүүлэгчийн сэтгэл зүйн ялгаатай байдлыг ойлгох нь" зэрэг сэдэвт 2 багц цагийн сургалтыг 11 дүгээр сарын 17-ны өдөр зохион байгуулсан ба сургалтад 60 хуульч хамрагдсан.

Хуульчийн үргэлжилсэн цахим вебинар сургалт зохион байгуулах хүрээнд:

1. 2025 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр "Авилгатай тэмцэх газрын хуульчдын сургалт" 2 багц цагийн сургалтад нийт 57 хуульч хамрагдсан.

2. 03 дугаар сарын 31-ний өдөр "Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь өмчлөх эрхийн хэрэгжилтийг хангаж буй практик, зөрчил" сэдэвт 1 багц цагийн сургалтад нийт 22 хуульч хамрагдсан. Сургагч багш Ц.Насанбат.

3. 04 дүгээр сарын 01-ний өдөр "Захиргааны хэргийн шүүхэд гаргах нэхэмжлэлийн төрлүүд", "Илт худал мэдээлэл тараах гэмт хэргийн шинж, шалгах ажиллагаа, хууль зүйн дүгнэлт хийх арга зүй" зэрэг сэдэвт 1 багц цагийн сургалтад нийт 78 хуульч хамрагдсан. Сургагч багшаар Б.Өнөрмаа, П.Соёл-Эрдэнэ.

4. 04 дүгээр сарын 18-ны өдөр "Халдашгүй чөлөөтэй байх эрх", "Хуульчийн ёс зүй" тус тус сэдвээр 1 багц цагийн сургалтад нийт 68 хуульч хамрагдсан. Сургагч багш Б.Энхболд, Я.Мөнхзаяа

5. 06 дугаар сарын 13-ны өдөр "Барилга уул уурхайн салбар дахь хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны эрүүгийн эрх зүйн хамгаалалт, гадаад орнуудын туршлага", "ЭХХША-Хөрөнгө буцаах ажиллагаа" сэдэвт 1 багц цагийн сургалтад нийт 24 хуульч хамрагдсан. Сургагч багш Г.Оюунбаяр, У.Эрдэнэтуяа

6. 06 дугаар сарын 20-ны өдөр "Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг", "Эд хөрөнгө хөлсөх ба Түрээсийн гэрээний эрх зүйн зохицуулалт" зэрэг сэдвээр 1 багц цагийн сургалтад нийт 71 хуульч хамрагдсан.

7. 11 дүгээр сарын 10-ны өдөр "Эрүүгийн хэргийн хууль зүйн дүгнэлт" сэдэвт 1 багц цагийн сургалт зохион байгуулж нийт 57 хуульч хамрагдсан.

8. 11 дүгээр сарын 28-ны өдөр "Татварын зөрчил, хариуцлага, Татварын маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа" сэдэвт 1 багц цагийн сургалтыг зохион байгуулсан ба сургалтад 32 хуульч хамрагдсан.

Үнэт цаасны зах зээлд үйлчилгээ үзүүлэх хуульчдад эрх олгох сургалт

Монголын Хуульчдын холбооноос Санхүүгийн зохицуулах хороотой хамтран 2025 оны 06 дугаар сарын 25, 26, 27-ны өдрүүдэд 16 сургагч багш 20 сэдвийн хүрээнд зохион байгуулсан ба 74 хуульчид эрх олгож сертификат олгов.

Видео хичээлийн сургалтын хөтөлбөр боловсруулах ажлын хүрээнд

Видео хичээлийн санг баяжуулах ажлыг эхлүүлэн бусад байгууллагуудтай хамтран Их дээд сургуулийн сургагч багш нартай хамтран баяжуулахаар ажиллаж байна. Тухайлбал МУИС-ын багш Сургалтын хорооны гишүүн С.Болормаа "Хөдөлмөрийн эрх зүй"-н сэдвээр видео бичлэг хийлгэх, түүнтэй холбоотой подкаст хийх зэрэг ажлыг төлөвлөн ажиллаж байна.

Бусад байгууллагатай хамтарсан сургалт

2025 онд Сургалтын хороо нь бусад 8 байгууллагатай хамтран нийт 1538 хуульчдад багц цаг олгох сургалт зохион байгуулсан байна.

1. Хууль зүйн туслалцааны төвтэй хамтран 68 улсын өмгөөлөгчийг хамруулан, “УЛСЫН ӨМГӨӨЛӨГЧ, АЛБАН ХААГЧДЫН ЧАДАВХЖУУЛАХ” 4 багц цагийн сургалтыг зохион байгууллаа. (2025.03.31)
2. Сонгинохайрхан дүүргийн Прокурорын газар, Мөрдөн байцаах албатай хамтран 3,5 багц цагийн сургалтад 68 хуульчийг хамруулан зохион байгуулсан. (2025.04.04)
3. 2025 оны 3, 4, 8, 9, 11 дүгээр саруудад Хуульчдын холбооны магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрийн хүрээнд Монголын Өмгөөлөгчдийн холбооноос зохион байгуулсан сургалтуудад хамрагдсан нийт 381 хуульчдад журмын дагуу 1-4 багц цаг олгосон.
4. Шүүхийн сахилгын хорооны хуульч албан хаагчдад зориулсан, “Эрх зүй ба технологи модуль 1, 2” сэдэвт 1 багц цагийн сургалтыг зохион байгуулсан ба сургалтад 14 хуульч хамрагдсан. (2025.06.10)
5. Баянзүрх дүүргийн Прокурорын газартай хамтран “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь шийдвэрт хууль зүйн дүгнэлт хийх” сэдэвт 2 багц цагийн сургалтыг зохион байгуулсан ба сургалтад 42 прокурор хамрагдсан. (2025.09.30)
6. УЕПГ-ын Сургалт, судалгааны хүрээлэнтэй хамтран “Хүний хөгжлийн мөчлөг, сэтгэл зүйн дархлааг дэмжих тухай ойлголт, Ажлаас халшрах хам шинж, түүнээс урьдчилан сэргийлэх, Ажлын байран дахь бүтээмж, сэтгэл зүйн дархлаагаа дэмжтх арга зүйн техникүүд” зэрэг сэдэвт 1 багц цагийн сургалтыг зохион байгуулсан ба сургалтад нийт 665 прокурор болон хуульч албан хаагчид хамрагдсан. (2025.09.08)
7. 2025 оны Улсын дээд шүүхийн хуульч албан хаагчдад зориулсан 4 багц цагийн сургалтыг зохион байгуулсан ба сургалтад 37 хуульчд хамрагдсан.
8. 2025 оны Хуульчдын холбооны магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрийн хүрээнд Монголын Нотариатчдын танхимаас зохион байгуулсан сургалтуудад хамрагдсан нийт нотариатчдад журмын дагуу 1-4 багц цаг олгосон.

Орон нутагт зохион байгуулсан сургалтын талаар

“Хуульд зааснаар өв залгамжлах, Гэрээслэлээр өв залгамжлах, Өмчлөх эрхийг зөрчих, Өвлөх харилцаа, Өвлөх харилцаа хууль хэрэглээ (процесс ажиллагаа)” сэдэвт 1,5 багц цагийн сургалтыг 2025 оны 10 дугаар сарын 16-ны өдөр Орхон аймгийн хуульчдад сургалт зохион байгуулж нийт 53 хуульч хамрагдсан.

Дөрөв. Сургалтын хорооны үйл ажиллагааг мэдээлэх, сурталчлах ажлын хүрээнд

1. Хуульчдын холбооны цахим хуудсыг шинэчилж байгаатай холбогдуулан хуульчийн үргэлжилсэн сургалтыг каталогжуулах ажлыг эхлүүлж, сургагч багш нарын мэдээлэл, сургалтын хөтөлбөрийн мэдээллийг тухай бүр оруулж ажиллаж байна.

2. Сургалтын хорооны зар, хөтөлбөрийн мэдээллийн загварыг шинэчилж батлуулсан бөгөөд сургалт эхлэхээс 7-10 хоногийн өмнө зарыг байршуулж хуульчдад түгээж байна.

Хуульчийн үргэлжилсэн сургалтын асуудал эрхэлсэн хороо

Сэдэв:

1. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаан дахь өмчлөх эрх хэрэгжилтийг хангаж буй практик, зөрчил
2. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зөрчил-Төлөөлөх эрх

Ц.НАСАНБАТ
Монголын Хуульчдын холбооны сургагч багш, Хуульчийн үргэлжилсэн сургалтын асуудал эрхэлсэн хорооны гишүүн

2025.04.03 | 08:30-12:30 | zoom

МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБОО

ХУУЛЬЧИЙН ҮРГЭЛЖИЛСЭН СУРГАЛТ

Сэдэв:

“ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ШҮҮХЭД ГАРГАХ НЭХЭМЖЛЭЛИЙН ШААРДЛАГЫН ТӨРЛҮҮД”

Сэдэв:

“ИЛТ ХУДАЛ МЭДЭЭЛЭЛ ТАРААХ ГЭМТ ХЭРГИЙН ШИНЖ, ШАЛГАХ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ ЗҮЙН ДҮГНЭЛТ ХИЙХ АРГА ЗҮЙ”

П.СОЁЛ-ЭРДЭНЭ
Улсын дээд шүүхийн шүүгч, магистр

Б.ӨНӨРМАА
УЕПГ-ын дэргэдэх Сургалт, судалгааны хүрээлэнгийн прокурор, доктор, дэд профессор

2025.04.10 | 09:00-12:10 | zoom

3. Сургалтын хөтөлбөрийг гаргаж, сургалт зохион байгуулсаны дараа тухай бүр мэдээллийг бичиж сайтад оруулж мөн сургалт зохион байгуулсан тухай “Сургалтын тайлан” бичиж Тамгын газрын даргад танилцуулсанаар сургалтад хамрагдсан хуульчдын бүртгэл болон сургагч багшийн урамшууллыг олгож байна. Холбооны мэйл болон утсаар өдөр бүр хуульчдын багц цагтай холбоотой мэдээллийг хуульчдад олгож байна.

4. Мөн багц цагийн хангалттай холбоотой тайлан мэдээг гаргаж, 2025 оны 01 дүгээр сард нийт хуульчдын багц цагийн судалгааг хийж Тамгын газар болон Зөвлөлийн хуралд танилцуулсан. Хуульчийн үргэлжилсэн сургалтын 20 багц цагаас дээш үлдэгдэлтэй 200 хуульчдын мэдээллийг Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг хүчингүй болгуулахаар Тамгын газарт нэрсийг хүргүүлсэн.

5. Хуульчийн үргэлжилсэн сургалтын асуудал эрхэлсэн хорооноос сургалтын чанар хүртээмжийг дээшлүүлэх, эрэлт хэрэгцээг тодорхойлох, судалгааны үр дүнг үндэслэн сургалтын сэдвийг шинэчлэх хүрээнд нийт хуульчдын дунд 2025 оны 01 дүгээр сарын 27-31-ний өдрийн хугацаанд санал асуулга явуулсан.

6. Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1 дэх хэсэгт “Хуульчдын холбооны Хуульчийн үргэлжилсэн сургалтын асуудал эрхэлсэн хороо /цаашид “Сургалтын хороо” гэх/ нь Хуульчдын холбооны хороодын төлөөллөөс болон хуульч профессоруудаас бүрдсэн 13 гишүүний бүрэлдэхүүнтэй байна.”, Монголын Хуульчдын холбооны дүрмийн 8.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Сургалтын хороо нь шүүгч, прокурор, өмгөөлөгчдийн хорооноос тус бүр 2, хуульч профессоруудаас долоон төлөөлөл оролцсон, нийт арван гурван гишүүний бүрэлдэхүүнтэй байна” гэж заасан.

Сургалтын хорооны хуульч профессорын төлөөлөл нэг гишүүн чөлөөлөгдөх хүсэлтээ өгсөн тул уг сул орон тоонд нэрээ дэвшүүлэх, шаардлага хангасан хуульч профессорын хүсэлтийг 2025 оны 02 дугаар сарын 14-ний өдөр хүртэл нийтэд нээлттэй зар оруулан материалыг хүлээн авсан. Үүнд Шихихутуг их сургууль, Дотоод хэргийн их сургууль, МУИС зэрэг нийт 3 сургуулиас нэр дэвшигчдийн материалыг ирүүлсэнээс МУИС-ын багш Л.Банзрагч хуульчийг хорооны хурлаар дэмжин Зөвлөлийн хуралд хүргүүлсэн ба Зөвлөл 05 дугаар сарын 08-ны өдрийн хурлаар батламжилсан.

7. 2024.10.03-ны Хуульчмйн мэргэжлийн дүрэм, ёс зүйн асуудал эрхэлсэн хороотой уулзалт хийсэн. Уулзалтад тус хороо нь Сургалтын хороонд магадлан итгэмжлэгдсэн “Хуульчийн ёс зүй”-тэй холбоотой хөтөлбөрүүдэд дүн шинжилгээ хийх, мөн хуульчдын мэдлэг ур чадвар, боловсролын шинэ үзэл баримтлал, хэрэгцээг хангахуйц жишиг хөтөлбөр боловсруулан ирүүлж Сургалтын хороотой хамтран ажиллах тухай мэдэгдсэн.

2025 онд хуульчдад дээрх сэдвээр сургалт зохион байгуулахад шинэчлэх, сайжруулахаас гадна хорооны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд дээрх ажил хийгдээгүй байсан тул Хуульчийн мэргэжлийн дүрэм, ёс зүйн асуудал эрхэлсэн хороонд 2025.04.16-ны өдөр 1/59 тоот албан бичиг хүргүүлж ажиллалаа.



Тав. Бусад арга хэмжээнд оролцсон байдал

Монголын Хуульчдын холбооны Ерөнхийлөгч П.Одгэрэл чиг үүргийн хороодын дарга, сайн дурын хороодын тэргүүнүүд, Тамгын газрын мэргэжилтнүүдтэй 2025 оны нэгдүгээр сарын 10-ны өдөр уулзсан. Уулзалтын үеэр Монголын Хуульчдын холбооны Тамгын газрын мэргэжилтнүүд 2024 оны тайлан, мэдээллээ танилцуулж, хороодын дарга, тэргүүнүүд 2025 онд

хэрэгжүүлэх ажлын талаар санал солилцсон.

Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газартай хамтран ажиллах санамж бичгийг 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр байгууллаа. Санамж бичгийн хүрээнд талууд Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар болон төрийн байгууллагуудын үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомжийг боловсронгуй болгох, хамтарсан судалгаа хийх, сургалт, хэлэлцүүлэг зохион

байгуулах чиглэлээр хамтран ажиллах юм.

Монголын Хуульчдын холбооноос АНУ-ын Элчин сайдын яамтай хамтран “Хуульчдын орчин цагийн сургалтын арга зүй” болон “АНУ дахь баривчлах, цагдан хорих албадлагын арга хэмжээний онцлог” сэдэвт сургалт-хэлэлцүүлгүүдийг 2025 оны 06 дугаар сарын 20-ны өдөр зохион байгуулсан.

Хуульчдын орчин цагийн сургалтын арга зүй” Сургалт-хэлэлцүүлгийн илтгэгчээр АНУ-ын Холбооны Шүүх(Federal Judicial Center, FJC)-ийн Дипломат албаны/Гадаад харилцааны хэлтсийн захирал Мира Гур-Ари, панелистаар Хуульчдын холбооны Шүүх(Federal Judicial Center, FJC)-ийн Дипломат албаны/Гадаад харилцааны хэлтсийн захирал Мира Гур-Ари, панелистаар Монголын Хуульчдын холбооны Хуульчийн үргэлжилсэн сургалтын асуудал эрхэлсэн хорооны дарга, доктор, дэд профессор Б.Өнөрмаа оролцлоо.



Монголын Хуульчдын холбооны Хуульчийн үргэлжилсэн сургалтын асуудал эрхэлсэн хорооны дарга, доктор, дэд профессор Б.Өнөрмаа оролцлоо.



Зургаа. Албан бус сургалт зохион байгуулсан ажлын хүрээнд

1.Боловсролын мэдээллийн технологийн төвийн албан хаагчдад зориулсан албан бус сургалт зохион байгууллаа. Дээрх сургалтыг 2025.05.19-ний өдөр “Цахим гэмт хэрэг” сэдвээр нийт 56 албан хаагчдыг хамруулан зохион байгуулсан.

2. Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын албан хаагчдад зориулсан албан бус сургалтыг 2025 оны 05 дугаар сарын 28-ны өдөр зохион байгуулж 67 албан хаагч хамрагдсан.
3. Хуулийн төсөл боловсруулагч бэлтгэх сургалт



Эдийн засаг хөгжлийн яамны “Хууль зүйн техник: хуулийн төсөл боловсруулах арга зүй” гэрээ сэдэвт Дугаар №ЭЗХЯ/20250203096 тендэрийн дагуу тус яамны албан хаагчдад зориулсан сургалтыг “Хуулийн төслийн хэлэлцүүлэг зохион байгуулж, олон нийтээс санал авч боловсронгуй болгох” мэдлэг олгох зорилгын хүрээнд зохион байгууллаа.

Сургалтад 33 ажилтан албан хаагч хамрагдсан. Үүнээс 3 хуульч албан хаагч

байсан ба хуульчийн үргэлжилсэн сургалтад 2025 оны 2 багц цагийг олгосон.



Долоо. Сургалтын хорооны 2025 онд шийдвэрлэсэн албан бичгийн тоо мэдээ

Сургалтын багц цаг тооцуулах, чөлөөлүүлэх, түүнтэй холбоотой бусад хүсэлтүүд нийт 282 хүсэлт хүлээн авч шийдвэрлэсэн байна.

ХУУЛЬЧДЫН ЭРХ, ХУУЛЬ ЁСНЫ АШИГ СОНИРХЛЫГ ХАМГААЛАХ ХОРОО

Нэг. Хуульчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлын хорооны гишүүдийн хурал

Хуульчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах хорооны хурлыг 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдөр зохион байгуулсан. Тус хурлаар Хуульчдын нийгэмд гүйцэтгэх үүрэг, оролцоо сэдвийн илтгэлийн уралдааныг дүгнэх асуудлыг хэлэлцсэн.

Хоёр. Албан бичиг төлөвлөлтийн хүрээнд:

Авилгатай тэмцэх газар, феделитас хуулийн фирм, хуульчдаас ирүүлсэн хуульчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах хорооноос албан бичиг төлөвлөн хүргүүлэн ажилласан.

Гурав. Хэлэлцүүлэг, илтгэлийн уралдаан, өглөөний уулзалт зохион байгуулах ажлын хүрээнд

“Хуульчдын нийгэмд гүйцэтгэх үүрэг, оролцоо” сэдэвт илтгэлийн уралдааныг зохион байгуулсан.

Монголын Хуульчдын холбооны Хуульчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах хорооноос хууль зүйн их, дээд сургуулийн оюутнуудын дунд “Хуульчдын нийгэмд гүйцэтгэх үүрэг, оролцоо” сэдэвт илтгэлийн уралдааныг хоёр үе шаттайгаар зохион байгууллаа. Илтгэлийн уралдааны эхний шатны шалгаруулалтыг 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдөр, эцсийн шатны шалгаруулалтыг 2025 оны 06 дугаар сарын 09-ний өдөр зохион байгуулж, шилдгүүдийг тодруулсан.

Илтгэлийн уралдааны тэргүүн байранд МУИС-ийн Хууль зүйн сургуулийн оюутан Б.Бямбажаргал, дэд байранд МУИС-ийн Хууль зүйн сургуулийн оюутан Б.Оюунтунгалаг, гуравдугаар байранд МУИС-ийн Хууль зүйн сургуулийн оюутан М.Баяржаргал, Б. Азаяа, тусгай байранд МУИС-ийн Хууль зүйн сургуулийн оюутан Б.Өсөхбаяр, Б.Мөнхцэцэг нар тус тус шалгарсан. Тус тэмцээний шүүгчээр Хуульчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах хорооны дарга Ш.Алтангадас, гишүүн Ш.Нарантуяа, Ц.Мөнхбат, Ц.Амарсанаа, П.Эрхэмбаяр нар ажилласан.



Өглөөний уулзалт

Монголын Хуульчдын холбооны Хуульчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах хорооноос санаачлан Хуульчдын өдөрт зориулан “Холбон тоглогч” өглөөний уулзалтыг 2025 оны 06 сарын 20-ны өдөр зохион байгуулсан. Илтгэгчээр Улсын Их Хурлын гишүүн О.Номинчимэг, Х.Баасанжаргал, чиглүүлэгчээр Хуульчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах хорооны дарга Ш.Алтангадас оролцсон.

Иргэний шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн эрх зүйн орчинг боловсронгуй болгох нь сэдэвт хэлэлцүүлэгт оролцсон.

Хариуцсан 3 хорооноос О.Чулуунцэцэг, Э.Энэбиш, Б.Алтаншагай, С.Батбуян гишүүдэд мэдээллийг танилцуулж оролцуулах ажлыг зохион байгуулсан.

Захиргааны эрх зүйн нэгдмэл байдал, чиг хандлага, шийдэл сэдэвт хэлэлцүүлэгт оролцсон.

2025 оны 03 дугаар сарын 21-ний өдөр Хуульчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах хорооноос Ч.Өнөржаргал, О.Чулуунцэцэг, Ц.Амарсанаа нар оролцсон.

Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийн хэлэлцүүлэгт хороог төлөөлөн гишүүн О.Чулуунцэцэг төлөөлөн оролцож санал, дүгнэлт гаргаж оролцсон.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны ил тод байдал, хэрэгжүүлэх арга зам хэлэлцүүлэгт хороог төлөөлөн Ч.Өнөржаргал, О.Чулуунцэцэг, Н.Ганболд гишүүд хороог төлөөлөн оролцож санал дүгнэлт гаргаж оролцов.

Монголын Хуульчдын холбоо байгуулагдсаны 12 жилийн ойг тохиолдуулан Монголын Хуульчдын холбооны Ерөнхийлөгчийн нэрэмжит Шатрын аварга шалгаруулах тэмцээнийг 2025 оны 09 дүгээр сарын 14-ний өдөр нийт хуульчдын дунд зохион байгуулсан. Оюуны спортыг түгээн дэлгэрүүлэх, ур чадварыг хөгжүүлэх, туршлага солилцох зорилгоор зохион байгуулсан тус тэмцээнд Монголын Хуульчдын холбооны 12 хорооны 36 тамирчин оюун ухаан, ур чадвараа сорин өрсөлдсөнөөс дараах амжилтыг үзүүлсэн. Үүнд:

🏆 Нэгдүгээр байр-Хууль зүйн шинжлэх ухаан, боловсролын хөгжлийг дэмжих асуудал эрхэлсэн хорооны баг тамирчин Ц.Мөнхбат, Т.Баярсайхан, Р.Энхтүвшин,

🏆 Хоёрдугаар байр-Иргэний эрх зүйн хорооны баг тамирчин М.Мөнгөнхүү, Т.Сайнбаяр, Б.Ургамалцэцэг,

🏆 Гуравдугаар байр-Хуульчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах хорооны баг тамирчин Б.Дамба, Ч.Булган, Ц.Нарантуяа,

🏆 Дөрөвдүгээр байр-Нотариатын хөгжлийг дэмжих хорооны баг тамирчин Д.Алтанхуяг, Б.Ганболор, С.Анударь,

🏆 Тавдугаар байр- Шүүгчдийн хорооны баг тамирчин Ч.Алдар, А.Зүмбэрэл, Э.Энхжаргал,

🏆 Шилдэг ахмад шатарчин- хуульч Ч.Булган,

🏆 Шилдэг эмэгтэй шатарчин- хуульч, нотариатч С.Анударь,

🏆 Ширээний аварга шатарчин- хуульч Ц.Мөнхбат, М.Мөнгөнхүү, Б.Ургамалцэцэг,

🏆 Рейтингүй шилдэг шатарчин- хуульч Ж.Тэгшмандал нар тус тус шалгарлаа.



Тэмцээний үеэр Монголын Хуульчдын холбооны Хүндэт тэмдгээр хуульч Б.Чинбаатар, Д.Ганхөлөг, Т.Цэнд-Аюуш нарыг шагнасныг Ерөнхийлөгч П.Одгэрэл, Тамгын газрын дарга Ш.Жолбарс, Хууль зүйн шинжлэх ухаан, боловсролын хөгжлийг дэмжих хорооны дарга Ц.Мөнхбат, Иргэний эрх зүйн хорооны Тэргүүн Г.Даваадорж, Эвлэрүүлэн зуучлалыг дэмжих хорооны Тэргүүн Д.Түмэнжаргал, Нотариатын хөгжлийг дэмжих хорооны тэргүүн Ч.Баянжаргал нар гардуулан өгсөн.

Шүүхийн төсвийн талаарх постер бэлдэж сайтад баршуулсан.



1. "...Сангийн сайд бусад төрийн захиргааны байгууллагын төвшинд шүүхийг авч үзэж тэдэнтэй адил шалгуураар шүүхийн төсвийг танана гэж үзэж байгаа нь Үндсэн хуулийн суурь зарчмын талаар ямар ч ойлголтгүйг харуулж байна. Нөгөө талаар шүүх эрх мэдэл нь Засгийн газрын нэг сайдаас гуйж эрх хэмжээгээ хэрэгжүүлэх нөхцөлөө бүрдүүлэх хэмжээнд байгаад байж болохгүй. Төсвийн тухай хуулиар ч шүүх эрх мэдлийн төсвийг бараг 90 орчим хувиар танах бололцоог олгоогүй.

Ер нь цаашид үндсэн хуулийн байгууллагын төсөвт хувь хүнээс хамааралтайгаар гар хүрдэг байдлыг засахгүй бол үеийн үед Монгол Улсын шүүн таслах тогтолцоо Сангийн сайдын үзэгний үзүүрт дэнжгэнэж болохгүй...”

Монголын Хуульчдын холбооны Зөвлөлийн гишүүн, Хуульчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах хорооны дарга Ш.Алтангадас

Гэр бүлийн эрх зүйн асуудлаар хамтарсан хэлэлцүүлэгт оролцлоо

Монголын Хуульчдын холбоо, Хууль зүй, дотоод хэргийн яам, Олон улсын Улаанбаатарын их сургуулийн Монгол-Солонгосын эрх зүйн хүрээлэнгээс санаачлан БНСУ-ын Хувийн эрх зүй судлалын нийгэмлэг, Олон Улсын хөгжлийн эрх зүйн байгууллага (IDLO)-тай хамтран “Монгол-Солонгосын гэр бүлийн эрх зүй, гэр бүлийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт” сэдэвт хамтарсан хэлэлцүүлгийг өнөөдөр зохион байгуулсан. Тус хэлэлцүүлэгт хорооноос О.Чулуунцэцэг өмгөөлөгч төлөөлж оролцсон.

“Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гэрч, хохирогчийг хамгаалах тогтолцоог бэхжүүлэх нь” сэдэвт хэлэлцүүлэгт оролцно.

Монголын Хуульчдын холбооны Хуульчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах хорооны гишүүд нь мэргэжлийн байгууллагаас зохион байгуулж буй хэлэлцүүлэгт тогтмол оролцдог бөгөөд энэхүү хэлэлцүүлэгт хороог төлөөлөн О.Чулуунцэцэг, П.Эрхэмбаяр хуульчид оролцохоор болсон.

ХУУЛЬ ЗҮЙН СУРГУУЛИЙГ МАГАДЛАН ИТГЭМЖЛЭХ АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ХОРОО

Нэг. Төлөвлөгөөнд тусгасан ажлын хүрээнд

Монголын Хуульчдын холбооны 2025 оны ерөнхий төлөвлөгөөний 6.3-т заасан Монгол Улсын Боловсролын ерөнхий хуулийн 17.14-д заасны дагуу МХХ-ны магадлан итгэмжлэл хийх комиссын магадлан итгэмжлэх эрхийг авах ажлын хүрээнд:

- 1.1. Монголын Хуульчдын холбооны хууль зүйн сургуулийг магадлан итгэмжлэх эрхийг хэрэгжүүлэх үүднээс Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэлтэй Холбооны Ерөнхийлөгч П.Одгэрэл, хорооны дарга Х.Сэлэнгэ, Тамгын газрын дарга Ш.Жолбарс нар 2025 оны 02 дугаар сарын 12-нд уулзалт зохион байгуулж, Монгол Улсын Боловсролын тухай хууль болон Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлэх арга хэмжээний асуудлыг хэлэлцсэн.
- 1.2. Хууль зүй, дотоод хэргийн яамны Сургалт, сурталчилгаа, хөтөлбөрийн хэрэгжилтийн газрын дарга Г.Эрдэнэбулгантай хамтран Боловсрол, шинжлэх ухааны сайд Д.Наранбаяр болон Магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн албан тушаалтнуудтай 02 дугаар сарын 14-ний өдөр уулзалт зохион байгуулж, холбогдох дүрэм, журмыг сайжруулж, комиссын дүрмийг батлуулах арга хэмжээний асуудлыг хэлэлцэж, МХХ-ны хууль зүйн сургуулийг магадлан итгэмжлэх комиссын дүрмийг батлуулахаар өгсөн.
- 1.3. Боловсрол, шинжлэх ухааны яамны Магадлан итгэмжлэлийн үндэсний төвийн захирал Б.Амарсанаа болон төлөөллүүдтэй 03 дугаар сарын 11-ний өдөр хорооны дарга Х.Сэлэнгэ болон Тамгын газрын дарга Ш.Жолбарс нар уулзалт зохион байгуулсан. Уг уулзалтаар Магадлан итгэмжлэлийн үндэсний зөвлөлөөс н.Ганзаяа, н.Мөнхтулга 2 ажилтан, Хуульчдын холбооноос Х.Сэлэнгэ профессорыг оролцуулсан баг бүрдүүлэн, ерөнхий журам болох бусад актууд дээр хамтарч санал боловсруулах болсон. Магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийн магадлан итгэмжлэх дүрэм, журмыг сайжруулан боловсруулан БШУЯ-д хүргүүлж, дараа дараагийн эрх зүйн актуудыг хамтран боловсруулж ойрын хугацаанд Боловсролын ерөнхий журам шинэчлэгдсэний дараа Хуульчдын холбооны магадлан итгэмжлэх комиссын дүрмийг батлуулахаар тохирч, тулгарч буй асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар санал солилцсон.



1.4. 2025 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр Хууль зүй, дотоод хэргийн яам, Боловсролын яамны Магадлан итгэмжлэлийн үндэсний зөвлөлийн төлөөлөлүүдтэй Хууль зүйн сургуулиудыг магадлан итгэмжлэх асуудал эрхэлсэн хорооны гишүүд "Мэргэжлийн болон техникийн, дээд боловсролыг сургалтын байгууллага болон хөтөлбөрийг магадлан итгэмжлэх, магадлан итгэмжлэл хийх журам", "Мэргэжлийн болон техникийн, дээд боловсролыг сургалтын байгууллага болон хөтөлбөрийг магадлан итгэмжлэл хийх шинжээчид тавих шаардлага"-ын төслийн хэлэлцүүлэг зохион байгуулж, санал солилцсон.



1.5. 2025.05.22-ны өдөр 2/513 дугаар албан бичгээр Хууль зүйн сургуулийг магадлан итгэмжлэх хорооноос "Мэргэжлийн болон техникийн, дээд боловсролыг сургалтын байгууллага болон хөтөлбөрийг магадлан итгэмжлэх, магадлан итгэмжлэл хийх журам", "Мэргэжлийн болон техникийн, дээд боловсролыг сургалтын байгууллага болон хөтөлбөрийг магадлан итгэмжлэл хийх шинжээчид тавих шаардлага"-ын төсөлд санал боловсруулан Боловсролын сайд П.Наранбаярт хүргүүлсэн.

Хоёр. Хорооны хурал

2.1. Хууль зүйн сургуулийг магадлан итгэмжлэх асуудал эрхэлсэн хороо 2025 оны 01 дүгээр сарын 21-ний өдөр хуралдсан. Хурал нийт 12 гишүүнээс 6 гишүүний ирцтэй хуралдсанаас 6 гишүүн танхимаар оролцсон. Тус хурлаар дараах асуудлыг хэлэлцсэн. Үүнд:

1.Монгол улс дахь Эрх зүйн боловсролын шинэчлэлийн үе шатны бодлогыг тодорхойлох асуудал


2.Монгол улс дахь “Эрх зүйн боловсролын шинэчлэл” (Эрх зүйчээс гадна хуульч бэлтгэх, магадлан итгэмжлэх) төслийг хэрэгжүүлэх тухай

3.МХХ –ны шинэ байрны ажилд хандив цуглуулах тухай

Тус хурлаар Монгол улс дахь Эрх зүйн боловсролын шинэчлэлийн үе шатны бодлогыг тодорхойлж, “Эрх зүйн боловсролын шинэчлэл” –ийн төслийг хэрэгжүүлэх комиссыг 7 гишүүнтэй байгуулсан. Хорооны гишүүд бүр Зөвлөл болон бусад хороо байсан ч 1 удаа заавал холбооны шинэ байранд хандив өгөхөөр шийдвэрлэсэн.

2.2. Хууль зүйн сургуулийг магадлан итгэмжлэх асуудал эрхэлсэн хорооны ээлжит хурал 2025 оны 12 дугаар сарын 06-ны өдөр хуралдсан. Хурал нийт 12 гишүүнээс 8 гишүүний ирцтэй хуралдсанаас 6 гишүүн цахимаар, 2 гишүүн бичгээр санал өгч оролцсон. Тус хурлаар дараах асуудлыг хэлэлцсэн.

1. 2025 оны ажлын төлөвлөгөөний хэрэгжилт, тайлан
2. 2026 оны ажлын төлөвлөгөөний төсөл



Гурав. Эрх зүйн боловсрол, ухамсарыг дээшлүүлэх ажлын хүрээнд:



3.1. Эрх зүйн боловсролын шинэчлэлийн үе шатны бодлогын төслийг боловсруулж, Хууль зүй дотоод хэргийн яаманд хүргүүлсэн.

3.2. “Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дэмжих 2026–2028 оны үндэсний төлөвлөгөө” -ний төслийг боловсруулж, 2025 оны 10 дугаар сарын 20-нд Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлсэн болно.

ХУУЛЬ ЗҮЙН ШИНЖЛЭХ УХААН, БОЛОВСРОЛЫН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ХОРОО

1. Хууль зүйн шинжлэх ухаан, боловсролын хөгжлийг дэмжих асуудал эрхэлсэн хорооны зохион байгуулалтын ажлын хүрээнд:

Иргэний эрх зүйн хороо, Өмгөөллийн “Легал гайд” ХХК-тай хамтран Монголын Хуульчдын холбооны Ерөнхийлөгчийн нэрэмжит иргэний хэргийн шүүхийн мэтгэлцээний “Цахим шүүх-Mock trial 2025” тэмцээнийг 2025 оны зургадугаар сарын 07-ны өдөр зохион байгууллаа. Тус тэмцээнд Монголын Хуульчдын холбооны Хууль зүйн шинжлэх ухаан, боловсролын хөгжлийг дэмжих асуудал эрхэлсэн хорооны дарга, доктор, профессор Ц.Мөнхбат хамтран оролцож шагнал гардуулах үйл ажиллагаанд оролцсон. Тус тэмцээн нь шүүх эрх мэдлийн байгууллагуудын цахимжилтын энэ үед цахим хэлбэрээр, мөн анхан болон давж заалдах шүүхэд иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар зохион байгуулагдсан онцлогтой болсон.

Оюутнууд энэ хугацаанд цахим хавтаст хэргээ судлахын зэрэгцээ онлайнаар шүүх хуралдаанд оролцох өрөө танхим, техник хэрэгслээ бэлтгэж мэтгэлцээндээ оролцсон. Зохион байгуулагчдын хувьд шүүх эрх мэдлийн байгууллагын цахимжилтын үйл явцыг дэмжихийн зэрэгцээ иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхүүдийн оролцоог хангахын тулд Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүх, Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхүүд дээр анхан шатны цахим шүүх хуралдааныг нэгэн зэрэг зохион байгууллаа.



Иргэний хэргийн шүүхийн мэтгэлцээний “Цахим шүүх-Mock Trial 2025” тэмцээнийг 2025 оны зургадугаар сарын 07-ны өдөр ZOOM платформ дээр нээж, мэтгэлцээний зургаан тоглолт нэгэн зэрэг, хоёр тойргийн шүүх дээр явагдсан.

Тэмцээний финалын шатанд Санхүү, эдийн засгийн их сургуулийн “Акси” баг, Монгол Улсын их сургуулийн Хууль зүйн сургуулийн “Эгүнэ” болон “Веритас” багууд шалгарч, давж заалдах шатны шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар, тойргийн зарчмаар хоёр хэргээр Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхэд танхимаар мэтгэлцсэн.

Анх удаа цахимаар зохион байгуулсан “Цахим шүүх-Mock Trial 2025” тэмцээний:

- 🏆 Тэргүүн байранд Монгол Улсын их сургуулийн Хууль зүйн сургуулийн “Веритас” баг шалгарч алтан медаль, өргөмжлөл, 3,000,000 төгрөгөөр;

- 🥈 Дэд байранд Монгол Улсын их сургуулийн Хууль зүйн сургуулийн “Эгүнэ” баг шалгарч, мөнгөн медаль, өргөмжлөл, 2,000,000 төгрөгөөр;

- 🥉 Гувдугаар байранд Санхүү, эдийн засгийн их сургуулийн “Акси” баг шалгарч, хүрэл медаль, өргөмжлөл, 1,000,000 төгрөгөөр тус тус шагнагдав.



1.2 Монголын Хуульчдын холбооноос Нийслэлийн Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны тойргийн шүүхтэй хамтран Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүрэгт шүүх байгуулагдсаны 60 жилийн ойд зориулан Монголын Хуульчдын холбооны Ерөнхийлөгчийн нэрэмжит Эрүүгийн хэргийн “Мок триал” шүүхийн мэтгэлцээний тэмцээнийг 2025 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр 10 дахь жилдээ Эрүүгийн эрх зүйн болон Шүүгчдийн хороотой хамтран зохион байгууллаа.



Тэмцээний нээлтийн үйл ажиллагаанд Монголын хуульчдын холбооны ерөнхийлөгч П.Одгэрэл, Хууль зүйн шинжлэх ухаан боловсролын хөгжлийг дэмжих асуудал эрхэлсэн хорооны дарга Ц.Мөнхбат оролцсон.

Тус тэмцээнд Монгол Улсын Их Сургууль, Дотоод хэргийн их сургууль, Шихихутаг, Их засаг их сургуулийн Хууль зүйн сургууль, Санхүү эдийн засгийн их сургууль, Олон улсын Улаанбаатар их сургууль, Глобал удирдагч их сургууль,

Отгонтэнгэр их сургууль, Зохиомж дээд сургууль гэсэн 10 сургуулийн 15 баг өрсөлдөж Шихихутуг их сургууль амжилттай өрсөлждөж тэргүүн болон дэд байр эзэлсэн бол Их засаг ХЗС гурав дугаар байр эзэлсэн байна.



2. Санамж бичиг байгуулах ажлын хүрээнд:

Монголын Хуульчдын холбоо, Шүүхийн академи, Монголын мэтгэлцээний нэгдсэн танхим хамтран ажиллах санамж бичиг байгуулж, Монголын Хуульчдын Холбооны Тамгын газрын дарга Ш.Жолбарс, Шүүхийн академийн захирал Д.Эрдэнэчимэг, Монголын мэтгэлцээний нэгдсэн танхимын дэд тэргүүн Б.Наранцэцэг нар өнөөдөр гарын үсэг зурж баталгаажууллаа. Хамтын ажиллагааны хүрээнд талууд шүүхийн мэтгэлцээний сургалт, семинар, сургалтын хөтөлбөр боловсруулах, зохион байгуулах, мэтгэлцээний дасгалжуулагч багш нарыг бэлтгэх, сургах, чадавхжуулах ажлыг хэрэгжүүлэх юм. Мөн шүүхийн мэтгэлцээнээр хичээллэгч оюутнуудад зориулсан сургалт, тэмцээн, үйл ажиллагааг зохион байгуулна. Түүнчлэн оюутнуудыг шүүхийн үйл ажиллагааны талаарх мэдлэгтэй, мэргэжлийн ур чадвартай боловсон хүчин болгон бэлтгэхэд хамтран ажиллах, хамтарсан судалгаа, төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхээр тохиролцсон. Тус хамтын ажиллагааны хүрээнд талууд нь шүүхийн мэтгэлцээний дасгалжуулагч багшийн сургалт, шүүхийн мэтгэлцээнээр хичээллэгч оюутнуудын сургалтыг 2025 оны тавдугаар сарын 06, 07-ны өдрүүдэд зохион байгуулав.



Хууль зүйн шинжлэх ухааны боловсролын хөгжлийг дэмжих асуудал эрхэлсэн хорооны санаачлагаар Монголын Хуульчдын холбоо нь Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Биеийн тамир, спортын улсын хороотой 2025 оны 11 сарын 19-ний өдөр хамтран ажиллах санамж бичиг байгуулсан. Санамж бичгийн зорилго нь хуулиар олгосон эрх хэмжээний хүрээнд талууд тэгш эрхэд үндэслэн биеийн тамир, спортыг хөгжүүлэн дэмжих, эрдэм шинжилгээ, сургалт, судалгааны чиглэлээр үр дүнтэй хамтарч ажиллах, хамтын үйл ажиллагааг хөгжүүлэхэд оршино.

3. Хуульч, эрдэмтэн, судлаач, хуульчдын дунд эрдэм шинжилгээний болон онол практикийн хурал, хэлэлцүүлэг зохион байгуулж үр дүнг тооцох ажлын хүрээнд:

3.1. Монголын Хуульчдын холбооны Прокурорын хороо, Улсын ерөнхий прокурорын газрын дэргэдэх Сургалт, судалгааны хүрээлэн хамтран **“Хүний эрх, эрх чөлөөг хамгаалахад мэдээллийн технологийн дэвшлийг ашиглах нь”** сэдэвт оюутны эрдэм шинжилгээний илтгэлийн уралдааныг хоёр үе шаттайгаар зохион байгуулсан.



Илтгэлийн уралдааны шалгаруулалт 2025 оны тавдугаар сарын 20-ны өдөр Улсын ерөнхий прокурорын дэргэдэх Сургалт, судалгааны хүрээлэнгийн сургалтын танхимд болж, шүүгчдээр Хууль зүйн шинжлэх ухаан, боловсролын хөгжлийг дэмжих асуудал эрхэлсэн хорооны дарга, доктор, профессор Ц.Мөнхбат, УЕПГ-ын дэргэдэх Сургалт, судалгааны хүрээлэнгийн Сургалтын албаны дарга, ахлах прокурор О.Алтангэрэл болон УЕПГ-ын дэргэдэх Сургалт, судалгааны хүрээлэнгийн Судалгааны албаны дарга, ахлах прокурор Б.Мөнхдорж нар ажиллаж дараах оролцогчид шилдгээр шалгарсан. Үүнд:

🏆 Тэргүүн байр: Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн оюутан Г.Анхзаяа, Г.Болор нарын “Мэдээлэл, технологийн дэвшлийг ашиглан хөгжлийн бэрхшээлтэй хүний хууль, шүүхийн байгууллагад хандах, үйлчилгээг тэгш хүртээмжтэй авах эрхийг хангах нь” илтгэл,

🏆 Дэд байр: Дотоод хэргийн их сургуулийн оюутан О.Номин-Эрдэнийн “Бага насны хүүхдээс мэдүүлэг авах ажиллагаан дахь хүүхдийн эрхийг хамгаалахад хиймэл оюун ухаан ашиглах боломж” илтгэл,

🏆 Гутгаар байр: Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн Э.Жавзмаа, Т.Анужин нарын “Хяналтын техник хэрэгсэл (цахим гав)-г ашиглан зорчих эрхийг хязгаарлах ял болон хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээний эрх зүйн орчныг боловсронгуй болгох нь” илтгэл,

🏆 Тусгай байр: мөн сургуулийн А.Сумъяабэйс, Н.Түшиг нарын “Эрүүгийн хэрэг мөрдөн шалгах ажиллагаанд техник, технологийн дэвшлийг ашиглах нь: Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэмт хэргийн газарт үзлэг хийх жишээн дээр” сэдэвт илтгэл тус тус шалгарч, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнагдлаа.

3.2. Монголын Хуульчдын холбооны Хууль зүйн шинжлэх ухаан, боловсролын хөгжлийг дэмжих хорооноос ““Олон улсын гэрээний эрх зүйн онол дахь давхар татварын гэрээний байр суурь ба эрх зүйн шинж”” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлыг 2025 оны 12 дугаар сарын 03-ны өдөр зохион байгууллаа. Олон Улсын гэрээний эрх зүйн онолд тулгуурлан давхар татварын гэрээний эрх зүйн байр суурь, хэрэгжилтийн онцлогийг онол, практикийн уялдаанд



шинжилгээ хийж, Монгол Улсын татварын эрх зүйн бодлогыг олон улсын стандарт, хамтын ажиллагааны жишигт нийцүүлэхэд чиглэсэн шинэлэг эрх зүйн дүгнэлт, зөвлөмж гаргах зорилгоор зохион байгуулж буй юм. Илтгэгчээр: С.Сүхбаатар, доктор, профессор “Давхар татварын талаарх НҮБ болон ЭЗХАХБ-ын загвар гэрээний ялгаа, Монгол Улсын бусад улстай байгуулсан гэрээ”, И.Энхбаяр докторант, ахлах багш “Давхар татварын гэрээ”, Р.Мөнхдулам магистр, судлаач “Олон улсын давхар татварын гэрээний эрх

зүйн зохицуулалт, Эрдэнэт Төрийн өмчит үйлдвэрийн газрын жишээн дээр” тус тус сэдвээр илтгэлт хэлэлцүүлсэн.



3.3. Хууль зүйн шинжлэх ухаан, боловсролын хөгжлийг дэмжих хорооноос “Үндсэн хуулийн хэрэглээний онол, арга зүй ба орчин үе” сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлыг 2025 оны 10 дугаар сарын 31-ний өдөр зохион байгуулахаар төлөвлөж илтгэл ирүүлэхээр байсан 5 хүн нь цаг үеийн асуудлаас болж илтгэлээ хугацаандаа ирүүлээгүй тул тус эрдэм шинжилгээний бага хурлыг тодорхойгүй хугацаагаар хойшлуулсан болно. Одоо нийт 7 хуульч, судлаачдаас илтгэл ирүүлсэн байгаа. Үндсэн

хуулийн процессын эрх зүйн онолын суурь үзэл баримтлал, арга зүйн ондоошил, судалгааны чиг хандлагын харьцуулсан судалгааны үндсэн дээр Үндсэн хуулийн хэрэглээний онол, арга зүй, шинжлэх ухаан, практикийн асуудал, Үндсэн хуулийн маргааныг хянан шийдвэрлэж буй нөхцөл байдлыг тодорхойлох, үнэлэлт өгөх, цаашид Үндсэн хууль хэрэглэх онол, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болох зорилгоор зохион байгуулах юм.

4. Хуульчдын холбооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, оролцох хамтран ажиллах чиглэлийн хүрээнд:



4.1. Монголын Хуульчдын холбооны Ерөнхийлөгчийн нэрэмжит Шатрын аварга шалгаруулах тэмцээнийг 2025 оны 09 дүгээр сарын 14-ний өдөр нийт хуульчдын дунд зохион байгууллаа. Оюуны спортыг түгээн дэлгэрүүлэх, ур чадварыг хөгжүүлэх, туршлага солилцох зорилгоор зохион байгуулсан тус тэмцээнд холбооны 12 хорооны 36 тамирчин оюун ухаан, ур чадвараа сорин өрсөлдсөнөөс дараах амжилтыг үзүүллээ. Үүнд:

🏆 Нэгдүгээр байр-Хууль зүйн шинжлэх ухаан, боловсролын хөгжлийг дэмжих асуудал

эрхэлсэн хорооны баг тамирчин Ц.Мөнхбат, Т.Баярсайхан, Р.Энхтүвшин

🥈 Хоёрдугаар байр-Иргэний эрх зүйн хорооны баг тамирчин М.Мөнгөнхүү, Т.Сайнбаяр, Б.Ургамалцэцэг

🥉 Гуравдугаар байр-Хуульчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах хорооны баг тамирчин Б.Дамба, Ч.Булган, Ц.Нарантуяа

🥈 Дөрөвдүгээр байр-Нотариатын хөгжлийг дэмжих хорооны баг тамирчин Д.Алтанхуяг, Б.Ганболор, С.Анударь

🥉 Тавдугаар байр- Шүүгчдийн хорооны баг тамирчин Ч.Алдар, А.Зүмбэрэл, Э.Энхжаргал

👤 Шилдэг ахмад шатарчин- хуульч Ч.Булган

👤 Шилдэг эмэгтэй шатарчин- хуульч, нотариатч С.Анударь

👤 Ширээний аварга шатарчин- хуульч Ц.Мөнхбат, М.Мөнгөнхүү, Б.Ургамалцэцэг,

👤 Рейтингүй шилдэг шатарчин- хуульч Ж.Тэгшмандал нар тус тус шалгарлаа.



Тэмцээний үеэр Монголын Хуульчдын холбооны Хүндэт тэмдгээр хуульч Б.Чинбаатар, Д.Ганхөлөг, Т.Цэнд-Аюуш нарыг шагнасныг Монголын Хуульчдын холбооны Ерөнхийлөгч П.Одгэрэл, Тамгын газрын дарга Ш.Жолбарс, Хууль зүйн шинжлэх ухаан, боловсролын хөгжлийг дэмжих хорооны дарга Ц.Мөнхбат, Иргэний эрх зүйн хорооны Тэргүүн Г.Даваадорж, Эвлэрүүлэн зуучлалыг дэмжих хорооны Тэргүүн Д.Түмэнжаргал, Нотариатын хөгжлийг дэмжих хорооны тэргүүн Ч.Баянжаргал нар гардуулан өгсөн.

4.2 Хуульч профессор ажиллуулах журмыг боловсруулж, батламж олгох арга хэмжээг зохион байгуулах ажлын хүрээнд “Хуульч Профессор” нэршил хэрэглэх эрхийн батламж, түүнийг олгох, түүнд тавигдах шаардлага, шалгуур үзүүлэлтийг тогтоож хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах журмыг боловсруулж Монголын Хуульчдын холбооны Сайн дур болон Чиг үүргийн хороод, Монголын Хуульчдын холбооны Удирдах зөвлөлд санал авахаар явуулж, журмыг боловсруулах ажил явагдаж байна.

Бусад ажлын хүрээнд:

4.3 2025 оны 10 дугаар сарын 05-ны өдөр Монголын Нотариатчдын Танхимын нэрэмжит хуулийн төв байгууллагуудын дунд жил бүр зохион байгууллагддаг шатрын тэмцээн “Хуульчдын ордон”-д болж, өндөрлөлөө.



хамтран зохион байгууллаа.

Шатрын тэмцээнд Хуулийн төв байгууллагын 20 багийн 80 тамирчид оролцож, шилдгүүдээ тодрууллаа.

4.4.Б.Чимид багшийн нэрэмжит шатрын тэмцээнийг Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс санаачлан 2024 оны 02 дугаар сарын 08-ны өдөр зохион байгуулсан. Тус тэмцээнд хорооны дарга Ц.Мөнхбат оролцсон.

4.5 .Тагнуулын ерөнхий газрын нэрэмжит Хуулийн байгууллагуудын аварга шалгаруулах “Шатар”-ын тэмцээнийг 2025 оны 03 дугаар сарын 09-ний өдөр зохион байгуулагдах уг тэмцээнд оролцох Монголын Хуульчдын холбооноос 1 баг тамирчдыг бүрдүүлж оролцсон.



төлөөлөн Хууль зүйн шинжлэх ухаан, боловсролын хөгжлийг дэмжих асуудал эрхэлсэн хорооноос баг бүрдүүлж оролцов.

4.6. Монголын Хуульчдын холбооны гишүүн Т.Азжаргалын “ҮНДСЭН ХУУЛИЙН АМИН СҮНС: ХАРИУЦЛАГА, ОНОЛ, ҮЗЭЛ БАРИМТЛАЛ, ХЭРЭГЛЭЭ” номын нээлтийн үйл ажиллагаа 2025 оны 11 дүгээр сарны 24-ний өдөр зохион байгууллаа. Уг үйл ажиллагааг хороо дэмжин ажиллав.

4.7. 2025 оны 11 дугаар сарын 26-ны өдөр Шихихутуг их сургуулийн хуулийн төв байгууллагуудын дундах шатрын тэмцээнд Монголын Хуульчдын холбоог

ҮНДСЭН ХУУЛИЙН ЭРХ ЗҮЙН ХОРОО

Хэлэлцүүлэг, уулзалт зохион байгуулах ажлын хүрээнд:

Үндсэн Хуулийн эрх зүйн хороо, Өмгөөлөгчдийн хорооноос санаачлан Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа, Монголын Өмгөөлөгчдийн холбоо, Монголын Криминологичдын холбоотой хамтран өмгөөлөгч нарын дунд **“Эрүү шүүлтгүй Монгол Улс-Өмгөөлөгчийн оролцоо”** сэдэвт өглөөний уулзалтыг зохион байгуулсан.

Уулзалтад Монголын Хуульчдын холбооны Үндсэн хуулийн эрх зүйн хорооны тэргүүн, Ш.Цогтоо, ХЭҮК-ын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн Я.Цэлмэн, Өмгөөлөгчдийн холбооны Ерөнхийлөгч Л.Данзанноров, Монголын Криминологичдын холбооны тэргүүн Б.Батзориг, Шихихутуг их сургуулийн дэргэдэх, Харьцуулсан эрх зүйн судалгааны хүрээлэнгийн захирал Т.Мөнх-Эрдэнэ, Үндсэн хуулийн эрх зүйн хорооны Удирдах зөвлөлийн гишүүн Ч.Өнөржаргал нар болон хуульч, өмгөөлөгч, эрдэмтэн, судлаачдын төлөөлөл оролцсон

Өглөөний уулзалтад Монголын Криминологичдын холбооноос “Эрүүдэн шүүх гэмт явдлын шалтгаан нөхцөлийг тогтоох” судалгааны дүнг танилцуулсан бөгөөд тус судалгаа нь анх удаа хийгдэж байгаа учир өмгөөлөгч, хууль нарыг өөрсдийн үзэл санаа, зөвлөмжөө идэвхтэй өгч хамтран ажиллахыг уриалсан.



Хуульчид хууль зүй, дотоод хэргийн сайдтай өглөөний уулзалт зохион байгууллаа

Үндсэн хуулийн эрх зүйн хороо, Хуульчдын клуб хамтран 2025 дөрөвдүгээр сарын 01-ний өдөр өглөөний уулзалт зохион байгууллаа. Энэ удаагийн уулзалтын зочноор Хууль зүй, дотоод хэргийн сайд О.Алтангэрэл оролцож, хууль зүйн бодлого болон Хууль зүй, дотоод хэргийн яамны үйл ажиллагааг танилцуулж, хуульчдын сонирхсон асуултад хариулт өгсөн. Тус уулзалтын чиглүүлэгчээр Монголын Хуульчдын холбооны Үндсэн хуулийн эрх зүйн хорооны Удирдах зөвлөлийн гишүүн, өмгөөлөгч Ч.Өнөржаргал ажилласан.

Уулзалтын үеэр Хууль зүй, дотоод хэргийн сайдын зүгээс 2025 оны хаврын чуулганаар хэлэлцэх Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн шинэчилсэн найруулга зэрэг хуулийн төслүүдийн талаар мэдээлэл өгч, хуульчдыг санаачилга гаргаад Монголын Хуульчдын холбоогоороо дамжуулан хуулийн төсөл болон хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах саналаа уламжилбал дэмжиж ажиллах болно гэдгээ илэрхийлсэн.

Монголын Хуульчдын холбооноос Хууль зүй, дотоод хэргийн сайдад хандан хууль хэрэглээний нэгдмэл байдлыг бий болгох зорилгоор тус яамны харьяа газар, агентлагуудын удирдлагуудыг оролцуулсан өглөөний уулзалтыг сар бүр тогтмол зохион байгуулж, хуульчидтай мэдээлэл солилцож байхыг хүссэн бөгөөд энэхүү санаачилгыг дэмжиж ажиллахаар болсон.





Монголын Хуульчдын холбооны Хууль зүйн шинжлэх ухаан, боловсролын хөгжлийг дэмжих хорооноос **“Үндсэн хуулийн хэрэглээний онол, арга зүй ба орчин үе”** сэдэвт эрдэм шинжилгээний бага хурлыг 2025 оны 10 дугаар сарын 31-ний өдөр зохион байгууллаа.

Үндсэн хуулийн процессын эрх зүйн онолын суурь үзэл баримтлал, арга зүйн ондоошил, судалгааны чиг хандлагын харьцуулсан судалгааны үндсэн дээр Үндсэн хуулийн хэрэглээний онол, арга зүй, шинжлэх ухаан, практикийн асуудал, Үндсэн хуулийн маргааныг хянан шийдвэрлэж буй нөхцөл байдлыг тодорхойлох, үнэлэлт өгөх, цаашид Үндсэн хууль хэрэглэх онол, эрх зүйн

зохицуулалтыг боловсронгуй болох зорилгоор зохион байгуулж буй тус эрдэм шинжилгээний бага хуралд Хууль зүйн их сургуулийн эрдэмтэн, судлаачид, хуульчид, хууль зүйн салбарын мэргэжилтэн, ахисан түвшний сургалтын хөтөлбөрт суралцагсад оролцов.

ШҮҮГЧДИЙН ХОРОО

Нэг. Шүүгчдийн хорооны Удирдах зөвлөлийн хурал зохион байгуулах

Шүүгчдийн хорооны удирдах зөвлөлийн хурлыг 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдөр зохион байгуулсан. Хорооны хурлыг цахимаар зохион байгуулсан бөгөөд Хуульчийн мэргэжлийн шалгалтын асуудал эрхэлсэн хорооноос ирүүлсэн албан бичгийн дагуу Шүүгчдийн хороонд бүртгэлтэй 130 шүүгчдэд мэдээлэл хүргэж ажилласан бөгөөд нийт 8 шүүгчдээс оролцох саналаа ирүүлсэнийг хэлэлцсэн. Түүнээс 3 шүүгчийн нэрийг зохион байгуулалтын комисст ажиллахаар хүргүүлсэн бөгөөд шалгалтын хороо Т.Жавхлантөгс, Т.Ганчимэг 2 шүүгчийг сонгон ажиллуулахаар болсон.

Хоёр. Хэлэлцүүлэг зохион байгуулах ажлын хүрээнд:



Эрүүгийн эрх зүйн хороо, Прокурорын хороо, Шүүгчдийн хороо, Өмгөөлөгчдийн хороо хамтран **“Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцүүлгийг** 2025 оны 03 дугаар сарын 13-ны өдөр зохион байгууллаа. Хэлэлцүүлгийг Монголын Хуульчдын холбооны Ерөнхийлөгч П.Одгэрэл нээж, тус хуулийн төсөлтэй холбоотой өөрийн саналыг хуваалцсан. Тус хэлэлцүүлэгт Улсын Их хурлын гишүүн Х.Тэмүүжин оролцож, Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн танилцуулгыг хийсэн бөгөөд эрүүгийн хариуцлагатай холбоотой зохицуулалтыг ял, албадлагын арга хэмжээ болгож өөрчлөх болон худал мэдээлэл тараах, мөрдөн шалгах ажиллагааны нууцыг задруулах гэмт хэргийн шинжийг өөрчлөх талаар

мэдээлэлдээ дурдсан.

Тус хэлэлцүүлгийн чиглүүлэгчээр Хуульчдын холбооны Судалгааны төвийн эрхлэгч Г.Оюунболд, хэлэлцүүлэгчээр Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин, Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны тойргийн шүүхийн шүүгч Л.Галбадар, Улсын Ерөнхий Прокурорын газрын дэргэдэх Сургалт, судалгааны хүрээлэнгийн Сургалтын албаны дарга, ахлах прокурор, О.Алтангэрэл, МУИС-ийн ХЗС-ийн Нийтийн эрх зүйн тэнхимийн багш, доктор, дэд профессор Т.Золбоо, Монголын Хуульчдын холбооны гишүүн хуульч, өмгөөлөгч Б.Мэргэн нар оролцож хуулийн төслийн талаар санал солилцсон. Монголын Хуульчдын холбооны гишүүн шүүгч, прокурор, өмгөөлөгч, бусад хуульчид болон иргэдийн

төлөөлөл болсон нийт 68 хүн тус хэлэлцүүлэгт оролцож санал, шүүмжээ хуваалцсан бөгөөд Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа судалгаа, шинжилгээнд үндэслэж, шинжлэх ухаанчаар хандах, хуулийн үзэл баримтлалыг алдагдуулахгүйгээр ардчилсан нийгмийн үнэт зүйлийг хамгаалах алхмаас ухрахгүй байхад анхаарах талаар тодорхой байр суурийг илэрхийлсэн.



Монголын Хуульчдын холбооноос санаачлан УИХ-ын Тамгын газрын дэргэдэх Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэн, Улсын бүртгэлийн Ерөнхий газар, Захиргааны эрх зүйн хороотой хамтран **“Хуулийн этгээдийн бүртгэлийн эрх зүйн зохицуулалт, тулгамдаж буй асуудал”** сэдэвт хэлэлцүүлгийг 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр зохион байгуулсан. Хэлэлцүүлгийг Монголын Хуульчдын холбооны Ерөнхийлөгч П.Одгэрэл, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Тамгын газрын дарга Д.Давааням нар нээж үг хэлсэн.

Хэлэлцүүлгийн хүрээнд Улсын бүртгэлийн ерөнхий газрын ахлах бүртгэгч Б.Лхагвасүрэн “Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн эрх зүйн зохицуулалт, тулгамдаж буй асуудал” сэдвээр илтгэл хэлэлцүүлж, улсын бүртгэлийн гэрчилгээ болон тамга, тэмдгийн хяналтын дугаар дахин олгох, тамга, тэмдэг алдагдсан, тамга тэмдгийг хүлээлгэн өгөхгүй байгаа үйлдэл, эс үйлдэхүйн талаар мэдээлэл өгсөн бол “Грандлекс партнерс” ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Халиунаа “Компанийн улсын бүртгэлийн тулгамдсан асуудал. /Харьцуулсан эрх зүй/” сэдвүүдээр илтгэл тавьсан.

Илтгэлийн дараа панел хэлэлцүүлэг явуулсан бөгөөд чиглүүлэгчээр Монголын Хуульчдын холбооны Тамгын газрын дарга Ш.Жолбарс, панелистаар Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Д.Халиуна, “Грандлекс партнерс” ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Халиунаа, ХЭУБГ-ын дарга Ж.Аюуш, Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн Судалгааны хэлтсийн ахлах референт О.Нарантуяа нар оролцсон. Тус хэлэлцүүлэгт Нийслэл дэх Захиргааны хэргийн шүүх, УИХ-ын Тамгын газрын дэргэдэх Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэн, Улсын Ерөнхий Прокурорын газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газрын төлөөлөл болон Монголын Хуульчдын холбооны гишүүн хуульч, өмгөөлөгчид оролцож хуулийн этгээдийн бүртгэлийн эрх зүйн зохицуулалтад тулгамдаж буй асуудлуудын талаар санал солилцож, цаашид эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох талаар зөвлөмж боловсруулан холбогдох байгууллагад хүргүүлэхээр болсон.



Монголын Хуульчдын холбоо, Нээлттэй нийгэм форум хамтран **“Шүүхийн захиргааны үндсэн чиг үүрэг, түүний хэрэгжилт”** сэдэвт хэлэлцүүлгийг өнөөдөр салбарын мэргэжилтнүүд болон хуульчдын дунд зохион байгуулсан. Хэлэлцүүлгийг Монголын Хуульчдын холбооны Ерөнхийлөгч П.Одгэрэл нээж үг хэлсэн бөгөөд Шүүхийн Ерөнхий зөвлөлийн шүүгч бус гишүүдийн сонгон шалгаруулалт томилгооны үйл явц өрнөж буй энэ чухал цаг үед шийдвэр гаргагчид болон салбарын оролцогчдод Шүүхийн ерөнхий зөвлөлийн үндсэн чиг үүргийн талаар мэдээлэл өгөх, тулгамдаж буй асуудлыг тодорхойлж, цаашид анхаарал

шийдвэрлэх асуудлын талаар мэргэжилтнүүд санаа бодлоо солилцох боломжоор хангах зорилгоор энэхүү хэлэлцүүлгийг зохион байгуулж байгаа нь ач холбогдолтой болохыг онцолсон.

Хэлэлцүүлгийн хүрээнд “Оюуны Инноваци” ТББ-ын судлаач П.Баттулга “Шүүгчийн сонгон шалгаруулалт” сэдвээр илтгэл тавьж, панел хэлэлцүүлгийг “Оюуны Инноваци” ТББ-ын судлаач Б.Төрболд чиглүүлж, хэлэлцүүлэгчээр Шүүхийн Ерөнхий зөвлөлийн гишүүн Н.Баасанжав, Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч Т.Мөнх-Эрдэнэ,

Шүүхийн академийн захирал Д.Эрдэнэчимэг, “Legaldata”-ийн захирал, хуульч, судлаач П.Баттулга нар оролцсон. Итгэгчийн зүгээс хэлэлцүүлгийн үеэр “Шүүгчийн сонгон шалгаруулалтын зорилго нь шүүхэд хамгийн сайн шаардлага хангасан нэр дэвшигчийг олж илрүүлэх, хамгийн өндөр зэрэглэлийн шүүгчийг томилоход оршино. Иймд шалгуур хангаагүй дээр биш, шалгуур хангасан дээр төвлөрөх нь эрэл хайгуулын эн тэргүүний зорилт болно” гэдгийг онцлоод, шүүгчид нэр дэвшигчдээс бичгийн шалгалт авдаг байдлаа өөрчлөөд шинэ арга, хэлбэр нэвтрүүлэх хэрэгцээ шаардлага байгааг дурдсан.

Дараагийн панел хэлэлцүүлэг “Шүүхийн нөөц, төсөв төлөвлөлт” сэдвийн хүрээнд үргэлжилсэн бөгөөд чиглүүлэгчээр “Нээлттэй нийгэм форум”-ийн Эрх зүйн хөтөлбөрийн менежер П.Бадамрагчаа, илтгэгчээр “Хууль эрх зүйн хөгжлийн хүрээлэн” ТББ-ийн судлаач Ж.Алтансүх, хэлэлцүүлэгчээр хуульч судлаач Отгончимэг, Ж.Алтансүх, С.Билгүүн нар оролцсон. Энэхүү хэлэлцүүлгээр шүүхийн нөөц, төсөв төлөвлөлтийн талаарх судалгааны тайланг танилцуулж, цаашид шүүхийн төсвийг гүйцэтгэлд суурилсан шүүхийн санхүүжилт олгох талаар судлах, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж Шүүхийн дэд бүтэц, хөрөнгө оруулалтыг дэмжих санг улсын тэмдэгтийн хураамж болон шүүхийн тусгай архивын үйлчилгээний орлогоос санхүүжүүлэх, Шүүхийн цахимжилтыг нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлэх, нийслэл болон орон нутгийн шүүгчийн ажлын ачааллыг тэнцвэржүүлэх хэрэгцээ шаардлага байгааг онцолсон.

Эрүүгийн хэргийн шүүхийн мэтгэлцээний тэмцээний техникийн зөвлөгөөний хурлыг зохион байгууллаа

Эрүүгийн эрх зүйн хороо, Шүүгчдийн хорооноос Нийслэлийн Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны тойргийн шүүхтэй хамтран Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүрэгт шүүх байгуулагдсаны 60 жилийн ойд зориулан Эрүүгийн хэргийн Мок триал шүүхийн мэтгэлцээний тэмцээнийг 2025 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр зохион байгуулсан.

Монголын Хуульчдын холбооны Ерөнхийлөгчийн нэрэмжит тус тэмцээнд МУИС-ийн Хууль зүйн сургууль, Санхүү эдийн засгийн их сургууль, Дотоод хэргийн их сургууль, "Рояль" Олон Улсын их сургууль, Олон Улсын "Улаанбаатар" их сургууль, "Глобал удирдагч" их сургууль, "Шихихутуг" их сургууль, "Зохиомж" их сургууль, "Их засаг" Олон Улсын их сургууль, "Отгонтэнгэр" их сургуулийн 15 баг өрсөлдөхөөр мэдүүлгээ ирүүлсэн. Тус тэмцээний техникийн зөвлөгөөн өнөөдөр болж, багуудын оноолтыг хийж, мандатыг олгож, эрүүгийн хэргийн материалтай холбоотой нэмэлт тодруулгыг өгсөн бөгөөд техникийн зөвлөгөөнд 15 багийг хариуцсан багш нар болон багийн ахлагч, төлөөлөгчид оролцсон.



Эрүүгийн хэргийн шүүхийн мэтгэлцээний тэмцээнийг хамтран зохион байгууллаа

Хуульчдын холбооноос Нийслэлийн Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны тойргийн шүүхтэй хамтран Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй

дүүрэгт шүүх байгуулагдсаны 60 жилийн ойд зориулан Эрүүгийн хэргийн “Мок триал” шүүхийн мэтгэлцээний тэмцээнийг 2025 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр зохион байгуулсан.

Монголын Хуульчдын холбооны Ерөнхийлөгчийн нэрэмжит тус тэмцээнийг 10 дахь жилдээ зохион байгуулж байгаа бөгөөд энэ удаагийн тэмцээнд МУИС-ийн Хууль зүйн сургууль, Санхүү эдийн засгийн их сургууль, Дотоод хэргийн их сургууль, "Рояаль" Олон Улсын их сургууль, Олон Улсын "Улаанбаатар" их сургууль, "Глобал удирдагч" их сургууль, "Шихихутуг" их сургууль, "Зохиомж" их сургууль, "Их засаг" Олон Улсын их сургууль, "Отгонтэнгэр" их сургуулийн 15 баг өрсөлдсөн. Үүнээс тэмцээнийн Тэргүүн байрыг "Шихихутуг" их сургуулийн Б.Бат-Ерөөлт, Б.Мөнх-Эрдэнэ багштай "Шихихутуг баг", Дэд байрыг "Шихихутуг" их сургуулийн Б.Бат-Ерөөлт, Б.Мөнх-Эрдэнэ багштай "Их зарагч" баг, Гуравдугаар байрыг "Их Засаг" их сургуулийн Ж.Баасанжав багштай "Дэнс" баг, Тусгай байрыг Олон Улсын Улаанбаатарын их сургуулийн П.Анхмаа багштай "Legal eagle's" багууд тус тус эзэлж, амжилттай оролцсон.

Мөн шилдэг илтгэгчдээр:

- МУИС-ийн Хууль зүйн сургуулийн "Цэгц" багийн оюутан М.Энхжин
- Олон Улсын Улаанбаатарын их сургуулийн "Legal eagle's" багийн оюутан Б.Номин;
- "Шихихутуг" их сургуулийн "Шихихутуг" багийн оюутан Х.Хонгорзул нар шалгарсан.



Гурав. Уулзалтад оролцсон ажлын хүрээнд:

Солонгосын Хууль зүйн судалгааны хүрээлэнгийн төлөөлөгчидтэй уулзалтад оролцлоо



БНСУ-ын Хууль зүйн судалгааны хүрээлэнгийн Ерөнхийлөгч Хан Ён Сү тэргүүтэй төлөөлөгчид 2025 оны 05 дугаар сарын 12-16-ны өдрүүдэд Монголд зочилсон.Төлөөлөгчдийг Монголын Хуульчдын холбооны Тамгын газрын дарга Ш.Жолбарс өчигдөр хүлээн авч уулзлаа. Уулзалтад Монголын Хуульчдын холбооны Шүүгчдийн хорооны тэргүүн, Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч С.Энхбаяр, Судалгааны төвийн эрхлэгч Г.Оюунболд, Гадаад харилцааны зөвлөх Ц.Одонжав, Монгол-

Солонгосын эрх зүйн хүрээлэнгийн Захирал О.Амарсанаа нар оролцсон. Монголын Хуульчдын холбоо нь БНСУ-ы Хууль зүйн судалгааны хүрээлэнтэй байгуулсан хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд харилцан илтгэл тавих, хамтарсан эрдэм шинжилгээний хурал зохион байгуулах зэрэг ажлуудыг өнгөрсөн хугацаанд хэрэгжүүлсэн бөгөөд 2025 онд хууль эрх зүйн олон талт судалгааны ажлуудад харилцан дэмжлэг үзүүлэх болон зочин судлаачийн хөтөлбөр хэрэгжүүлэхээр тохиролцсон. Тус айчллын хүрээнд “Хиймэл оюун ухаан ба хууль эрх зүй” сэдэвт эрдэм шинжилгээний хурлыг 2025 оны тавдугаар сарын 14-ний өдөр зохион байгууллаа.

Дөрөв. Про-боно өдөрлөг зохион байгуулах ажлын хүрээнд:

Монголын Хуульчдын холбооны Ерөнхийлөгчийн тушаалаар жил бүрийн тавдугаар сарын 01-ний өдрийг “Хуульчийн про боно өдөр” болсон зарласан. Энэ жил Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай хамтран “Хуульчийн про боно өдөр”-ийг долоо дахь жилдээ зохион байгуулсан бөгөөд өнөөдөр Сүхбаатарын талбай болон 21 аймгийн төв талбай, Нийслэлийн нэгдсэн үйлчилгээ төв, алслагдсан хороод, тойргийн шүүх, хялбар ажиллагааны шүүхийн гадна талбайд “Хуульчийн про боно-2025” өдөрлөгийг зохион байгуулсан бөгөөд Шүүгчдийн хороо шүүхийн байруудад зөвлөгөө өгөх ажлын хариуцан зохион байгуулсан.

Хуульчдын холбооны Ерөнхийлөгчийн нэрэмжит Шатрын аварга шалгаруулах тэмцээнийг 2025 оны 09 дүгээр сарын 14-ний өдөр нийт хуульчдын дунд зохион байгуулсан. Оюуны спортыг түгээн дэлгэрүүлэх, ур чадварыг хөгжүүлэх, туршлага солилцох зорилгоор зохион байгуулсан тус тэмцээнд Шүүгчдийн хорооны баг тамирчид оролцлоо.

1. Шүүхийн төсвийн талаарх постер бэлдэж сайтад баршуулсан.



1. Шүүх бол хэмнэлтийн золиос биш. Шүүхийн төсөв багасах юм бол хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа удааширч, иргэдэд шударга ёсыг хүртэхэд илүү их зардал, цаг хугацаа, золиос шаардагдана..."



2. "...Иргэний амь нас, эрүүл мэнд, өмч хөрөнгийн маргааныг шийдэж үйлчилгээ үзүүлдэг байгууллага болох Шүүхийн төсвийг танах нь иргэдийн халаасруу шууд гар дүрэхтэй агаар нэг..."



3. "...Шүүхийн төсвийн зарцуулалт илт үр ашиггүй, илүүдэлтэй бол танах асуудал яригдаж болно. Илүүдэл байтугай батлагдсан төсөв нь хүрэлцэхгүй олон жил аргацаасан. Гэтэл хууль зөрчиж шүүхийн төсвийг бууруулах нь шүүхийн хуулиар хүлээн үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх чадвараа хадгалах эдийн засгийн баталгааг алдагдуулахаас гадна шүүхийн үйлчилгээг иргэдэд доголдолгүй хүргэхэд томоохон эрсдэл учруулна. Үүний хохирогч нь шүүхийн үйлчилгээг авч буй иргэн..."



4. "...ХЭҮК УИХ-ын баталсан Хүний эрхийг хангах тухай тогтоолуудыг хэрэгжүүлэхээр ажиллаж байгаа. Мөн саяхан УИХ-ын тогтоолуудыг хэрэгжүүлэх үүднээс Эрүүгийн процессын хууль болон холбогдох хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулаад байна. Гэтэл ЗГ-ын ШЕЗ-ийн төсвийг 20 хувь, УДШ-ийн төсвийг 14 хувь, ХЭҮК-ийн төсвийг 18,2 хувиар хасах саналыг гаргаж байгаад харамсалтай байна. Иймд УИХ гишүүдийг ЗГ-ын хуулийн байгууллагуудад хамаарах саналыг дэмжихгүй байхыг уриалж байна..."



5. "...Хувийн өмчийг хамгаалах, хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх-шүүх засаглал. ШЕЗ нь төсвөө Сангийн яам, УИХ-аар тануулах нь харилцан хяналт тавих, тэнцвэртэй байх зарчмыг алдагдуулж, шүүхийн хараат бус байдалд халдаж буй үйлдэл юм. Шүүх дээр овоорсон хэдэн зуун хэргүүд хүний эрхийн хамгийн том зөрчил болж байна..."



6. "...Үндсэн хуулиар төрийн эрх мэдлийг хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх гэж эн тэнцүү гурван салаанд хуваасан. Шүүхийн төсөв гэдэг бол шүүх эрх мэдлийн үйл ажиллагааны цусан хангамж бөгөөд энэ агуулгаараа дан ганц шүүхэд зориулсан мөнгө биш, шүүхээс шударга ёсны төлөө үйлчилгээ авч байгаа бүх хүнд хамаатай юм. Тиймээс шүүхийн төсвийг ямар нэг бодитой үндэслэлгүйгээр танахгүй байх үүргийг төр хүлээдэг..."

ПРОКУРОРЫН ХОРОО

Нэг. Прокурорын хууль ёсны эрх, эрх ашгийг хамгаалах ажлын хүрээнд

Монгол Улсад хүний эрх, эрх чөлөөг хамгаалах хуулиар хүлээсэн үүргээ нэр төртэй биелүүлж, хуульчийн нэр хүндийг өндөрт өргөн ажилласан Улсын ерөнхий прокурорын туслах прокурор, ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавих хэлтсийн дарга Д.Энхтөр, Улсын ерөнхий прокурорын газрын Шүүхэд төрийг төлөөлөх хэлтсийн Төр, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах албаны дарга, ахлах прокурор Д.Сарантуяа, Тээврийн прокурорын газрын ахлах прокурор Ч.Энхтуяа нарыг Монголын Хуульчдын холбооны Ерөнхийлөгчийн 2025 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 70 дугаар тушаалаар Монголын Хуульчдын холбооны хүндэт тэмдгээр шагнагдсан.

Хоёр. Зохион байгуулалтын ажлын хүрээнд

2.1. Хуульчдын холбооноос хэрэгжүүлж буй сургалт, судалгааны төсөл, хөтөлбөрт прокуроруудыг ажил мэргэжлийн дагуу оролцуулж, хамтран ажиллах чиглэлээр:



Монголын Хуульчдын холбооноос жил бүрийн 05 дугаар сарын 01-ний өдрийг "Хуульчийн Про боно" өдөр болгон тэмдэглэн өнгөрүүлсээр ирсэн. Энэ жилийн про боно өдрийг угтаж Нийслэл болон 21 аймгийн Ерөнхий боловсролын 8-11 дүгээр ангийн сурагчдад "Цахим орчны зохистой хэрэглээ" сэдвээр нийт 72 сургуулийн 7906 сурагчид сургалт зохион байгууллаа. Сургалтаар гэмт хэргийн тухай ойлголт, цахим гэмт хэрэг, түүний хохирогч болохоос урьдчилан сэргийлэх болон цахим донтолын талаар сурагчдад таниулан, мэдээлэл өгсөн.

Хуульчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх ажлын хүрээнд тус сургалтад сургагч багшаар дүүрэг, орон нутгийн Прокурорын газрын прокурорууд ажилласан. Хуульч, өмгөөлөгч, улсын өмгөөлөгч, 21 аймгийн салбарын зохицуулагч нарт болон сургалтын хөтөлбөр боловсруулах, сургагч багш бэлтгэхэд Улсын ерөнхий прокурорын газрын дэргэдэх Сургалт, судалгааны хүрээлэнгийн хяналтын прокурор, доктор, дэд профессор Б.Өнөрмаа, Прокурорын хорооны тэргүүн Ж.Болорпүрэв нар хамтран ажилласан.

2.2. Оюутнуудын дунд Прокурорын байгууллагын үйл ажиллагаа, прокурорын хяналтын онцлогийг таниулан сурталчлах зорилгоор илтгэлийн уралдааныг зохион байгуулах чиглэлээр:

Монгол Улсад прокурорын байгууллага үүсэж хөгжсөний түүхт 95 жилийн ойг тохиолдуулан их, дээд сургуулийн оюутнуудын дунд хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдөхөөс сэргийлэх, зөрчигдсөн эрхийг сэргээх үйл ажиллагаанд мэдээллийн технологийн дэвшил, хиймэл оюун ухаан, их өгөгдлийг ашиглах талаар эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх оюутнуудын санал, санаачилгыг дэмжих, тэдэнд хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа, прокурорын хяналтын ажлын онцлогийг таниулах зорилгоор Тус хорооноос Улсын ерөнхий прокурорын газрын дэргэдэх Сургалт, судалгааны хүрээлэнтэй хамтран **“Хүний эрх, эрх чөлөөг хамгаалахад мэдээллийн технологийн дэвшлийг ашиглах нь”** сэдэвт оюутны эрдэм шинжилгээний хурлыг хоёр үе шаттайгаар зохион байгуулсан. Тус эрдэм шинжилгээний илтгэлийн уралдаанд МУИС-ийн Хууль зүйн сургууль, Дотоод хэргийн их сургууль, Санхүү, эдийн засгийн их сургууль, Шихихутуг их сургууль, Их засаг Олон улсын их сургууль, Олон Улсын Улаанбаатар их сургуулийн нийт 41 оюутнаас 27 илтгэл ирүүлсэн.

- Тэргүүн байранд Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуулийн оюутан Г.Анхзаяа, Г.Болор нарын “Мэдээлэл, технологийн дэвшлийг ашиглан хөгжлийн бэрхшээлтэй хүний хууль, шүүхийн байгууллагад хандах, үйлчилгээг тэгш хүртээмжтэй авах эрхийг хангах нь” илтгэл,
- Дэд байранд Дотоод хэргийн их сургуулийн оюутан О.Номин-Эрдэнийн “Бага насны хүүхдээс мэдүүлэг авах ажиллагаан дахь хүүхдийн эрхийг хамгаалахад хиймэл оюун ухаан ашиглах боломж” илтгэл,
- Гуравдугаар байранд Монгол Улсын Их сургуулийн Хууль зүйн сургуулийн Э.Жавзмаа, Т.Анужин нарын “Хяналтын техник хэрэгсэл (цахим гав)-г ашиглан зорчих эрхийг хязгаарлах ял болон хязгаарлалт тогтоох таслан сэргийлэх арга хэмжээний эрх зүйн орчныг боловсронгуй болгох нь” илтгэл, тусгай байранд мөн сургуулийн А.Сумъяабэйс, Н.Түшиг нарын “Эрүүгийн хэрэг мөрдөн шалгах ажиллагаанд техник, технологийн дэвшлийг ашиглах нь: Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих гэмт хэргийн газарт үзлэг хийх жишээн дээр” сэдэвт илтгэл тус тус шалгарч, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнагдлаа.



Мөн хоёрдугаар шатанд Дотоод хэргийн их сургуулийн оюутан Б.Оюун-Эрдэнэ, Б.Цэцэгжаргал нар “Монгол Улсын Прокурорын байгууллага хиймэл оюун ухаан ашиглах боломж, шийдэл, хүний эрхийн асуудал”, “Их засаг” олон улсын их сургуулийн Хууль зүйн сургуулийн оюутан Г.Ган-Од “Хорих ял эдлүүлэх ажиллагаанд тавих прокурорын хяналтад хиймэл оюун ухааныг ашиглах нь”, “Шихихутуг” их сургуулийн оюутан Д.Баянжаргал, Б.Содчимэг нар “Мэдээллийн технологиор дамжуулан цахим орчинд хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, тулгарах асуудлыг шийдвэрлэх”,

Олон Улсын “Улаанбаатар” их сургуулийн Хууль зүйн сургуулийн оюутан Э.Хулан “Цахим нотлох баримт ба хүний эрхийн хамгаалалт” сэдвээр илтгэлээ амжилттай хэлэлцүүлсэн.

2.3. Хууль зүйн салбарт тулгамдсан асуудал, судалгааны үр дүнд үндэслэн хурал, хэлэлцүүлэг, семинар зэрэг арга хэмжээг зохион байгуулах чиглэлээр:

Улсын ерөнхий прокурорын газрын дэргэдэх Сургалт, судалгааны хүрээлэн, Дотоод хэргийн их сургууль, Үндсэн хуулийн цэцийн Судалгааны төв, Улсын Их Хурлын Тамгын газрын Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэн, Цагдаагийн ерөнхий газрын Кибер гэмт хэрэгтэй тэмцэх газар, “Суурийн Жанцан сан” төрийн бус байгууллагатай хамтран **“Цахим гэмт**

хэргийн криминологийн чиг хандлага” сэдэвт эрдэм шинжилгээний хурлыг 2025 оны 05 дугаар сарын 09-ний өдөр зохион байгуулсан. Энэ хурлыг зохион байгуулахад Прокурорын хороо, гишүүд идэвхтэй оролцож ажилласан.

Цахим арга, хэлбэрээр болон цахим хэрэгсэл ашиглан үйлдэж буй гэмт хэргийн хуулийн зохицуулалт, төлөв байдал, криминологи шинж, урьдчилан сэргийлэх арга зүйг тодорхойлох, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын онол, практикийн нэгдлийг хангах, хуульч, эрдэмтэн, судлаач, мэргэжилтнүүдийн алба хаагчдын шинжлэх ухаанч санал, дүгнэлтийг хэлэлцүүлэх зорилгоор байгуулж буй тус эрдэм шинжилгээний хуралд хууль зүйн салбарын 60 орчим хуульч, профессор багш, эрдэмтэн, судлаач, мэргэжилтэн оролцсон.

Тус эрдэм шинжилгээний хуралд хуульч, эрдэмтэн, судлаачдаас нийт 30 гаруй илтгэл ирүүлснээс

- “Суурийн Жанцан судлал (Бүтээлийн үнэ цэн), Монголын криминологийн хөгжилд оруулсан хувь нэмэр” сэдвээр Монголын Криминологичдын холбооны Удирдах зөвлөлийн дарга, Дотоод хэргийн их сургуулийн Гэмт явдал судлалын профессорын судалгааны багийн профессор, хууль зүйн ухааны доктор, профессор Б.Батзориг,
- “Цахим хэрэгсэл ашиглаж үйлдсэн гэмт хэргийг илрүүлэхэд хиймэл оюун ухаан ашиглах нь” сэдвээр Авлигатай тэмцэх газрын Хэлтсийн дарга, эрхэлсэн комиссар, хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор Р.Баярмагнай,
- “Цахим орчинд үйлдэгдэж буй зарим төрлийн гэмт хэргийг тодорхойлох асуудал” сэдвээр Дотоод хэргийн их сургуулийн Эрүүгийн процессын эрх зүйн тэнхимийн дэд профессор, хууль зүйн ухааны доктор Н.Сайнбаяр,
- “Цахим гэмт хэргийн нийтлэг шинж, эрх зүйн зохицуулалт” сэдвээр Үндсэн хуулийн цэцийн Тамгын газрын судлаач, Бээжингийн их сургуулийн докторант Д.Бадамханд,
- “Кибер орчинд үйлдэгдсэн гэмт хэргийн нөхцөл байдал, цаашдын чиг хандлага” сэдвээр Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн албаны Кибер гэмт хэрэгтэй тэмцэх газрын Тоон ул мөр илрүүлэх хэлтсийн дарга, цагдаагийн хошууч Б.Соронзонбаатар, “Цахим мөрийтэй тоглоомын криминологийн чиг хандлага: 1xbet” сэдвээр Монголбанкны дэргэдэх Санхүүгийн мэдээллийн албаны төлөөлөгч Г.Мягмарцэрэн, Б.Даваадэмбэрэл,
- “Кибер хүчирхийллийн тухай ойлголт, түүний зохицуулалт, криминологийн чиг хандлага: харьцуулсан судалгаа” сэдвээр Монголын Хуульчдын холбооны гишүүн хуульч, докторант М.Дэлгэржаргал,
- “Цахим гэмт хэрэг: Цахим нотлох баримтын ойлголт, олон улсын зохицуулалт, стандарт” сэдвээр Улсын ерөнхий прокурорын газрын дэргэдэх Сургалт, судалгааны хүрээлэнгийн хяналтын прокурор М.Сансарсайхан нар илтгэл хэлэлцүүлсэн байна.



Америкийн Нэгдсэн Улсын Конгрессын дэргэдэх “Олон улсын манлайллын төвөөс шүүхийн салбарт хэрэгжүүлдэг “Нээлттэй дэлхий” хөтөлбөрийн төгсөгчдийн анхдугаар хуралдаан манай улсад болсон.

Энэхүү хурлын илтгэгч нарыг оролцуулан АНУ-ын “Зочин илтгэгч” хөтөлбөрийн хүрээнд Монголын Хуульчдын холбооноос АНУ-ын Элчин сайдын яамтай хамтран “Хуульчдын орчин цагийн сургалтын арга зүй”, “АНУ дахь баривчлах, цагдан хорих албадлагын арга хэмжээний

онцлог” сэдэвт сургалт-хэлэлцүүлгүүдийг зохион байгууллаа.

“АНУ дахь баривчлах, цагдан хорих албадлагын арга хэмжээний онцлог” сэдэвт сургалт-хэлэлцүүлгийн илтгэгчээр АНУ-ын Холбооны шүүхийн шүүгч Сюзанна Митчелл, панелистаар Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны тойргийн шүүхийн шүүгч Л.Галбадар, “Хуульчдын орчин цагийн сургалтын арга зүй” Сургалт-хэлэлцүүлгийн илтгэгчээр АНУ-ын Холбооны Шүүхийн Дипломат албаны Гадаад харилцааны хэлтсийн захирал Мира Гур-Ари, панелистаар Монголын Хуульчдын холбооны Хуульчийн

үргэлжилсэн сургалтын асуудал эрхэлсэн хорооны дарга, доктор, дэд профессор Б.Өнөрмаа оролцсон.

Өнөөдрийн сургалт-хэлэлцүүлгээр АНУ-ын хууль зүйн боловсрол, насанд хүрэгчдийн боловсролын зарчмууд, Холбооны шүүхийн төвийн сургалтын онцлог болон мэргэжилтнүүд нь хэрхэн суралцдаг болоод АНУ дахь баривчлах, Цагдан хорих албадлагын арга хэмжээний онцлог, олон улсын практик туршлага, онолын ойлголтыг хуваалцаж, хэлэлцүүлэг өрнүүлсэн бөгөөд сургалтад Монголын Хуульчдын холбооны гишүүн шүүгч, прокурор, өмгөөлөгч, бусад хуульчдын төлөөлөл оролцсон байна.

Гурав. Хууль тогтоомж, эрх зүйн бусад эрх зүйн акт, баримт бичгийг боловсронгуй болгох ажлын хүрээнд:

3.1. Монголын Хуульчдын холбоонд эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас ирүүлсэн хууль тогтоомжийн төсөлд санал өгөх, эрх зүйн бусад акт, баримт бичгийн төсөл боловсруулахад оролцох чиглэлээр:

Эрүүгийн эрх зүйн хороо, Прокурорын хороо, Шүүгчдийн хороо, Өмгөөлөгчдийн хороо хамтран Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцүүлгийг 2025 оны 03 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулсан. Хэлэлцүүлгийг Монголын Хуульчдын холбооны Ерөнхийлөгч П.Одгэрэл нээж, тус хуулийн төсөлтэй холбоотой өөрийн саналыг хуваалцсан. Тус хэлэлцүүлэгт Улсын Их хурлын гишүүн Х.Тэмүүжин оролцож, Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн танилцуулгыг хийсэн бөгөөд эрүүгийн хариуцлагатай холбоотой зохицуулалтыг ял, албадлагын арга хэмжээ болгож өөрчлөх болон худал мэдээлэл тараах, мөрдөн шалгах ажиллагааны нууцыг задруулах гэмт хэргийн шинжийг өөрчлөх талаар мэдээлэлдээ дурдсан. Хэлэлцүүлгийн чиглүүлэгчээр Монголын Хуульчдын холбооны судалгааны төвийн эрхлэгч Г.Оюунболд, хэлэлцүүлэгчээр Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин, Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны тойргийн шүүхийн шүүгч Л.Галбадар, Улсын Ерөнхий Прокурорын газрын дэргэдэх Сургалт, судалгааны хүрээлэнгийн Сургалтын албаны дарга, ахлах прокурор, О.Алтангэрэл, Монгол улсын их сургуулийн хууль зүйн суруулийн Нийтийн эрх зүйн тэнхимийн багш, доктор, дэд профессор Т.Золбоо, Монголын Хуульчдын холбооны гишүүн хуульч, өмгөөлөгч Б.Мэргэн нар оролцож хуулийн төслийн талаар санал солилцлоо.



Монголын Хуульчдын холбооны гишүүн шүүгч, прокурор, өмгөөлөгч, бусад хуульчид болон иргэдийн төлөөлөл болсон нийт 68 хүн тус хэлэлцүүлэгт оролцож санал, шүүмжээ хуваалцсан бөгөөд Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа судалгаа, шинжилгээнд үндэслэж, шинжлэх ухаанчаар хандах, хуулийн үзэл баримтлалыг алдагдуулахгүйгээр ардчилсан нийгмийн үнэт зүйлийг хамгаалах алхмаас ухрахгүй байхад анхаарах талаар тодорхой байр суурийг илэрхийлсэн.

Дөрөв. Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хүрээнд:

Олон улсын Прокуроруудын холбооны зүүн Европ, Төв Азийн бүс нутгийн 10 дугаар хурал Монгол Улсын Нийслэл Улаанбаатар хотноо 2025 оны 06 дугаар сарын 05, 06-ны өдрүүдэд зохион байгуулагдлаа. Тус хуралд АНУ, Англи, Канад, Австрали, Румын, Хятад, Турк, Казакстан, Азербайжан, Саудын Араб, Кувейт, Кени, Сингапур, Бүгд Найрамдах Солонгос Улс, Кувейт, Непал зэрэг 25 улсын прокурорын байгууллагын 100 гаруй төлөөлөл оролцож, “Прокурорын үүрэг оролцооны хувьсал: цахим орчин дахь гэмт хэрэгтэй тэмцэх сорилтууд, сайн туршлага” сэдвээр нэгэн дор чууллаа.

Олон Улсын Прокуроруудын холбооны бүсийн хурлаар “Олон нийтийн сүлжээ ба гэмт хэргийн хувьсал, чиг хандлага”, “Цахим орчинд үйлдэгдэж буй хүүхдийн эсрэг гэмт хэрэгтэй

тэмцэх нь”, “Технологийн дэвшил, инновацыг гэмт хэрэгтэй тэмцэхэд ашиглах нь”, “Хүн худалдаалах гэмт хэрэг: Бүс нутгийн чиг хандлага, стратеги, хохирогчийг хамгаалах ажиллагаа” дөрвөн дэд сэдвийн хүрээнд 16 илтгэл хэлэлцүүлж, цахим орчин дахь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, сайн туршлагаа хуваалцлаа.

Монгол Улсад анх удаа зохион байгуулагдаж буй Олон Улсын Прокуроруудын холбооны Зүүн Европ, Төв Азийн 10 дугаар хурал нь бүс нутаг төдийгүй олон улсын өмнө тулгарч буй асуудлыг шийдвэрлэхэд прокурорын байгууллагуудын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх онцгой чухал ач холбогдолтой арга хэмжээ боллоо.



Монголын Хуульчдын холбоо, Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай хамтран Азийн про боно 13 дахь удаагийн чуулга уулзалтыг 2025 оны 10 дугаар сарын 03-ны өдрөөс 05-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулсан. Тус чуулга уулзалтанд аймаг, Нийслэлийн прокурорын газраас 30 гаруй прокурорыг оролцуулсан. Азийн про боно чуулга уулзалтаар “Олон салбарын оролцоотой про боно: өнгөрсөн, одоо, ирээдүй-Монголын туршлага” сэдэвт хэлэлцүүлэгт илтгэгчээр Улсын Ерөнхий прокурорын газрын дэргэдэх Сургалт, судалгааны хүрээлэнгийн прокурор, доктор, профессор Б.Өнөрмаа оролцсон.



Бусад үйл ажиллагаа

2025 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн “Цэвэр агаар-Эрүүл хуульч” өдөрлөгт прокурорын хороог төлөөлөн Төв аймгийн прокурорын газрын Хяналтын прокурор Б.Түмэндэмбэрэл, Төв аймгийн прокурорын газрны Хяналтын прокурор Б.Лувсанцэрэн, Төв аймгийн прокурорын газрын Хяналтын прокурор Ж.Мөнхзул, Төв аймгийн прокурорын газрын туслах ажилтан Ц.Ариунаа, Т.Хулан нар оролцсон.

Монголын Хуульчдын холбооноос жил бүрийн 05 дугаар сарын 01-ний өдөр зохион байгуулдаг “Хуульчийн Про боно-2025” өдөрлөгт аймаг, нийслэл, тээвэр, дүүргийн прокурорын газрын **100** орчим прокурор оролцож, иргэдэд хууль, эрх зүйн үнэ төлбөргүй зөвлөгөө, мэдээлэл өгч, гомдол, хүсэлтийг хүлээн авч ажиллаа.

Монголын Хуульчдын холбооны Хяналтын зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх саналыг ирүүлэх тухай албан бичгийг хүлээн авч хорооны Удирдах Зөвлөлийн гишүүдээр 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр хуралдан, Хяналтын зөвлөлд ажиллах прокуророор Улсын ерөнхий прокурорын газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Д.Чулуунбатыг нэр дэвшүүлж, холбогдох мэдээллийг Монголын Хуульчдын холбооны дүрэм, журамд нийцүүлэн холбоонд хүргүүлж ажилласан.


ЗАХИРГААНЫ ЭРХ ЗҮЙН ХОРОО

❖ Хорооны Удирдах зөвлөлийн хурал:

1. Захиргааны эрх зүйн хорооны удирдах зөвлөлийн ээлжит хурлыг 2025 оны 01 дүгээр сарын 09-ний өдөр зохион байгуулсан.

Хэлэлцсэн асуудлууд:

- Удирдах зөвлөлийн 3 гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсон, мөн 1 гишүүн хуульчийн эрхээ түдгэлзүүлсэн тул 4 гишүүний орон тоон дээр нөхөн сонгууль явуулахаар тогтов. Сонгуулийн нэр дэвшүүлэх ажлыг 2025 оны 01 дүгээр сарын 10-ны өдрөөс эхлэн 7 хоног, санал хураах ажиллалааг түүнээс хойш 5 хоног байхаар тогтсон.
- 2025 оны Хорооны үйл ажиллагааны төлөвлөгөөг хэлэлцэж, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд анхаарах асуудлуудыг ярилцсан.
- Бусад байгууллагатай байгуулсан хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд 2025 онд Хороо хэрхэн ажиллах талаар санал солилцож, багийн зохион байгуулалтад орж ажиллахаар тогтсон.
- 2025 онд хийгдэх подкастыг тухай бүр Удирдах зөвлөлийн гишүүд хариуцан идэвхжүүлж хийхээр санал нэгдсэн.
- Дараагийн хурлаар “Захиргааны эрх зүйчдийн өдөр” бий болгох, Хорооны бүх гишүүдийн хурлыг зохион байгуулах талаар хэлэлцэхээр шийдвэрлэсэн.



2. Захиргааны эрх зүйн хорооны Удирдах зөвлөл хуралдсан.

Захиргааны эрх зүйн хорооны Удирдах зөвлөлийн ээлжит бус хурал 2025 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр болсон. Тус хорооны гишүүн хуульчдаас хамгийн олон санал авч сонгогдсон шүүгч С.Оюунгэрэл, өмгөөлөгч Б.Анхбаяр, Б.Золзаяа, А.Түвшинтөгс нарыг хорооны Удирдах зөвлөлийн гишүүнээр батламжилсан. Мөн тус хорооны дэргэдэх Хүүхдийн эрхийн дэд хорооны зохицуулагч М.Хандармааг өөрийн гаргасан хүсэлтийг үндэслэн үүрэгт ажлаас нь чөлөөлсөн.

🔔 Хорооны Удирдах зөвлөлийн шинэчлэгдсэн бүрэлдэхүүн

3.Захиргааны эрх зүйн хорооны Удирдах зөвлөл хуралдсан.

Захиргааны эрх зүйн хорооны Удирдах зөвлөлийн ээлжит бус хурал 2025 оны 09 дүгээр сарын 10-ны өдөр цахим болон танхимаар хуралдсан. Тус хурлаар бүрэн эрхийн хугацаа нь дууссан гишүүдийг нөхөх сонгуулийн хугацааг товлох тухай /3 орон тоо/, 2025 оны төлөвлөгөөний хэрэгжилтийн байдал, 2026 оны төлөвлөгөөний тухай санал солилцох, Бусад /Азийн 13 дахь удаагийн пробоно чуулга уулзалтын талаар мэдээлэл, Холбооны ээлжит Их хурлын тухай, Хуульчийн мэргэжлийн шалгалтын тухай г.м/ асуудлуудыг хэлэлцсэн.

4.Захиргааны эрх зүйн хорооны Удирдах зөвлөл хуралдсан.

Захиргааны эрх зүйн хорооны Удирдах зөвлөлийн ээлжит бус хурал 2025.11.07-ны өдөр 17.30 цагт цахимгаар хуралдсан. Тус хурлаар сонгуулиар сонгогдсон 2 гишүүнийг /С.Халиунаа, Ч.Мөнхболор/ батламжилсан. 2026 оны төлөвлөгөөнд тусгах ажлын санал авахаар гишүүдэд мэдээллэх, 1 гишүүний дахин сонгох сонгууль явуулах талаар тус тус хэлэлцсэн.

❖ Нийтийн удирдлагын онол арга зүй, Захиргааны эрх зүйн онолыг хавсарган эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулах ажлын хүрээнд:

Захиргааны эрх зүйн хорооны цуврал өглөөний уулзалтуудыг зохион байгууллаа. Үүнд:

- “Миний дуртай захиргааны эрх зүй” цуврал уулзалт-1



Монголын Хуульчдын холбоо
Захиргааны эрх зүйн хороо

**МИНИЙ ДУРТАЙ
ЗАХИРГААНЫ ЭРХ ЗҮЙ**
цуврал уулзалт

Сэдэв:
**2024 ОНЫ ТАТВАРЫН
ТАЙЛАН: ХХОАТ-ЫГ
ТАЙЛАГНАХ НЬ**

Панелист:
Б.БАТТОГТОХ
Өмгөөллийн Арга партнерс ХХК-ийн
татварын өмгөөлөгч

2025.02.12
07.40

Чингис хааны музей
1 д давсарт,
Musa coffee shop

Захиргааны эрх зүйн хорооноос “Миний дуртай захиргааны эрх зүй” цуврал уулзалтын хүрээнд “2024 оны татварын тайлан: ХХОАТ-ыг тайлагнах нь” сэдэвт өглөөний уулзалтыг 2025 оны 02 дугаар сарын 12-ны өдөр зохион байгуулсан. Тус уулзалтын панелистаар Өмгөөллийн “Арга партнерс” ХХК-ийн татварын өмгөөлөгч, Захиргааны эрх зүйн хорооны Удирдах зөвлөлийн гишүүн Б.Баттогтох оролцов. Сэдвийн хүрээнд Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, Татварын ерөнхий хуульд заасан хувь хүний орлогын албан татварын тайлагналтай холбоотой суурь ойлголтууд, тайлан гаргахад анхаарах

асуудлуудын талаар тайлбарлаж, захиргааны эрх зүйн чиглэлээр ажиллаж буй хуульч, судлаач, эрх зүйч нартай сонирхолтой яриа өрнүүлсэн.

- “Миний дуртай захиргааны эрх зүй” цуврал уулзалт-2, 3



Монголын Хуульчдын холбоо
Захиргааны эрх зүйн хороо

**МИНИЙ ДУРТАЙ
ЗАХИРГААНЫ ЭРХ ЗҮЙ**
цуврал уулзалт

Сэдэв:
**"ШУДАРГА БУС
ХУУЛИЙГ ҮЛ ТЭВЧИХ
ЗАРЧИМ"**

Панелист:
Т.МӨНХ-ЭРДЭНЭ
МОНГОЛЫН ХУУЛЬЧИДЫН ХОЛБООНЫ
ЭРХ ЗҮЙН ХОРООНЫ УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН
ГИШҮҮН

2025.03.14
07.40

Чингис хааны музей
1 д давсарт,
Musa coffee shop

"Миний дуртай захиргааны эрх зүй" цуврал уулзалтын хүрээнд "Шударга бус хуулийг үл тэвчих зарчим" сэдэвт өглөөний уулзалтыг 2025 оны 03 дугаар сарын 14-ний өдөр зохион байгуулсан. Тус уулзалтын панелистаар Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч, Захиргааны эрх зүйн хорооны тэргүүн Т.Мөнх-Эрдэнэ оролцсон. Тус сэдвийн хүрээнд хууль Үндсэн хуульд нийцсэн байх, шударга ёсны үнэлэмжид нийцсэн байх тухай сонирхолтой агуулгыг хөндөж, Радбрухын формула хэмээх эрх зүйн онол, эрх зүйн философийн чухал ойлголтыг тайлбарлан, шүүхээс Үндсэн хуульд нийцсэн хуулийг хэрэглэх, хууль Үндсэн хуульд

нийцсэн эсэхийг ямар шалгуураар хэрхэн тогтоох, үндсэн хуулийн тодорхой хяналтын механизмд шүүхийн үүрэг, оролцоо ямар байдаг тухай зарчмын асуудлуудыг тайлбарлан ярилцсан.

- “Миний дуртай захиргааны эрх зүй” цуврал уулзалт-4



нийтийн өмч"-ийн үзэл баримтлал, тэдгээрийн ялгаа, нийтийн өмчийн төрөл, хэлбэрийн тухай тайлбарлаж, захиргааны эрх зүйн чиглэлээр ажиллаж буй хуульч, судлаач, эрх зүйч нартай сонирхолтой яриа өрнүүлсэн.

- “Миний дуртай захиргааны эрх зүй” цуврал уулзалт-5



Захиргааны эрх зүйн хорооноос "Миний дуртай захиргааны эрх зүй" цуврал уулзалтыг "БНСУ, БНХАУ-ын шүүхийн цахимжилтын ололт (бодит ажиглалт)" сэдвээр 2025 оны 06 дугаар сарын 05-ны өдөр зохион байгуулсан.

Тус уулзалтын панелистаар Захиргааны эрх зүйн хорооны тэргүүн, Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Т.Мөнх-Эрдэнэ оролцож, БНСУ болон БНХАУ-д шүүхийн цахимжилтын талаар судлаж ажилласан бодит ажиглалтын үр дүнгээ хуульч нарт хуваалцсан юм.

Тухайлбал, БНСУ, БНХАУ-ын шүүхийн цахимжилтын хөгжлийн үе шат, цөм системүүдийг хөгжүүлсэн байдал, цахимаар нэхэмжлэл гаргах, цахим нотлох баримтыг хүлээн авч бэхжүүлж, үнэлэх ажиллагаа, цахимаар хэрэг хянан шийдвэрлэх буюу цахим шүүх хуралдаан явуулах, тухайлан байгуулсан цахим шүүхийн тогтолцоо, шүүхийн барилга байгууламж, техник төхөөрөмжийн стандарт, хөгжил, шүүхийн цахимжилтад хөрөнгө оруулалт, дэд бүтцийн хөгжүүлэлт суурь асуудал болох тухай зэрэг олон сонирхолтой мэдээллийг танилцуулсан.

Уулзалтын төгсгөлд БНСУ, БНХАУ-ын шүүхийн цахимжилтын туршлагын талаар захиргааны эрх зүйн чиглэлээр ажиллаж буй хуульч, судлаач, эрх зүйч нар өөрийн сонирхсон асуултыг асууж, хариулт авахын зэрэгцээ панелистын зүгээс манай улсад хэрэгжиж байгаа "Цахим шүүх 2.0" цөм системийн хөгжүүлэлтийн талаарх зарим нэг мэдээллийг оролцогч нарт хүргэсэн.

Хэлэлцүүлэг зохион байгуулах ажлын хүрээнд:

1. "Компани өөрийн хөрөнгөөс хувь нийлүүлсэн хөрөнгөө нэмэгдүүлэхэд ногдол ашгийн татвар төлөх үү?" сэдэвт хэлэлцүүлэг зохион байгууллаа

Захиргааны эрх зүйн хорооноос санаачлан Эдийн засгийн эрх зүйн хороотой хамтран 2025 оны нэгдүгээр сарын 31-ний өдөр "Компани өөрийн хөрөнгөөс хувь нийлүүлсэн хөрөнгөө нэмэгдүүлэхэд ногдол ашгийн татвар төлөх үү?: Улсын дээд шүүхийн шийдвэр, тусгай саналын жишээн дээр" сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Тус хэлэлцүүлгийг нээж Захиргааны эрх зүйн хорооны тэргүүн, шүүгч Т.Мөнх-Эрдэнэ үг хэлсэн бөгөөд тэрбээр "Өнгөрсөн онд бид Монгол Улсад захиргааны хэргийн дагнасан шүүх байгуулагдсаны 20 жилийн ойг өргөн хүрээнд тэмдэглэн өнгөрүүлсэн бөгөөд сүүлийн жилүүдэд захиргааны хэргийн шүүхээр шийдвэрлэгдэх маргааны төрөл, зүйл, маргаж буй үндэслэлүүд нэмэгдэж, улам бүр нарийсан мэргэших чиг хандлага бодитой болсон өнөөгийн нөхцөлд салбарын хуульчид бид захиргааны хэргийн

шүүхээр шийдвэрлэгдэж буй шинэ төрлийн, зарчмын ач холбогдолтой, хууль хэрэглээний онол-практикийн маргаантай, сонирхолтой кэйсүүдийг судлан тал бүрээс нь мэргэжлийн түвшинд шинжлэн ярилцдаг ийм формат бүхий хэлэлцүүлгийг тогтмол хийдэг байх нь чухал болоод байгаа" гэдгийг онцолсон.

Тус хэлэлцүүлгээр Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны нэгдүгээр сарын 03-ны өдрийн 21 дугаартай шийдвэр, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2024 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 353 дугаартай магадлал, Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн хяналтын шатны шүүх хуралдааны 2024 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 84 дугаартай тогтоол, мөн тогтоолд бичсэн Улсын дээд шүүхийн шүүгчийн тусгай саналтай кэйсийг тойрч хөндлөнгийн бөгөөд мэргэжлийн агуулга бүхий хэлэлцүүлгийг өрнүүлсэн.

Тодруулбал, "Шүүгчийн тусгай санал буюу компани өөрийн хөрөнгөөс хувь нийлүүлсэн хөрөнгөө нэмэгдүүлсэн нь татвар ногдуулах үндэслэл биш (Няцаах байр суурь)" сэдвээр "Грандлекс партнерс" ХХК-ийн гүйцэтгэх захирал, хуульч С.Халиунаа, Өмгөөллийн "ЭмДиЭс энд Хаан лекс" ХХН-ийн партнер, хуульч С.Батбуян, "Компани өөрийн хөрөнгөөс хувь нийлүүлсэн хөрөнгөө нэмэгдүүлэхэд ногдол ашгийн татвар ногдуулах нь зөв (Нотлох байр суурь)" сэдвээр Өмгөөллийн "Хэруга партнерс" ХХК-ийн үүсгэн байгуулагч, хуульч А.Базар, Өмгөөллийн "Арга партнерс" ХХК-ийн өмгөөлөгч, хуульч Б.Баттогтох нар илтгэл хэлэлцүүлсэн.

Мөн тухайн кэйст санхүүгийн тайлагнал, нягтлан бодох бүртгэлийн үүднээс хөндлөнгийн судлаачийн байр сууриа дүгнэлтийн хэлбэрээр Санхүү эдийн засгийн их сургуулийн ахлах багш Ч.Өнөржаргал танилцуулсан.

Эдийн засгийн эрх зүйн хорооны тэргүүн, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн санхүү, татварын эрх зүйн багш Б.Баасандорж тус хэлэлцүүлгийг дүгнэж хаалаа. Тэрээр Захиргааны эрх зүйн хороонд талархлаа илэрхийлж, хууль тогтоомжийн шинэчлэлийг хийхэд Монголын Хуульчдын холбооны хувь нэмэр чухал болохыг онцолж хуульчдын хамтын ажиллагааг өргөжүүлэхийг хичээж ажиллахаа илэрхийлсэн.



Хэлэлцүүлгийг дүгнэж хаасан үгийн хувьд санхүү, татварын салбарын эрх зүйн хэм хэмжээг тайлбарлахад мэргэжлийн бүртгэл, олон улсын стандартын ач холбогдол өндөр учир хэм хэмжээг хэрэглэхдээ хуулийн зорилго, үгийн утгыг харгалзахын зэрэгцээ цаад системийг давхар харахын чухлыг онцолсон. Мөн татварын эрх зүйд аналог буюу төсөөтэй хэрэглэх нь зөвшөөрөгдөхгүй бөгөөд энэ нь татварыг зөвхөн хуулиар ногдуулах Үндсэн хуулийн зарчмаас урган гардаг болохыг тэмдэглэж татварын хууль тогтоомж дахь материаллаг хэм хэмжээг татварын эрх зүйн үүднээс хөгжүүлэхгүй бол татвар төлөгчийн эрх ашиг зөрчигдсөн хэвээр байхыг дурдаж хэлэлцүүлгийг хаасан.

2. "Газрын эрх зүйн зохицуулалт, тулгамдаж буй асуудал" сэдвээр хэлэлцүүлэг зохион байгууллаа

 Хамтын оюоны байгуулалт Монголын Хуульчдын холбооны Захиргааны эрх зүйн хороо	 Хамтын оюоны байгуулалт Монголын Хуульчдын холбооны Эдийн засгийн эрх зүйн хороо
 Батбуяан А. АЗАР Батбуяан "Хэруга Партнерс" ХХК-ийн үүсгэн байгуулагч	 С. ХАЛИУНАА Грандлекс Партнерс" ХХК-ийн Гүйцэтгэх захирал
КОМПАНИ ӨӨРИЙН ХӨРӨНГӨӨС ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨӨ НЭМЭГДҮҮЛЭХЭД НОГДОЛ АШГИЙН ТАТВАР ТӨЛӨХ ҮҮ?	
Улсын Дээд шүүхийн шийдвэр, тусгай саналын жишээн дээр	
 Баттогтох Б. БАТТОГТОХ Баттогтох "Арга партнерс" ХХК-ийн татварын өмгөөлөгч	 С. БАТБУН Батбуун "ЭмДиЭс энд Хаанлекс" ХХН-ийн партнер
Хэвлэл: Утасны Голын Их сургуулийн Шалын өмчийн газрын 2024 оны тэмцэв Хэвлэл: 2024 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр 10:00 цагт	
Холбоо барих утас: 99612223	

М.Үнэнбат, Монголын Хуульчдын холбооны Тамгын газрын дарга Ш.Жолбарс нар нээж үг хэлсэн.

Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газраас санаачлан Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай хамтран "Газрын эрх зүйн зохицуулалт, тулгамдаж буй асуудал" сэдэвт хэлэлцүүлгийг 2025 оны хоёрдугаар сарын 26-ны өдөр зохион байгуулсан.

Хэлэлцүүлгийг ЗГХХГ-ын Хууль, эрх зүйн газрын дарга Б.Аз, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль, тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга



Хэлэлцүүлгийн үеэр “Газрын зөвшөөрөл олгох харилцааны зохицуулалт, асуудлууд” сэдвээр Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын Хууль, эрх зүйн газрын ахлах шинжээч С.Уранмандах, “Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанаас иргэн, аж ахуйн нэгжид үзүүлж буй үйлчилгээ” сэдвээр Нийслэлийн газар зохион байгуулалтын албаны Кадастрын хэлтсийн дарга Б.Загдсамбар, “Газартай холбоотой захиргааны актад хамаарах маргааныг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ” сэдвээр Хуульчдын холбооны судлаач Г.Оюунболд нар илтэл тавьж, панел хэлэлцүүлгүүд зохион байгуулсан.

Чиглүүлэгчээр Захиргааны эрх зүйн хорооны Удирдах зөвлөлийн гишүүн А.Түвшинтөгс ажилласан бөгөөд Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газар, Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яам, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Монголын Хуульчдын холбоо зэрэг байгууллагын 80 гаруй албан хаагчдын төлөөлөл оролцсон.

Тус хэлэлцүүлгийн оролцогчдын зүгээс газрын харилцааны өнөөгийн нөхцөл байдал, тулгамдсан асуудлыг тодорхойлж, цаашдын хөгжлийн шийдэл, гарцуудын талаар санал бодлоо солилцож, нэгдсэн зөвлөмж, шийдэлд хүрч цаашид авах арга хэмжээг тодорхойлж холбогдох байгууллагуудад хүргүүлэн биелэлтэд хяналт тавин ажиллахаар болсон.

Хэлэлцүүлгийг Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Ч.Өнөрбаяр, Хуульчдын холбооны Ерөнхийлөгч П.Одгэрэл, Захиргааны эрх зүйн хорооны тэргүүн Т.Мөнх-Эрдэнэ нар хааж үг хэлсэн бөгөөд Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Ч.Өнөрбаяр "Иргэн, аж ахуйн нэгжээс төрийн болон нутгийн захиргааны байгууллагад хандан газрын харилцаатай холбоотой өргөдөл, гомдлыг ихээр гаргаж буй нь газрын зөвшөөрөл олгохтой холбоотой харилцааг зохицуулсан эрх зүйн орчин тодорхойгүй, холбогдох хууль, журамд гүйцэтгэх хугацаа нь тодорхойгүй шат дамжлага ихээр тусгагдсан, бүрдүүлэх баримт бичгийг эрх зүйн орчны хүрээнд бүрэн тодорхойлоогүй, зарим тохиолдолд захиргааны байгууллагаас хуульд заагаагүй баримт бичгийг нэмэлтээр шаардаж байгаа, дүрэм, журам, захиргааны хэм хэмжээний актын зохицуулалт их, хэт олон шат дамжлага байгаатай холбоотой" гэдгийг онцолсон.

3. “Монгол Улсын нийгмийн хамгааллын эрх зүйг боловсронгуй болгох нь: ХБНГУ-ын нийгмийн хамгааллын эрх зүй ба сайн туршлага” сэдэвт хэлэлцүүлэг зохион байгууллаа

Захиргааны эрх зүйн хорооноос “Монгол Улсын нийгмийн хамгааллын эрх зүйг боловсронгуй болгох нь: ХБНГУ-ын нийгмийн хамгааллын эрх зүй ба сайн туршлага” сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгуулсан бөгөөд хэлэлцүүлэгт Германы Касселын их сургуулийн Нийгмийн хамгаалал, эрүүл мэндийн эрх зүйн тэнхимийн профессор, Германы холбооны нийгмийн хамгааллын шүүхийн хүндэт шүүгч Феликс Вельти, Касселын их сургуулийн докторант, судлаач С.Амармэнд нар зочин илтгэгчээр оролцов.

Профессор, шүүгч Феликс Вельти “Германы нийгмийн хамгааллын эрх зүйн тусгай зохицуулалтууд ба нийгмийн хамгааллын шүүхийн үүрэг” сэдвээр, судлаач С.Амармэнд “Германы нийгмийн хамгааллын шүүхийн тогтолцоо” сэдвээр илтгэл хэлэлцүүлсэн.

Илтгэгчид Германы нийгмийн хамгааллын эрх зүйн зохицуулалтуудын тухай тайлбарласнаас гадна тус улсад нийгмийн хамгааллын дагнасан шүүхийн тогтолцоо ажилладаг тухай танилцуулж, нийгмийн хамгааллын эрх зүйд нийгмийн даатгалын сангуудын удирдлагын хэлбэр чухал тухай, Германд нийгмийн даатгалын сангуудыг Засгийн газраас бус, харин нийтийн эрх зүйн өөрийн удирдлага бүхий нэгдлүүд (сангууд) удирддаг тухай болон нийгмийн даатгал, халамжийн суурь асуудал нь иргэдийн орлогын хэмжээ байдаг гэх зэрэг олон чухал асуудлуудыг хөндсөн.



Тус хэлэлцүүлэгт Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн танхимын тэргүүн, шүүгчид, Захиргааны хэргийн давж заалдах шатны болон Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчид, орон нутаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчид, Захиргааны эрх зүйн хорооны гишүүн хуульчид болон төрийн холбогдох байгууллагууд, судлаач, эрдэмтдийн төлөөлөл оролцсон.

4. Хот байгуулалтын эрх зүйн зохицуулалтад тулгамдаж буй асуудлын талаар хэлэлцүүлэг зохион байгууллаа

Захиргааны эрх зүйн хорооноос Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамтай хамтран “Хот байгуулалтын эрх зүйн зохицуулалт, тулгамдаж буй асуудал” сэдэвт хэлэлцүүлгийг 2025 оны 04 дүгээр сарын 25-ны өдөр зохион байгуулсан. Хэлэлцүүлгийн хүрээнд ХББОСЯ-ны Хот байгуулалтын бодлого, зохицуулалтын газрын дарга Ц.Баярбат “Хот байгуулалтын тухай хуулийг шинэчлэх хэрэгцээ, шаардлага” сэдвээр, Монголын Хуульчдын холбооны гишүүн, хуульч Ж.Сайнхишиг “Хот байгуулалтын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээ, хууль тогтоомжийг боловсронгуй болгох чиглэл” сэдвээр, Нийслэлийн Хот байгуулалт, хотын стандартын газрын Хуулийн хэлтсийн дарга Я.Болор “Хот төлөвлөлтийн шийдвэр гаргах процесс: Эрх зүйн зохицуулалт, тулгамдсан асуудал” сэдвээр, Хот байгуулалт, хотын стандартын газрын Дэд төв дагуул хотын хөгжлийн хэлтсийн хуулийн мэргэжилтэн С.Энхжаргал Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн хэрэгжилтийн үр нөлөөнд хийсэн үнэлгээний тайлан” сэдвээр, Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч А.Ганзориг Хот байгуулалт, дахин төлөвлөлттэй холбоотой захиргааны актад хамаарах маргааныг шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрт хийсэн дүн шинжилгээ” сэдвүүдээр тус тус илтгэл хэлэлцүүлсэн.

Чиглүүлэгчээр Захиргааны эрх зүйн хорооны Удирдах зөвлөлийн гишүүн Б.Баттогтох ажилласан бөгөөд тус хэлэлцүүлэгт Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын яамны ажилтнууд, Хот байгуулалтын тухай хууль, Хот, суурин газрыг дахин хөгжүүлэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажлын хэсгийн гишүүд, Монголын Хуульчдын холбооны гишүүд болон холбогдох төрийн болон нийслэлийн Захиргааны байгууллагын албан хаагчид оролцсон.

Тус хэлэлцүүлгээр Хот байгуулалтын салбарын эрх зүйн орчны өнөөгийн байдал, тулгамдсан асуудлыг тодорхойлох, хууль тогтоомжийн тогтолцоог боловсронгуй болгох асуудлаар хэлэлцүүлэг өрнүүлсэн бөгөөд хот байгуулалтын тухай хуулийн боловсронгуй болгох, холбогдох дүрэм, журмуудыг нийтэд ил тод байршуулах талаар оролцогчид санал солилцсон юм.



5.Хуулийн этгээдийн бүртгэлийн эрх зүйн зохицуулалтад тулгамдаж буй асуудлыг хэлэлцүүлэг зохион байгуулсан.

Монголын Хуульчдын холбооноос санаачлан УИХ-ын Тамгын газрын дэргэдэх Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэн, Улсын бүртгэлийн Ерөнхий газар, Захиргааны эрх зүйн хороотой хамтран “Хуулийн этгээдийн бүртгэлийн эрх зүйн зохицуулалт, тулгамдаж буй асуудал” сэдэвт хэлэлцүүлгийг 2025 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр зохион байгуулсан. Хэлэлцүүлгийг Монголын Хуульчдын холбооны Ерөнхийлөгч П.Одгэрэл, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Тамгын газрын дарга Д.Давааням нар нээж үг хэлсэн.

Хэлэлцүүлгийн хүрээнд Улсын бүртгэлийн ерөнхий газрын ахлах бүртгэгч Б.Лхагвасүрэн “Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн эрх зүйн зохицуулалт, тулгамдаж буй асуудал” сэдвээр илтгэл хэлэлцүүлж, улсын бүртгэлийн гэрчилгээ болон тамга, тэмдгийн хяналтын дугаар дахин олгох, тамга, тэмдэг алдагдсан, тамга тэмдгийг хүлээлгэн өгөхгүй байгаа үйлдэл, эс үйлдэхүйн талаар мэдээлэл өгсөн бол “Грандлекс партнерс” ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Халиунаа “Компанийн улсын бүртгэлийн тулгамдсан асуудал. /Харьцуулсан эрх зүй/” сэдвүүдээр илтгэл тавьсан.



Илтгэлийн дараа панел хэлэлцүүлэг явуулсан бөгөөд чиглүүлэгчээр Монголын Хуульчдын холбооны Тамгын газрын дарга Ш.Жолбарс, панелистаар Нийслэл дэх захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Д.Халиуна, “Грандлекс партнерс” ХХК-ийн гүйцэтгэх захирал С.Халиунаа, ХЭУБГ-ын дарга Ж.Аюуш, Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнгийн Судалгааны хэлтсийн ахлах референт О.Нарантуяа нар оролцсон. Тус хэлэлцүүлэгт Нийслэл дэх Захиргааны хэргийн шүүх, УИХ-ын Тамгын газрын дэргэдэх Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэн, Улсын Ерөнхий Прокурорын газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газрын төлөөлөл болон Монголын Хуульчдын холбооны гишүүн хуульч, өмгөөлөгчид оролцож хуулийн этгээдийн бүртгэлийн эрх зүйн зохицуулалтад тулгамдаж буй асуудлуудын талаар санал солилцож, цаашид эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох талаар зөвлөмж боловсруулан холбогдох байгууллагад хүргүүлэхээр болсон.

6."Татварын шинэчлэл" сэдэвт хэлэлцүүлэг зохион байгууллаа



Захиргааны эрх зүйн хороо Татварын хөгжил дэвшил холбоотой хамтран “Татварын шинэчлэл” сэдэвт хэлэлцүүлгийг 2025 оны 10 дугаар сарын 09-ний өдөр зохион байгуулж дараах илтгэлүүдийг хэлэлцүүллээ. Үүнд:

- Захиргааны эрх зүйн хорооны Удирдах зөвлөлийн гишүүн Б.Баттогтох “Татварын ерөнхий хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөлд хийсэн дүн шинжилгээ”,
- Эдийн засгийн эрх зүйн хорооны тэргүүн Б.Баасандорж “Нэмэгдсэн өртгийн албан татварын хуулийг шинэчлэн найруулах тухай хуулийн төсөл ,санал, дүгнэлт”,
- СЭЗИС-ийн ахлах багш Ч.Өнөржаргал “Хувь хүний орлогын албан татварын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл”,
- Өмгөөллийн “Түмэн адвокат” ХХК-ийн удирдах партнер Н.Түмэнбаяр “Аж ахуйн нэгжийн албан татварын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл”,
- ТХДХ-ийн хуулийн зөвлөх Т.Заяахишиг “Татварын дарамт, татварын хуулийн өөрчлөлт” сэдвээр тус тус илтгэл хэлэлцүүлсэн.

Хорооны төлөөлөл уулзалт, хэлэлцүүлэг оролцсон талаар

Монголын Хуульчдын холбоо, Олон Улсын Эрх зүйн хөгжлийн байгууллага хоорондын уулзалтад Захиргааны эрх зүйн хороог төлөөлөн хуульч н.Хандармаа, н.Номин нар Олон Улсын эрх зүйн хөгжлийн байгууллага (IDLO)-тай уулзаж, хамтран ажиллах боломжийн талаар ярилцлаа.

Холбооны Ерөнхийлөгч П.Одгэрэл чиг үүргийн хороодын дарга, сайн дурын хороодын тэргүүнүүд, Тамгын газрын мэргэжилтнүүдтэй 2025 оны нэгдүгээр сарын 10-ны өдөр уулзсан. Уулзалтын үеэр Монголын Хуульчдын холбооны Тамгын газрын мэргэжилтнүүд 2024 оны тайлан, мэдээллээ танилцуулж, хороодын дарга, тэргүүнүүд 2025 онд хэрэгжүүлэх ажлын талаар санал солилцсон.

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Нийтийн эрх зүйн нэгдмэл байдал, чиг хандлага, шийдэл” цуврал хэлэлцүүлгийн хүрээнд хийх “Захиргааны эрх зүйн нэгдмэл байдал, чиг хандлага, шийдэл” сэдэвт хэлэлцүүлэгт Захиргааны эрх зүйн хорооны Р.Лхагвабаяр, С.Халиунаа нарыг оролцуулахаар нэр холбогдох мэдээллийг 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдөр явуулсан.

Иргэний шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн эрх зүйн орчинг боловсронгуй болгох нь сэдэвт хэлэлцүүлэгт хуульч О.Чулуунцэцэг, Э.Энэбиш, Б.Алтаншагай, С.Батбуян нар оролцсон.

“Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндсэний хөтөлбөрийн хэрэгжилт ба дараагийн бодлогын чиглэл” сэдэвт хэлэлцүүлэгт захиргааны эрх зүйн хорооноос Д.Номин, Хуульчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах хорооноос О.Чулуунцэцэг, Ц.Амарсанаа, Ч.Өнөржаргал нар оролцсон.

Монголын Хуульчдын холбоо, Нээлттэй нийгэм форум хамтран “Шүүхийн захиргааны үндсэн чиг үүрэг, түүний хэрэгжилт” сэдэвт хэлэлцүүлэгт Захиргааны эрх зүйн хорооны тэргүүн Т.Мөнх-Эрдэнэ оролцлоо.

Сонгууль зохион байгуулах ажлын хүрээнд:

1.Захиргааны эрх зүйн хорооноос тайлант хугацаанд Удирдах зөвлөлийн 8 гишүүний бүрэн эрхийн хугацаа дуусгавар болсонтой холбогдуулан дээрх орон тоон дээр 2025 оны 01, 09, 11 дүгээр сард тус тус сонгууль зарлаж гишүүдийг нөхөн сонгосон.



Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхээс эрхлэн явуулдаг “Сонсдог шүүх” подкастын ээлжит дугаарт хорооны тэргүүн, шүүгч Т.Мөнх-Эрдэнэ оролцсон.

ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН ХОРОО

1. "Цэвэр агаар-эрүүл хуульч" өдөрлөг зохион байгууллаа

Иргэний эрх зүйн хорооноос санаачлан Тамгын газартай хамтран "Цэвэр агаар-Эрүүл хуульч" өдөрлөгийг 2025 оны хоёрдугаар сарын 01-ний өдөр Манзуширын аманд байрлах "Овооны энгэр" жуулчны баазад зохион байгууллаа.



Хуульчдын эрүүл мэнд, бие бялдрыг чийрэгжүүлэх, амьдралын зөв дадал, хэвшил олгох зорилгоор зохион байгуулсан тус өдөрлөгт 60 гаруй хуульч оролцсон. Тэднийг сугалаагаар 6 багт хувааж, хөгжөөнт тэмцээн, уралдаанууд зохион байгуулсан бөгөөд хуульч Г.Даваанямаар ахлуулсан "Зүгээр л..." баг нэгдүгээр байрт, хуульч О.Билгүүнээр ахлуулсан "Нил ягаан" баг хоёрдугаар байрт шалгарсан. Тус өдөрлөгт Монголын Хуульчдын холбооны Ерөнхийлөгч П.Одгэрэл, Тамгын газрын дарга Ш.Жолбарс, Иргэний эрх зүйн хорооны тэргүүн Г.Даваадорж болон тус хорооны удирдах зөвлөлийн гишүүд хүрэлцэж ирж, оролцогчдод амжилт хүссэн юм. Мөн өдөрлөгт өмгөөллийн "Легал гайд", "Анта партнерс", "Монгол өмгөөлөгч" нөхөрлөлийнхөн идэвхтэй оролцсон.

2. "Цахим эрх зүйн олон улсын чиг хандлага" сэдэвт хэлэлцүүлэг зохион байгууллаа



Монголын Хуульчдын холбоо, Герман Европын эрх зүйн төв, УИХ-ын Парламентийн сургалт, судалгаа, хөгжлийн хүрээлэн хамтран "Цахим эрх зүйн олон улсын чиг хандлага" сэдэвт хэлэлцүүлгийг 2025 оны нэгдүгээр сарын 31-ний өдөр зохион байгууллаа. Тус хэлэлцүүлгийг Монголын Хуульчдын холбооны Ерөнхийлөгч П.Одгэрэл, Хансс Зайдел сангийн Монгол дахь суурин төлөөлөгч Феликс Гленк, Герман Европын эрх зүйн төвийн захирал Т.Золбоо нар нээж үг хэлсэн

бөгөөд Бүгд Найрамдах Ардчилсан Конго улсын Конгогийн Киквит ба Католик их сургуулийн доктор, профессор Лумингү Манзанза "БНАКУ-ын Шүүх засаглалыг цахимжуулахад тулгарч буй бэрхшээлүүд" сэдвээр, ХБНГУ-ын Юлиус-Максимилианы нэрэмжит Вюрцбургийн их сургуулийн Эрүүгийн эрх зүй, Эрүүгийн байцаан шийтгэх эрх зүй, Эрх зүйн онол, мэдээллийн эрх зүй, эрх зүйн мэдээлэл зүйн асуудал хариуцсан тэнхимийн эрхлэгч Проф. Доктор. Эрик Хилгендорф "Авлига - Эрх зүйт төрийн сорилт" сэдвээр, ХБНГУ-ын "Рехтс- унд Фаханвэлтэ" хуулийн фирмийн партнер, өмгөөлөгч, доктор Северин Лоефлер "Цахимжилт ба өмгөөлөл" сэдвээр, Вюрцбургийн Их Сургуулийн Эрдэм шинжилгээний туслах ажилтан Йоханнес Хартлейн "Европын Холбооны Хиймэл оюун ухааны тухай шинэ Тогтоол" сэдвээр, МХХ-ны ИЭЗ хорооны Тэргүүн, Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч Г.Даваадорж " Монгол Улсын цахим шилжилтийн эрх зүйн орчин ба тулгамдсан асуудлууд" сэдвээр тус тус илтгэл хэлэлцүүлээ.

3. "DATA+AI CONFERENCE-2025" оролцлоо



Их өгөгдөл, хиймэл оюуны үндэсний стратеги хэлэлцүүлэх анхдугаар чуулга уулзалтад Төрийн ордонд болсон. Тус чуулга уулзалтад Монголын Хуульчдын холбооны Иргэний эрх зүйн хорооны Тэргүүн, Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч Г.Даваадорж оролцов. Уулзалтаар Монгол Улс хиймэл оюуны үндэсний стратегиа хэлэлцэх, шинэ цагийн технологийн салбарт хөл тавих, бодлогын түвшинд томоохон ахиц гаргах түүхэн ач холбогдолтой үйл явдал болж байна. Түүнчлэн Сингапур, Малайз, Англи зэрэг улсаас хиймэл оюуны мэргэжилтнүүд хүрэлцэн ирж хамгийн сүүлийн үеийн мэдээ, мэдээлэл, улс орон болон хувийн хэвслүүдийн амжилттай туршлагаудыг хуваалцаж байгаагаараа онцлогтой юм. Үндэсний стратегитай болсноор бүхий л салбарт

хиймэл оюуныг нэвтрүүлэх, их өгөгдлөө зөв зүйтэй ашиглах, бүтээмжийг нэмэгдүүлэх, оновчтой шийдвэр гаргах ач холбогдолтой.

4. ESG зохицуулалтын чиг хандлага ба Монгол Улс дахь нөлөөлөл подкаст хийлээ
Сэдэв: ESG зохицуулалтын чиг хандлага ба Монгол Улс дахь нөлөөлөл

🎙️ Зочин: Б.Оюунжаргал (МУИС-ийн ХЗС-ийн Иргэний эрх зүйн тэнхимийн ахлах багш, доктор)
🎙️ Хөтлөгч: Б.Анирмаа ("Фиделитас партнерс" ХХН-ийн өмгөөлөгч)

5. Аризона мужийн Барын холбоотой уулзалт зохион байгууллаа



Монголын Хуульчдын холбоо нь АНУ-ын Аризона мужийн Барын холбоотой 2025 оны гуравдугаар сарын 12-ны өдөр цахим уулзалт зохион байгууллаа. Уулзалтад Монголын Хуульчдын холбооны Ерөнхийлөгч П.Одгэрэл, Тамгын газрын дарга Ш.Жолбарс, Иргэний эрх зүйн хорооны Тэргүүн, Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч Г.Даваадорж, Иргэний эрх зүйн хорооны Удирдах зөвлөлийн гишүүн, өмгөөлөгч Ч.Отгонбаатар, Судалгааны төвийн эрхлэгч Ц.Одонжав болон Аризона мужийн Барын холбооны Гүйцэтгэх

захирал Жоэл Ингланд, Тамгын газрын дарга ба Олон нийтийн нөлөөллийн төвийн захирал Ноа Коакли, Харилцаа холбооны тэргүүн Жо Хенгемухлер, Үйлчилгээний ахлах ажилтан Роберта Теппер нар оролцов.

Тус уулзалтаар хоёр байгууллагын бүтэц, зохион байгуулалт, онцлогийн талаар танилцуулж, хамтран ажиллах санамж бичиг байгуулах, хуульчийн үргэлжилсэн сургалтын хөтөлбөрийг сайжруулах, сургагч багш бэлтгэх, харилцан туршлага судлах зэрэг цаашид хэрэгжүүлэх хамтын ажиллагааны талаар санал солилцсон.

6. “Төрийн болон орон нутгийн өмчийн эрх зүйн зохицуулалтын зарим асуудал” сэдэвт илтгэлийн уралдаан зохион байгууллаа



Иргэний эрх зүйн хорооноос жил бүр хууль зүй их, дээд сургуулийн оюутнуудын дунд хувийн эрх зүйн тодорхой асуудал хөндсөн сэдвээр эрдэм шинжилгээний илтгэлийн уралдаан зарлаж дүгнэдэг уламжлалтай. 2025 оны оюутны эрдэм шинжилгээний илтгэлийн уралдааныг “Төрийн болон орон нутгийн өмчийн эрх зүйн зохицуулалтын зарим асуудал” сэдвийн хүрээнд зохион байгууллаа.

Илтгэлийн уралдааны хоёрдугаар шатанд МУИС-ийн Хууль зүйн сургууль, Дотоод хэргийн их сургууль,

Шихихутуг их сургууль, Санхүү, эдийн засгийн их сургууль, Их засаг их сургуулийн оюутнуудын илтгэлүүд шалгарсан бөгөөд шалгарсан илтгэлүүдийг 2025 оны тавдугаар сарын 2-ны өдөр хэлэлцүүлж шилдгүүдийг тодрууллаа. Хоёрдугаар шатны шалгаруулалтын шүүгчээр Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхийн шүүгч Н.Оюунтуяа, “Эрдэнэс монгол” ХХК-ийн Нэгдлийн хууль, эрх зүйн зөвлөлийн дарга Б.Гэрлээ, хуульч, өмгөөлөгч Э.Удвал, өмгөөллийн "Легал гайд" хуулийн фирмийн партнер Э.Эрдэнэхишиг нар ажиллаж шилдэг илтгэлийг тодруулсан бөгөөд дараах илтгэлүүд шилдгээр шалгарлаа. Үүнд: -1 дүгээр байранд Санхүү, эдийн засгийн их сургуулийн Бизнесийн эрх зүйн хөтөлбөрийн IV дамжааны оюутан А.Азжаргал, Э.Оюунбилэг нар “Үндсэн хуулийн 6.2 дахь заалтын зарим агуулгыг тайлбарлан хэрэглэх асуудал” илтгэлээр, -2 дугаар байранд МУИС-ийн Хууль зүйн сургуулийн IV түвшний оюутан Ч.Цэрэнчимэд, Б.Өсөхбаяр нар “Төрийн болон орон нутгийн өмчийн эрх зүйн зохицуулалтын зарим асуудал” илтгэлээр, -3 дугаар байранд МУИС-ийн Хууль зүйн сургуулийн IV түвшний оюутан Б.Өсөхбаяр, Б.Мөнхцэцэг нар “Төрийн

өмчит компани дахь өмчлөгчийн хяналт, онцгой дэглэм тогтоох асуудлын хүрээнд” илтгэлээр тус тус шалгарсан.

7. “Цахим шүүх mock trial-2025” шүүхийн мэтгэлцээний тэмцээний техникийн зөвлөгөөн боллоо

Иргэний эрх зүйн хороо, өмгөөллийн “Легал гайд” хуулийн фирм хамтран зохион байгуулах “Цахим шүүх Mock Trial – 2025” иргэний хэргийн шүүхийн мэтгэлцээний техникийн зөвлөгөөн өнөөдөр (2025.05.08) боллоо. Шүүх эрх мэдлийн байгууллагуудын цахимжилтын энэ цаг үед анх удаа цахим хэлбэрээр зохион байгуулагдах “Цахим шүүх Mock Trial – 2025” иргэний хэргийн шүүхийн мэтгэлцээнд нийт 8 сургуулийн 12 баг оролцохоор мэдүүлгээ ирүүлсэн. Техникийн зөвлөгөөнөөр “Цахим шүүх Mock Trial-2025” иргэний хэргийн шүүхийн мэтгэлцээний дүрмийг баталж, тоглох оноолтоо тодруулж, мэтгэлцээний хэргээ багууд хүлээн авлаа. Мэтгэлцээний хэргээр зээлийн гэрээ, тээвэрлэлтийн гэрээ, орон сууц зээлээр худалдах, худалдан авах гэрээ болон концессын гэрээтэй холбоотой маргаанууд сонгогдсон байна.

8. Иргэний эрх зүйн хорооны тэргүүн Г.Даваадорж “Кибер аюулгүй байдал: эрсдэл ба хариуцлага” сэдвээр илтгэл хэлэлцүүлсэн



Монгол Улсын дээд шүүх, Шүүхийн Академи, Шүүхийн ерөнхий зөвлөл болон АНУ-ын Элчин Сайдын Яам хамтран 2025 оны 6 дугаар сарын 16, 17-ны өдрүүдэд Улаанбаатар хотноо Америкийн Нэгдсэн Улсын Конгрессын дэргэдэх “Олон улсын манлайллын төв” (COIL – Congressional Office for International Leadership)-өөс шүүхийн салбарт хэрэгжүүлдэг “Нээлттэй дэлхий” хөтөлбөрийн төгсөгчдийн анхдугаар хуралдааныг “Шүүхийн хараат бус байдал ба цахимжилт” сэдвийн дор зохион байгуулах гэж байна.

Энэхүү Олон Улсын хуралд манай улсын шүүгчдээс гадна АНУ, Армени, Эстони, Индонез, Казахстан, Киргизстан, Молдав, Узбекистан, Серби зэрэг орны шүүгчид хүрэлцэн ирж,

“Шударга ёсны хүртээмжийг нэмэгдүүлэхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг цахимжуулах нь”, “Хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангахад хэрэг судлал (database, caselaw) ашиглах нь”, “Дижитал эрин үе дэх хиймэл оюун ба шүүх”, “Кибер аюулгүй байдлын асуудлууд”, “Олон нийтийн мэдэх эрх ба шүүхэд итгэх итгэл”, “Дижитал эрин үе дэх шүүхийн сургалт: цахим хэрэгсэл, хиймэл оюуныг хэрэглэх чадварыг хөгжүүлэх нь” зэрэг сэдвийн хүрээнд хэлэлцүүлэг өрнүүлж, харилцан туршлага солилцсон бөгөөд тус хуралд Монголын Хуульчдын холбооны Иргэний эрх зүйн хорооны Тэргүүн, Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч Г.Даваадорж “Кибер аюулгүй байдал: Эрсдэл ба Хариуцлага” сэдвээр илтгэл тавьсан.

9. “Хиймэл оюун ба эрх зүйн тогтолцоо” олон улсын эрдэм шинжилгээний хуралд оролцлоо

Монголын Хуульчдын холбоо, Хууль зүй, дотоод хэргийн яам, Олон улсын Улаанбаатарын их сургуулийн Хууль зүйн сургууль, Монгол-Солонгосын эрх зүйн хүрээлэнгээс санаачлан “Хиймэл оюун ба эрх зүйн тогтолцоо” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний хурлыг 2025 оны тавдугаар сарын 14-ний өдөр зохион байгууллаа.

Хурлыг нээж олон улсын Улаанбаатар их сургуулийн Хууль зүйн сургуулийн захирал М.Эрдэнэбаяр, Хууль зүй, дотоод хэргийн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга Н.Жамъянхүү, БНСУ-ын Хууль зүйн судалгааны хүрээлэнгийн Ерөнхийлөгч Хан Ён Сү нар үг хэлсэн бөгөөд хуралд ХЗДХЯ-ны Хууль зүйн бодлогын газрын дарга Н.Жамъянхүү, Иргэний эрх зүйн хорооны тэргүүн Г.Даваадорж, БНСУ-ын Хууль тогтоомжийн яамны Хууль тогтоомжийн хамтын ажиллагааны газрын захирал Пак Суни, ОУУБИС-ийн Хууль зүйн

сургуулийн захирал М.Эрдэнэбаяр, УЕПГ-ын Сургалт, судалгааны хүрээлэнгийн судалгааны албаны дарга, ахлах прокурор Б.Мөнхдорж, Дотоод хэргийн их сургуулийн докторант З.Сансарзолбоо, Ханнс Зайдел сангийн суурин төлөөлөгч Феликс Гленк, Сингапур улсын Хэвлэл мэдээлэл, хөгжлийн газрын Хиймэл оюун, аюулгүй байдлын ахлах менежер Даршини Рамиа нар илтгэл хэлэлцүүлж, Монгол-Солонгосын эрх зүйн хүрээлэнгийн захирал О.Амарсанаа чиглүүлэгчээр оролцлоо.

Мөн Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Б.Энхболд, БНСУ-ын Төрийн өмчит хууль зүйн судалгааны хүрээлэнгийн Инноваци, санхүү, хууль тогтоомжийн хэлтсийн дарга Пак Сэ Хүн, Шинжлэх Ухааны Академийн Бага чуулганы гишүүн Ж.Болдбаатар нар тус сэдвийн хүрээнд Монгол Улсад хийж хэрэгжүүлж буй асуудлуудыг талаар өөрсдийн байр суурийг илэрхийлж, хэлэлцүүлэгчээр оролцсон.

Эрдэм шинжилгээний хурлаар хиймэл оюун ухааныг Монгол Улсын эрх зүйн тогтолцоонд нэвтрүүлэх нь шинэ зүйл бөгөөд энэ нь хууль эрх зүйн салбар дахь үр ашгийг дээшлүүлж, илүү хүртээмжтэй хуулийн үйлчилгээ үзүүлэх боломжтойн зэрэгцээ бидэнд суралцах зүйл их байгааг онцолсон. Түүнчлэн ёс зүй, хувийн нууцтай холбоотой асуудал, зохих зохицуулалтын хэрэгцээ зэрэг томоохон асуудлуудыг дагуулах эрсдэлтэйг мөн дурдаж, хиймэл оюуныг бид тэнцвэртэй ашиглах нь чухал бөгөөд хүний үндсэн эрхийг хамгаалах, шударга ёсыг хангах нь чухал гэдгийг илтгэгч, хэлэлцүүлэгч нар хэлсэн.

10. Цахим шүүх mocktrial 2025 тэмцээн зохион байгууллаа

Иргэний эрх зүйн хороо, Өмгөөллийн “Легал гайд” ХХК-тай хамтран Монголын Хуульчдын холбооны Ерөнхийлөгчийн нэрэмжит иргэний хэргийн шүүхийн мэтгэлцээний “Цахим шүүх-Mock trial 2025” тэмцээнийг 2025 оны зургадугаар сарын 7-ны өдөр зохион байгууллаа.

Тус тэмцээн нь шүүх эрх мэдлийн байгууллагуудын цахимжилтын энэ үед цахим хэлбэрээр, мөн анхан болон давж заалдах шүүхэд иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар зохион байгуулагдсан онцлогтой боллоо. Тэмцээнд:

- 1.“Их засаг” их сургуулийн Хууль зүйн сургуулийн “Цэц” болон “Факт” баг;
- 2.Монгол Улсын их сургуулийн Хууль зүйн сургуулийн “Веритас” болон “Эгүнэ” баг;
- 3.Дотоод хэргийн их сургуулийн “True force” болон “Justice” баг;
- 4.Санхүү, эдийн засгийн их сургуулийн “Акси” болон “UFE Law” баг;
- 5.Олон Улсын “Улаанбаатар” их сургуулийн Хууль зүйн сургуулийн “Legal minds” баг;
- 6.“Шихихутуг” их сургуулийн “Шихихутуг –1- баг;
- 7.“Идэр” их сургуулийн “Lawyers” баг;
- 8.“Сити” их сургуулийн “Advocate” баг оролцсон.



Багууд анхан шатны шүүхэд хянан шийдвэрлэх хоёр хэрэг, давж заалдах шатны шүүхэд хянан шийдвэрлэх хоёр хэргийг тус тус 2025 оны тавдугаар сарын 08-ны өдөр болсон техникийн зөвлөгөөн дээр цахим хэлбэрээр хүлээн авч, нэг сарын хугацаанд бэлтгэсэн юм.

Оюутнууд энэ хугацаанд цахим хавтаст хэргээ судлахын зэрэгцээ онлайнаар шүүх хуралдаанд оролцох өрөө танхим, техник хэрэгслээ бэлтгэж мэтгэлцээндээ оролцсон.

Зохион байгуулагчдын хувьд шүүх эрх мэдлийн байгууллагын цахимжилтын үйл явцыг дэмжихийн зэрэгцээ иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхүүдийн оролцоог хангахын тулд Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүх, Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүхүүд дээр анхан шатны цахим шүүх хуралдааныг нэгэн зэрэг зохион байгуулсан юм.

Мөн зохион байгуулагчдын зүгээс оролцогч сургуулиуд, оюутнуудад зориулж мэтгэлцээний удирдамж, цахим шүүхийн мэтгэлцээнд оролцох гарын авлага, мэтгэлцээний

дүрмийг цахим хэлбэрээр хүргүүлж, мэтгэлцээний бэлтгэл шатанд болон цахим шүүх хуралдааны дараа хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны цахимжилттай холбоотой судалгаа авсан. Түүнчлэн оролцогч багуудыг тус бүрээр танилцуулах цуврал бичлэгийг бэлтгэж олон нийтийн сүлжээнд байршуулсан.



Иргэний хэргийн шүүхийн мэтгэлцээний “Цахим шүүх-Mock Trial 2025” тэмцээнийг 2025 оны зургадугаар сарын 7-ны өдөр ZOOM платформ дээр нээж, мэтгэлцээний зургаан тоглолт нэгэн зэрэг, хоёр тойргийн шүүх дээр явагдсан.

Тэмцээний финалын шатанд Санхүү, эдийн засгийн их сургуулийн “Акси” баг, Монгол Улсын их сургуулийн Хууль зүйн сургуулийн “Эгүнэ” болон “Веритас” багууд шалгарч, давж заалдах шатны шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны

журмаар, тойргийн зарчмаар хоёр хэргээр Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхэд танхимаар мэтгэлцсэн.

Анх удаа цахимаар зохион байгуулсан “Цахим шүүх-Mock Trial 2025” тэмцээний:


🏆 Тэргүүн байранд Монгол Улсын их сургуулийн Хууль зүйн сургуулийн “Веритас” баг шалгарч алтан медаль, өргөмжлөл, 3,000,000 төгрөгөөр;

🥈 Дэд байранд Монгол Улсын их сургуулийн Хууль зүйн сургуулийн “Эгүнэ” баг шалгарч, мөнгөн медаль, өргөмжлөл, 2,000,000 төгрөгөөр;

🥉 Гувдугаар байранд Санхүү, эдийн засгийн их сургуулийн “Акси” баг шалгарч, хүрэл медаль, өргөмжлөл, 1,000,000 төгрөгөөр тус тус шагнагдав.

Мөн мэтгэлцээний шилдэг мэтгэлцэгч-илтгэгчээр Монгол Улсын их сургуулийн Хууль зүйн сургуулийн “Веритас” баг гишүүн Ч.Ариун-Энх шалгарч өргөмжлөл, 500,000 төгрөгөөр шагнуулсан.

11. "Арбитрын хэрэгцээ, шаардлага, тулгамдсан асуудал" подкаст хийлээ



Монголын Хуульчдын холбооны иргэний эрх зүйн цуврал подкастийн хүрээнд Арбитрын хэрэгцээ, шаардлага, тулгамдсан асуудал сэдвээр

🎙 **Зочин:** МҮХАҮТ-ын дэргэдэх Монголын Олон улсын арбитрын дарга, доктор /Ph.D/ С.Энхцэцэг

🎙 **Хөтлөгч:** Монголын хуульчдын холбооны Иргэний эрх зүйн хорооны удирдах зөвлөлийн гишүүн Т.Наранцогт оролцов.

12. Хууль зүйн салбар дахь хиймэл оюун ухааны хэрэглээ, өнөөгийн нөхцөл байдал, шинэчлэл судалгаа зохион байгууллаа

Иргэний эрх зүйн хорооноос “Хууль зүйн салбар дахь хиймэл оюун ухааны хэрэглээ, өнөөгийн нөхцөл байдал, шинэчлэл”-ийн талаарх судалгааг хуулийн салбарын мэргэжилтнүүдийн дунд зохион байгуулж байсан.

13. Иргэний эрх зүйн хорооны тэргүүн олон улсын хуралд илтгэл хэлэлцүүлээ

Иргэний эрх зүйн хорооны Тэргүүн Г.Даваадорж АНЭУ-ын Дубай хотод Шүүхийн захиргааны Олон Улсын хуралд оролцож байна. Тэрээр "Шүүхийн захиргаанд хиймэл оюун ухааны үзүүлэх нөлөө: Монголын туршлага" сэдвээр илтгэл хэлэлцүүлэв.


14. Өмгөөллийн хуулийн этгээдүүдийн туршлага солилцох өдөрлөгт илтгэл хэлэлцүүлээ

Өмгөөллийн хуулийн этгээдүүдийн хөгжлийг дэмжих хорооны санаачилгаар “Өмгөөллийн хуулийн этгээдүүдийн туршлага солилцох өдөрлөг”-ийг 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр зохион байгууллаа. “Хуулийн фирмийн пробоно үйл ажиллагаа” сэдвээр Иргэний эрх зүйн хорооны удирдах зөвлөлийн гишүүн, Өмгөөллийн “Легал гайд” ХХК-ийн Гүйцэтгэх захирал Ч.Отгонбаатар, “Өмгөөллийн хуулийн этгээдүүдийн үйл ажиллагаанд гарч буй хүндрэлүүд, шийдвэрлэх арга замууд” сэдвээр илтгэл хэлэлцүүлж, өөрсдийн туршлагыг хуваалцлаа.

ЭВЛЭРҮҮЛЭН ЗУУЧЛАЛЫГ ДЭМЖИХ АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ХОРООНЫ 2025 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

Нэг. Хорооны Удирдах зөвлөлийн хурал:

Хорооны Удирдах зөвлөл нь тайлангийн хугацаанд нийт 6 удаа хуралдаж, хорооны 2025 оны төлөвлөгөөг хэрэгжүүлэх, Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн төсөлд санал өгөх, Удирддах зөвлөлийн идэвхгүй гишүүдийг чөлөөлөх, сонгох, гишүүдийн нээлттэй өдөрлөг, өглөөний уулзалт зохион байгуулах зэрэг асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэв.



Хоёр. Өглөөний уулзалт зохион байгуулах:

1. “Хөдөлмөрийн харилцаан дахь Эвлэрүүлэн зуучлал” сэдэвт өглөөний уулзалт, хэлэлцүүлгийг 2025 оны хоёрдугаар сарын 18-ны өдөр зохион байгуулж, нийт 30 гаруй хуульч хамрагдав.



2. “Эвлэрүүлэн зуучлалын Олон Улсын туршлага” сэдэвт өглөөний уулзалтыг 2025 оны есдүгээр сарын 26-ны өдөр Хуульчдын ордонд зохион байгуулж, илтгэгчээр Монголын Хуульчдын холбооны гишүүн хуульч, Лондон дахь Маргааныг үр дүнтэй шийдвэрлэх төвийн мэргэшсэн эвлэрүүлэгч, Лондон дахь Итгэмжлэгдсэн арбитражын институтын эрдэмтэн гишүүн, өмгөөлөгч Ц.Санжаалхам, Монголын Хуульчдын холбооны гишүүн хуульч, Олон Улсын Хуульчдын холбооны гишүүн, Гадаад худалдааны маргаанаас урьдчилан сэргийлэх ба шийдвэрлэх Олон улсын байгууллагын хяналтын зөвлөлийн гишүүн, Олон Улсын арбитраж, өмгөөлөгч С.Уянгаа, Монголын Хуульчдын холбооны ахлах мэргэжилтэн, хуульч, судлаач Ж.Бариаширсүрэн нар оролцов.



Гурав. Хорооны гишүүдийн бүртгэлийг шинэчлэх:

Хорооны гишүүдийг идэвхжүүлэх хүрээнд хорооны гишүүдийн бүртгэлийг шинэчлэх ажлыг хэрэгжүүлэв. Бүртгэл шинэчлэхээс өмнө нийт 181 гишүүн бүртгэлтэй байсан бөгөөд үүнээс өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөх хүсэлтэй байгаа гишүүдийг хасалт хийж нийт 170 гишүүн үлдсэн. Үүнээс хойш 47 гишүүн шинээр нэмэгдэж, одоогоор **217** гишүүн тус хороонд бүртгэлтэй байна. Хорооны гишүүдийн бүртгэл шинэчилсэнтэй холбоотой гишүүдийн статистик тоон мэдээллийг нэгтгэн гаргасан.



Дөрөв. Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн төсөлд санал өгөх:



Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулах ажлын хэсэгт хорооны тэргүүн Д.Түмэнжаргал, Удирдах зөвлөлийн гишүүн Э.Цолмон, Э.Одонтуяа нар ажиллаж байна. Энэ хүрээнд тус гишүүдийн зүгээс холбооны дэргэд Тамгын газрын даргаар ахлуулсан ажлын хэсгийг байгуулах санал гаргаж, тус ажлын хэсэг нь нийт 4 удаагийн уулзалтыг зохион байгуулж, Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд Монголын Хуульчдын холбооноос өгөх саналыг боловсруулж, Хууль зүй, дотоод хэргийн сайдад хүргүүлээд байна.

Тав. Хорооны УЗ-ийн гишүүний нөхөн сонгууль зарлах:

Хорооны Удирдах зөвлөлийн идэвхгүй, хуралд оролцдоггүй гишүүдийг чөлөөлөх асуудлыг Удирдах зөвлөлөөр хэлэлцсэн бөгөөд үүний дагуу ажлын ачааллаас болоод хурал, үйл ажиллагаанд оролцох боломжгүй байгаагаа илэрхийлж 2 гишүүн өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөх хүсэлтээ өгсөн. Энэ дагуу хорооны Удирдах зөвлөл хуралдаж, тус хоёр гишүүнийг чөлөөлөх тогтоолыг гаргаж, нөхөх сонгуулийг зарласан. Сонгуульд нийт 5 хуульч нэрээ дэвшүүлснээс 3.Тунгалагмаа, Г.Энхтуяа нар олонхийн санал авсныг Хорооны удирдах зөвлөлийн хурлаар батламжлав.



Зургаа:Гишүүдийн нээлттэй өдөрлөг зохион байгуулах:

Хорооноос гишүүдээ идэвхжүүлэх, хорооны үйл ажиллагааг таниулах зорилгоор нийт гишүүдийнхээ дунд нээлттэй өдөрлөгийг анх удаа 2025 оны 04 дүгээр сарын 26-ны өдөр зохион байгууллаа. Өдөрлөгийг Эвлэрүүлэн зуучлалыг дэмжих асуудал эрхэлсэн хорооны Тэргүүн Д.Түмэнжаргал чиглүүлж явуулсан бөгөөд тэрбээр “Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгагдсан хувийн эвлэрүүлэн зуучлалын шинэчлэл” сэдвээр гишүүдэд мэдээлэл өгч, сонирхсон асуултад хариуллаа. Энэ удаагийн өдөрлөгийг Олон Улсын эрх зүйн хөгжлийн байгууллага хамтран явуулж, тус байгууллагын Төслийн зохицуулагч С.Агьзул “Монгол Улсад арилжааны эвлэрүүлэн зуучлалыг бэхжүүлэх нь” төслийн товч танилцуулгыг хийхийн зэрэгцээ төслийн сургагч багш З.Тунгалагмаа, Д.Түмэнжаргал, Ч.Анар нар оролцогчдод зориулж, “Why mediation? Хуульч нарт эвлэрүүлэн зуучлал яагаад чухал ач холбогдолтой вэ?” сэдвээр ворк шоп явуулсан юм. Мөн өдөрлөгийн хүрээнд тус төслийн үндэсний зөвлөх, сургагч багш, Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны тойргийн шүүхийн шүүгч Ц.Мөнх-Эрдэнэ “Сингапур Улсын эрүү болон зөрчлийн хэрэгт эвлэрүүлэн зуучлах ажиллагааг нэвтрүүлсэн туршлага” сэдвээр сонирхолтой мэдээлэл хуваалцсан.Түүнчлэн Эвлэрүүлэн зуучлалыг дэмжих хорооны Удирдах зөвлөлийн гишүүн Ц.Амарсанаа “Хувь хүний хөгжил” сэдэвт лекц орсонд оролцогчид талархан хүлээж авлаа.



Долоо:Эвлэрүүлэн зуучлагчдыг чадавхжуулах сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулав

“Монгол Улсад арилжааны эвлэрүүлэн зуучлалыг бэхжүүлэх нь” (2023-2025) төслийн хүрээнд **“Арилжааны эвлэрүүлэн зуучлалын чиглэлд эвлэрүүлэн зуучлагчдын чадавхыг бэхжүүлэх”** сургалтыг IDLO-той хамтран 2025 оны тавдугаар сарын 12-13-ны хооронд зохион байгуулав. Тус сургалтад Хорооны тэргүүн Д.Түмэнжаргал, Удирдах зөвлөлийн гишүүн З.Тунгалагмаа сургагч багшаар, УЗ-ийн гишүүн Ц.Амарсанаа илтгэгчээр оролцсон бол УЗ-ийн гишүүн Э.Цолмон, Г.Энхтуяа, хорооны гишүүн Э.Одончимэг, Г.Ган-Эрдэнэ, Д.Наранцэцэг, Б.Тогоодулам, С.Бүжинлхам нар оролцлоо.



'Why mediation?, Why for businesses?' сэдэвт мэдээлэл хүргэх арга хэмжээг Дархан-Уул аймагт зохион байгуулсан бөгөөд Дархан-Уул аймагт хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэрлэл, барилга, уул уурхай, хүнсний үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй бизнес эрхлэгчид, эрдэмтэн судлаач, нотариатч, хуульч, өмгөөлөгч, шүүхийн байгууллагын нийт 50 гаруй төлөөлөл оролцов.



Эвлэрүүлэн зуучлалыг дэмжих асуудал эрхэлсэн хорооноос санаачлан **'Why mediation? Why for Lawyers?'** сэдэвт сургалт, хэлэлцүүлгийг 2025 оны 11 дүгээр сарын 19-ний өдөр зохион байгуулав. Монголын Хуульчдын холбоо болон Монголын Өмгөөлөгчдийн холбооны гишүүн хуульч, өмгөөлөгч, шүүгч, эвлэрүүлэн зуучлагч, нотариатч зэрэг 60 гаруй төлөөлөл оролцож, эвлэрүүлэн зуучлал нь шүүхийн бус журмаар маргааныг шийдвэрлэх үр дүнтэй ажиллагаа болох талаар сургалтад хамрагдаж, Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгагдсан арилжааны эвлэрүүлэн зуучлалын шинэчлэлийн талаар хэлэлцүүлэг өрнүүлж, эвлэрүүлэн зуучлалын эрх зүйн орчныг боловсронгуй болгох, үүний үр дүнд арилжааны болон бизнесийн шинжтэй маргааныг илүү үр дүнтэй шийдвэрлэх, шүүхийн ачааллыг бууруулах болон олон нийтийн эвлэрүүлэн зуучлалд итгэх итгэлийг нэмэгдүүлэхэд чиглэлээр санал солилцсон.



Найм.Холбооны үйл ажиллагаанд хороог төлөөлөн оролцох:



"Монгол Улсад жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааг бэхжүүлэх" төслийн хоёр дахь шатыг Канад Улсын Засгийн газрын санхүүжилтээр 5 жилийн хугацаанд хэрэгжүүлэхээр баталсан бөгөөд Монголын Хуульчдын холбоо нь тус төслийн хүрээнд гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагаанд хохирогч төвтэй хандлагыг төлөвшүүлэх, жендерт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэхэд хуульчдын ур чадвар, ойлголтыг нэмэгдүүлэх чиглэлээр хамтарч ажиллахаар болсон. Төслийн талаар санал солилцох Олон Улсын эрх зүйн хөгжлийн байгууллагын

суурин төлөөлөгч Чарльз Болландтэй уулзах уулзалтад Эвлэрүүлэн зуучлалыг дэмжих хорооны тэргүүн Д.Түмэнжаргал оролцов.


Ес."Арилжааны эвлэрүүлэн зуучлал" гарын авлага хэвлүүлэх:

Европын холбооны санхүүжилтээр Олон Улсын эрх зүйн хөгжлийн байгууллагаас "Монгол Улсад Арилжааны эвлэрүүлэн зуучлалыг бэхжүүлэх нь (2023-2025) төслийг хэрэгжүүлж байгаа билээ. Тус төслийн хүрээнд "Арилжааны эвлэрүүлэн зуучлал" гарын авлагыг хэвлүүлээ. Тус гарын авлагыг боловсруулахад Монголын Хуульчдын холбоо нь хамтран ажилласан бөгөөд холбооны Эвлэрүүлэн зуучлалыг дэмжих хорооны тэргүүн Д.Түмэнжаргал, Удирдах зөвлөлийн гишүүн З.Тунгалагмаа нар оролцов.

Арав. Хуульчдад эвлэрүүлэн зуучлалын үйл ажиллагааг хэрэгжүүлж байхыг уриалах:



Эрх зүйн маргааныг шүүхийн бус аргаар шийдвэрлэх нь талуудын цаашдын хамтын ажиллагаа хэвийн үргэлжлэх, найрсаг харилцааг хадгалж үлдэх зэрэг тал бүрийн ач холбогдолтой. Энэ талаар Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 24 дүгээр зүйлд хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны төрлийг тодорхойлохдоо 24.1.4-д "нэхэмжлэл, хүсэлтийг шийдвэрлэх, хохирол барагдуулахад чиглэсэн аливаа зөвшилцөх, эвлэрүүлэх үйл ажиллагаа явуулах" хэмээн хуульчилж өгсөн байдаг. Иймд хуульчдыг эвлэрүүлэх үйл ажиллагааг мэргэжлийн түвшинд, чадварлаг хэрэгжүүлж байхыг уриалав.




Арваннэг. Хорооны гишүүдээ шагнаж, урамшуулах:

Хорооны дөрвөн гишүүнийг Хууль зүйн албаны тэргүүний ажилтан Хүндэт тэмдгээр шагнуулахаар тодорхойлж, холбогдох эрх бүхий байгууллагад уламжил өгөхийг хүссэн албан бичгийг Тамгын газрын дарга Ш.Жолбарст хүргүүлэв.

Арванхоёр. Гишүүдээ мэдээллээр хангах:

Хорооны гишүүдэд Холбоо болон Хорооны мэдээллийг түргэн шуурхай хүргэх хүрээнд фэйсбүүк хуудас, хаалттай групп нээн удирдаж, мэдээллээ тогтмол нийтэлж байна. Мөн бүх гишүүддээ 2023-2025 оны тайланг и-мэйлээр нь хүргүүлэв.



Арвангурав.Хуульчдад зориулсан эвлэрүүлэн зуучлалын хөтөлбөрийг магадлан итгэмжлүүлэв:



Эвлэрүүлэн зуучлалыг дэмжих хороо, Шүүхийн Ерөнхий зөвлөлийн дэргэдэх Эвлэрүүлэн зуучлагчдын зөвлөлийн төлөөлөл уулзаж, хуульчдад зориулсан эвлэрүүлэн зуучлалын сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах асуудлаар ярилцсан.

Энэхүү уулзалтаар хуульчдад зориулсан эвлэрүүлэн зуучлалын сургалтын хөтөлбөрийг орчин үеийн сургалтын арга зүй, хэлбэр, шаардлагад тулгуурлан видео болон

танхимын хэлбэрээр боловсруулж, магадлан итгэмжлүүлэхээр Хуульчийн үргэлжилсэн сургалтын асуудал эрхэлсэн хороонд хүргүүлсэн бөгөөд Сургалтын хорооноос тус хөтөлбөрийг магадлан итгэмжилж шийдвэрлэлээ.

Арвандөрөв. Эвлэрүүлэн зуучлалын талаар олон нийтэд мэдээлэл өгөх:

Гэр бүлийн эвлэрүүлэн зуучлалын асуудлаар Хорооны Удирдах зөвлөлийн гишүүн Г.Энхтуяа “Өнөөдөр” сонинд мэдээлэл, ярилцлага өгөв.



Арвантав. “Арилжааны эвлэрүүлэн зуучлалыг бэхжүүлэх нь” төслийг амжилттай хэрэгжүүллээ

Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллагаас санаачилсан “Монгол Улсад арилжааны эвлэрүүлэн зуучлалыг бэхжүүлэх нь” төслийг Монголын Хуульчдын Холбооны дэргэдэх Эвлэрүүлэн зуучлалыг дэмжих асуудал эрхэлсэн хороо 2023-2025 онд хамтран хэрэгжүүлж, хаалтаа хийлээ. Тус төслийн хүрээнд Эвлэрүүлэн зуучлалын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг дагалдах судалгааны хамт боловсруулах, эвлэрүүлэн зуучлагчдын чадавхыг бэхжүүлэх, болон олон нийт, бизнес эрхлэгчдэд арилжааны эвлэрүүлэн зуучлалыг сурталчлан таниулах гэх мэт олон талт үйл ажиллагааг хэрэгжүүлсэн.

ӨМГӨӨЛЛИЙН НӨХӨРЛӨЛИЙН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ХОРОО

1. “Хуулийн фирмийн менежмент, хөгжил, чиг хандлага” сэдэвт уулзалт, хэлэлцүүлэг зохион байгууллаа

Монголын Хуульчдын холбоо, Өмгөөллийн нөхөрлөлийн хөгжлийг дэмжих хороо хамтран өмгөөллийн хуулийн этгээдүүд болон хуульч, өмгөөлөгчдийн дунд “Хуулийн фирмийн менежмент, хөгжил, чиг хандлага” сэдэвт уулзалт, хэлэлцүүлгийг 2025 оны нэгдүгээр сарын 30-ны өдөр зохион байгууллаа.

Тус хэлэлцүүлгийг Монголын Хуульчдын холбооны Ерөнхийлөгч П.Одгэрэл, Өмгөөллийн нөхөрлөлийн хөгжлийг дэмжих хорооны тэргүүн Д.Түвшинтамир нар нээж үг хэлсэн. Хэлэлцүүлгийн чиглүүлэгчээр тус хорооны Удирдах зөвлөлийн гишүүн, Б.Батцэнгэл ажилласан. Хэлэлцүүлгийн хүрээнд холбооны гишүүн хуульч, арбитрч, Олон улсын Хуульчдын холбооны гишүүн өмгөөлөгч С.Уянгаа “Танай хуулийн фирм орчин цагт нийцэж байна уу?” сэдвээр, Монголын хуульчдын холбооны гишүүн хуульч, Олон улсын Хуульчдын холбооны гишүүн өмгөөлөгч С.Отгонжаргал “Хуулийн фирмүүд хиймэл оюун ухааныг ашиглах тухайд” сэдвээр тус тус илтгэл тавьж, хэлэлцүүллээ.

Цаашид “Хуулийн фирмийн менежмент, хөгжил, чиг хандлага” сэдэвт сургалт, уулзалт, хэлэлцүүлгийг цувралаар зохион байгуулахаар төлөвлөсөн.



2. “Өмгөөллийн хуулийн этгээдүүдийн форум-2025” боллоо

Өмгөөллийн нөхөрлөлийн хөгжлийг дэмжих хорооноос Хуульчийн үргэлжилсэн сургалтын асуудал эрхэлсэн хорооны дэмжлэгтэйгээр “Өмгөөллийн хуулийн этгээдүүдийн форум-2025” үйл ажиллагааг 2025 оны хоёрдугаар сарын 21-ний өдөр анх удаа зохион байгууллаа. Форумын хүрээнд Монголын Хуульчдын холбооны гишүүн, өмгөөлөгч Ө.Эрдэнэ-Очир, Татварын мэргэшсэн зөвлөх С.Баярхүү нар “Өмгөөллийн хуулийн этгээдийн татварын

орчин” сэдвээр, өмгөөллийн “Анта партнерс” ХХК-ийн гүйцэтгэх захирал М.Энхжин “Өмгөөллийн үйл ажиллагааны зах зээлийн орчин” сэдвээр, “ЭмДиЭс ХаанЛекс” ХХН-ийн гүйцэтгэх захирал Ж.Майзориг “Хиймэл оюун ухаан (AI) хуулийн салбарт нөлөөлөх нь, цаашдын чиг хандлага” сэдвээр тус тус илтгэл хэлэлцүүлж, хуульчдын асуултад хариулж, санал солилцсон. Мөн Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн цахимжилтын газрын дарга Б.Мөнхбаяр “Шүүхийн цахимжилт”, “Хялбар ажиллагааны шүүхийн цахимжилт” сэдвээр мэдээлэл өгсөн.

Тус форумгаас өмгөөллийн хуулийн этгээдүүдийн татварын орчинг сайжруулах, харилцан сайн туршлага солилцох, шинэ техник технологийг нэвтрүүлэх талаар санал, зөвлөмж гаргасан бөгөөд форумгаас гарсан зөвлөмжийг холбогдох байгууллагуудад хүргүүлэх болно.

Монгол Улсад анх удаа өмгөөллийн хуулийн этгээдүүд нэгдэн чуулж, тулгамдаж буй асуудлаа хэлэлцсэн тус форумыг 10 өмгөөллийн хуулийн этгээд ивээн тэтгэж ажилласан. Үүнд:

- ✚ "Анта партнерс" ХХН;
- ✚ "Дашням Партнерс" ХХК;
- ✚ "Легал полиси" ХХН;
- ✚ "Легал гайд" ХХН;
- ✚ "Нийслэл адвокатс" ХХК;
- ✚ "LPC консалтинг" ХХК;
- ✚ "Lex консалтинг" ХХК;
- ✚ "Монгол өмгөөлөгч" ХХН;
- ✚ "Хэруга партнерс" ХХН;
- ✚ "Legal Service center" төв;
- ✚ "Онч нүүдэл" ХХН;
- ✚ "Эл Би партнерс" ХХК зэрэг юм.

Тус форумын үеэр Монголын Хуульчдын холбооны Тамгын газрын дарга Ш.Жолбарс Хуульчдын ордны талаарх танилцуулгыг хийж, хуульчид анх удаа өөрийн байртай болж буй уг үйл ажиллагаанд өмгөөллийн хуулийн этгээдүүдийг хандив өгөхийг уриалсан. Энэхүү уриалгад дараах өмгөөллийн хуулийн этгээдүүд нэгдсэн юм.



3.Өмгөөллийн хуулийн этгээдүүдийн төлөөлөлтэй уулзлаа

Азийн про боно 13 дахь чуулга уулзалтыг 2025 оны 10 дугаар сарын 03-05-ны өдрүүдэд Монголд зохион байгуулах бэлтгэл ажлын хүрээнд Азийн про боно чуулга уулзалтыг санаачлагч “Babseacle” байгууллагын Ерөнхий захирал Брюс Ласки, Гүйцэтгэх захирал Вэнди Морриш нар өнөөдөр өмгөөллийн хуулийн этгээдийн төлөөлөлтэй өглөөний уулзалт зохион



байгууллаа. Уулзалтаар Азийн про боно чуулга уулзалтын талаар мэдээлэл өгч, өмгөөллийн хуулийн этгээдүүд хуульчийн про боног хэрхэн явуулдаг талаарх улс орнуудын туршлагыг хуваалцаж, санал солилцсон.

4. “Хүүхэд бүр ялагч-хүүхэд бүр хамгаалагч” марафоныг хуулийн фирмүүд дэмжин оролцлоо

“Хүүхэд бүр ялагч-Хүүхэд бүр хамгаалагч” марафоныг ХЭҮК-оос хоёр дахь жилдээ зохион байгуулсан бөгөөд Монголын Хуульчдын холбооноос тус үйл ажиллагааг дэмжиж хамтран ажиллалаа. Марафонд 7-17 насны 6000 орчим хүүхэд 6-7, 7-8, 8-9, 9-10, 12-13, 14-15, 16-17 насны ангиллаар оролцсон. Мөн энэ үеэр “Хүслийн хайрцаг”, “The Open Mic” болон зураг авч, цахим шуудангаар хүргүүлэх, хүүхдийн эрхийн чиглэлээр мэдлэг олгох, Замын хөдөлгөөний дүрмийн мэдээлэл өгөх зэрэг үйл ажиллагааг зохион байгуулсан. Энэхүү үйл ажиллагааг дэмжиж хүүхдийн эрхийн төлөө хамтран ажилласан өмгөөллийн “Легал полиси” ХХК, “Дашням партнерс” ХХК, “Нийслэл адвокатс” ХХК дэмжиж, ивээн тэтгэж оролцлоо.

5. “Хуульчийн про боно өдөрт өмгөөллийн нөхөрлөлүүд оролцлоо

Сүхбаатарын талбайд зохион байгуулж буй өдөрлөгт Өмгөөллийн “Легал гайд” ХХН, “Сноухилл консалтанси” ХХН, Өмгөөллийн “Цогц өмгөөлөл” хууль зүйн фирм, Өмгөөллийн Легал полиси ХХН, “Легас атторнийз” хуулийн фирм, “Легал сервис” ХХН, “Эм Жи Эл атторнийз” хуулийн фирм, “Чирха өвгөн” ХХН, “Компасс консалтинг” хууль зүйн фирм, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Клиник сургалтын төв, “Анбаунд Монгол” ТББ, Монголын Барилгын Үндэсний Ассоциаци зэрэг 20 гаруй байгууллага оролцож иргэдэд хууль, эрх зүйн анхан шатны зөвлөгөө мэдээлэл өгч, төрийн зарим үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлсэн.

6. Өмгөөллийн хуулийн этгээдүүдийн туршлага солилцох өдөрлөг боллоо



Өмгөөллийн хуулийн этгээдүүдийн хөгжлийг дэмжих хорооны санаачилгаар “Өмгөөллийн хуулийн этгээдүүдийн туршлага солилцох өдөрлөг”-ийг 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр зохион байгууллаа. Өдөрлөгт “Хуулийн фирмийн өнөөгийн нөхцөл байдал, ирээдүйн чиг хандлага” сэдвээр Өмгөөллийн “Дашням партнерс” ХХК-ийн үүсгэн байгуулагч, партнер Д.Золжаргал, “Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа олон улсын хуулийн фирмийн онцлог, давуу тал” сэдвээр “Грата Интернэшнл Монголиа” ХХН-ийн Партнер В.Болормаа, “Технологийн салбар дагнасан зөвлөх үйлчилгээний онцлог, туршлага” сэдвээр Өмгөөллийн “Виндекс ХХН-ийн Партнер, Гүйцэтгэт захирал

Б.Наранцэцэг, “Хуулийн фирмийн пробоно үйл ажиллагаа” сэдвээр Өмгөөллийн “Легал гайд” ХХК-ийн Гүйцэтгэх захирал Ч.Отгонбаатар, “Өмгөөллийн хуулийн этгээдүүдийн үйл ажиллагаанд гарч буй хүндрэлүүд, шийдвэрлэх арга замууд” сэдвээр Өмгөөллийн хуулийн этгээдүүдийн хөгжлийг дэмжих хорооны тэргүүн, Өмгөөллийн “Анта партнерс” ХХК-ийн Ерөнхий захирал Д.Түвшинтамир нар тус тус илтгэл хэлэлцүүлж, өөрсдийн туршлагыг хуваалцлаа.

ЭДИЙН ЗАСГИЙН ЭРХ ЗҮЙН ХОРОО

Нэг. “Law and Economics” цуврал уулзалт:

Монголын Хуульчдын холбооны Эдийн засгийн эрх зүйн хорооны Удирдах зөвлөлийн гишүүдийн санаачилгаар хорооны гишүүдийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн өглөөний

цайтай цуврал уулзалт, ярилцлагыг 2023 оноос “Law and Economics” нэрийн дор зохион байгуулж байна.



1.1. "Law and Economics #04" цуврал өглөөний уулзалтыг **“Хөрөнгө оруулагчдад хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэхэд хуульчийн зүгээс анхаарвал зохих асуудлууд”** сэдвээр 2025 оны 03 сарын 26-ны өдөр зохион байгуулав. Тус уулзалтын панелистаар "Грата Интернэшл Монголиа" олон улсын хуулийн фирмийн партнер, “Бизнесийн эрх зүй” номын зохиогч В.Болормаа оролцож, хөрөнгө оруулагчдад хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлэхэд анхаарах асуудлууд, хууль зүйн мэдээллийг тогтмол бэлтгэхийн ач холбогдол, олон

улсын хуульчийн рэйкингийн талаар мэдээлэл өгөхийн зэрэгцээ үйлчлүүлэгчийнхээ талаар судлах хэрэгцээ шаардлага зэрэг олон дэд сэдвээр сонирхолтой ярилцлага өрнүүлж, өөрийн туршлагыг хуваалцав. Мөн энэ үеэр англи, монгол хэлээр хэвлүүлсэн “Бизнесийн эрх зүй” бүтээлээ танилцууллаа.

1.2. "Law and Economics #05" цуврал өглөөний уулзалтын уулзалтын ээлжит дугаарт Монголын Хуульчдын холбооны гишүүн, АНУ-ын Нью-Йорк мужийн барын холбооны шалгаруулалтад тэнцсэн хуульч, Би Ди Эф Инвестор ХХК-ийн Хуулийн бодлогын зөвлөх Э.Цэлмэг хүрэлцэн ирж **“Компанийн эд хөрөнгө хувьцаа эзэмшигчийн эд хөрөнгөөс зааглагдах зарчим” /Commingling of Funds and Assets of company and its shareholder/** сэдвээр хэлэлцүүлэг өрнүүлээ.

Тус сэдвийн хүрээнд компанийн тухай ойлголтууд, Компанийн тухай хуулийн зохицуулалт, Монгол Улсын шүүхийн практик, АНУ шүүхийн практикийн талаар мэдээлэл солилцож өнөөгийн хэрэгжиж буй хууль, эрх зүйн хүрээнд шаардлагатай зохицуулалтын талаар харилцан яриа өрнүүлсэн юм.

1.3. "Law and Economics #06" цуврал өглөөний уулзалтын ээлжит дугаарт Монголын Хуульчдын холбооны гишүүн хуульч, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Т.Баясгалан оролцож, **“Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хэрэгцээ, шаардлага”** сэдвээр хэлэлцүүлэг өрнүүлээ.



Тэрээр одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль нь 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдөр баталж, 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн бөгөөд тус хуульд 2023 оны 06 дугаар сараас хойш жил хагасын хугацаад гурван удаа нэмэлт, өөрчлөлт оруулсныг дурдаад Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр түншлэлийн төслийн үе шатыг

хялбарчлах, хамрах хүрээг өргөтгөх, төсөлд тавигдах шаардлагыг багасгах, орон нутгийн бие даасан оролцоог дэмжих, төслийн явц, гүйцэтгэл, хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулж, эрсдэлийг бууруулах хэрэгцээ шаардлага байгааг онцоллоо.

1.4. "Law and Economics #07" цуврал өглөөний уулзалтын ээлжит дугаарт "Улаанбаатар хотын худалдааны танхим"-ын Гүйцэтгэх захирал, эдийн засагч Б.Хаш-Эрдэнэ оролцож, "Арилжааны арбитрын онцлог, хэрэгцээ шаардлага" сэдвээр яриа өрнүүлээ.



Уулзалтын хүрээнд өнөөгийн манай бизнесийн орчинд бизнесийн мэргэшсэн хуульчдын ач холбогдлыг дурдаж арилжааны арбитрын үйл ажиллагаанд оролцох, дэмжлэг үзүүлэх ач холбогдлын талаар



ярилцлаа. Арилжааны арбитр нь талууд бизнесийн хүрээний асуудлаа өөрсдөө хэлэлцэн тохиролцож, харилцан шийдвэрлэх боломжийг олгодог онцлог давуу талтай юм.

Хоёр. Эдийн засгийн эрх зүйн салбараар бодлогын нөлөөлөл үзүүлэх, Монголын Хуульчдын холбооны үйл ажиллагааг бэхжүүлэх чиглэлээр:



2.1. Эдийн засаг, хөгжлийн яамтай хамтын ажиллагааны санамж бичиг байгууллаа. Монголын Хуульчдын холбоо, Эдийн засаг хөгжлийн яам хамран ажиллахаар санамж бичиг байгуулж, Монголын Хуульчдын холбооны Тамгын газрын дарга Ш.Жолбарс, Эдийн засаг, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга И.Батхүү нар 2025 оны 04 дүгээр сарын 09-ний өдөр гарын үсэг зурж баталгаажууллаа.

Санамж бичгийн хүрээнд талууд Монгол Улсын урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгийг удирдлага болгон эдийн засаг, хөрөнгө оруулалт, худалдаа, шинжлэх ухаан, технологийн салбарын хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгоход мэргэжлийн дэмжлэг, туслалцаа үзүүлэх, эдийн засаг, төр, хувийн хэвшлийн түншлэл, шинжлэх ухаан, технологийн чиглэлээр хуульчдад болон бусад оролцогчдод хамтран сургалт, зөвлөгөөн, хэлэлцүүлэг зохион байгуулах, хууль тогтоомжийн төсөл боловсруулах ажиллагаанд хуульчдын оролцоог хангах чиглэлээр хамтран ажиллана. Тус санамж бичгийг гурван жилийн хугацаатайгаар байгуулж буй бөгөөд хамтын ажиллагааны хүрээнд талууд ажлын төлөвлөгөө гарган ажиллаж, түүний хэрэгжилт, тайланг жил бүр дүгнэн хэлэлцэж, үр дүнг, эхний улиралд тооцож ажиллахаар тохиролцлоо.

Санамж бичиг зурах ёслолын ажиллагааны дараа Эдийн засгийн, хөгжлийн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Т.Баясгалан Монголын Хуульчдын холбооны Тамгын газрын дарга Ш.Жолбарсыг хүлээн авч уулзаж, цаашид авч хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, гүйцэтгэлийн талаар ярилцав.

2.2 “Татварын шинэчлэл-дигитал шийдэл” сэдэвт уулзалт, хэлэлцүүлэг:



"Татварын хөгжил дэвшил" холбооноос санаачлан "Татварын шинэчлэл-дигитал шийдэл" сэдэвт уулзалт, хэлэлцүүлгийг 2025 оны тавдугаар сарын 8-ны өдөр зохион байгууллаа.

Тус уулзалтад Монголын Хуульчдын холбоо, Сууц өмчлөгчдийн холбоо, Эм ханган нийлүүлэх холбоо, Монголын барилгын үндэсний ассоциаци, Авто тээвэрчдийн нэгдсэн холбоо гэх зэрэг байгууллагын төлөөллүүд оролцож татварын багц хуулийн шинэчлэлтийн талаар санал солилцож, өөрсдийн

салбарт татвартай холбоотойгоор тулгамдаж буй асуудлуудыг хэлэлцсэн.

Энэхүү уулзалт хэлэлцүүлэгт Монголын Хуульчдын холбоог төлөөлөн Эдийн засгийн эрх зүйн хорооны тэргүүн Б.Баасандорж оролцож, хууль зүйн салбарт тулгамдаж буй асуудлаар байр сууриа илэрхийлж, санал солилцсон юм.

Монгол Улсад үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуй нэгжүүд нь орлогын албан татвар, НӨАТ, Нийгмийн даатгалын шимтгэл гэх татварууд төлөхөөс гадна ажил гүйцэтгэх гэрээнээс нийгмийн даатгал авч буй нь компаниудад татвараа төлж дийлэхгүй нөхцөл байдал үүсгэж байгаа бөгөөд татварын өртэйн улмаас тендерт орж чадахгүй байх, байгууллагын данс хаах, хориг тавих нь тухайн компани үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх боломжгүй болж байгаа тохиолдлуудыг уулзалтад оролцсон хувийн хэвшлийн төлөөллүүд дурдлаа.

Түүнчлэн Татварын багц хуулийг шинэчлэхдээ үндэслэлтэй тооцоо судалгаа, үнэлгээ хийх зайлшгүй шаардлагатайг онцолж, энэ хууль нь татвар төлөгчдөд таатай орчин бүрдүүлэх, үйл ажиллагаа эрхлэгчдийг өрсөлдөх чадвартай байлгах зорилготой учраас багцаар нь шинэчилж, зарчмын өөрчлөлт хийх, татварын алба, татвар төлөгчийн үйл ажиллагааны тэнцвэрт байдлыг хангах, “татвар төлөгдөхгүйц байх” зарчмыг хуульд тусгаж, Татварын хуулийн шинэчилсэн төслийг боловсруулахдаа одоогийн хуулийн заалт бүрээр үнэлгээ хийх гэх зэрэг асуудлыг уламжилсан бөгөөд бөгөөд тус байгууллагуудын зүгээс саналуудыг нэгтгэн холбогдох төрийн байгууллагад хүргүүлэхээр боллоо.

Гурав. Хуульчийн үргэлжилсэн болон албан бус сургалтыг зохион байгуулах чиглэлээр:

3.1. Эдийн засгийн эрх зүйн хорооноос 2025 онд зохион байгуулах сургалтын хэрэгцээ, шаардлагыг тандан судалж шинэ сэдвээр сургалт бэлтгэх зорилгоор 2025 оны 01 дүгээр сарын 21-ний өдөр судалгааны санал асуулга, асуумж авсан билээ.

Хорооны зүгээс сургалтыг “цахим, танхим хосолсон” болон “танхимаар”, “цахимаар” зэрэг олон хэлбэрээр аль болох хүртээмжтэй байдалд анхаарч ажиллахыг эрмэлзэн, сургалтын хөтөлбөр боловсруулж байна.

3.2. “Бизнесээ томруулъя” жижиг, дунд бизнес эрхлэгчдийн чуулга уулзалтад оролцлоо.



“Бизнесээ Томруулъя” төрийн бус байгууллагаас жижиг, дунд бизнес эрхлэгчдэд бизнесээ томруулж, ашгаа нэмэгдүүлэхэд нь туслах зорилготой “Бизнесээ томруулъя” чуулга уулзалтыг 2025 оны тавдугаар сарын 31-ний өдөр зохион байгууллаа. Монголын Хуульчдын холбоо нь тус байгууллагатай хамтран ажиллах санамж бичиг байгуулсан бөгөөд энэ хүрээнд Монголын Хуульчдын холбооны Гадаад харилцаа, хамтын ажиллагааны зөвлөх хуульч, өмгөөлөгч Ц.Одонжав “**Бизнесийн үйл ажиллагаанд гэрээ, хэлцэл хэрхэн хийх, түүний үзүүлэх нөлөө**” сэдвээр, Өмгөөллийн “Цогц өмгөөлөл” хууль зүйн фирмийн гүйцэтгэх захирал, өмгөөлөгч О.Билгүүн “**Хөдөлмөрийн хуулийн шинэлэг зохицуулалт**” сэдвээр, “HR Consulting Firm”-ийн гүйцэтгэх захирал Ш.Баярмагнай “**Бизнес эрхлэгч ба хөдөлмөрийн хуулийн анхаарах зүйл**” сэдвээр, Өмгөөллийн “Компасс консалтинг” хуулийн фирмийн үүсгэн байгуулагч, өмгөөлөгч О.Билгүүн “**Компанийн засаглал**” сэдвээр бизнес эрхлэгчдэд тулгарч буй асуудалд шийдэл олоход туслах зорилгоор үнэ төлбөргүй сургалт орж, хууль зүйн асуудлаар зөвлөгөө өглөө.

Дөрөв. Хорооны үйл ажиллагаа, хууль тогтоомж дахь эдийн засгийн зохицуулалтыг нийтэд сурталчлах:

4.1. “Татварын шинэчлэл-Хувийн хэвшлийн оролцоо” сэдэвт хэлэлцүүлэг:

Эдийн засгийн эрх зүйн хороо, Улаанбаатар хотын худалдааны танхим хамтран "Татварын шинэчлэл-Хувийн хэвшлийн оролцоо" сэдэвт хэлэлцүүлгийг 2024 оны нэгдүгээр сарын 14-ний зохион байгууллаа.

Монгол Улсын татварын орчныг сайжруулах, татварын багц хуулийн хэрэгжилтийн талаар хувийн хэвшлийнхний саналыг нэгтгэн холбогдох төрийн байгууллагуудад хүргүүлэн, шийдвэрлүүлэх замаар эдийн засгийн хөгжлийг дэмжих, хувийн хэвшлийн үйл ажиллагаа, цар хүрээг өргөжүүлэх зорилгоор тус хэлэлцүүлгийг зохион байгуулсан бөгөөд Улаанбаатар хотын худалдааны танхимын Гүйцэтгэх захирал Б.Хаш-Эрдэнэ **“Татварын багц хуулийн өөрчлөлтийн талаарх хувийн хэвшлийн нэгдсэн санал”** сэдвээр, Монголын Хуульчдын холбооны Эдийн засгийн эрх зүйн хорооны тэргүүн Б.Баасандорж **“Татварын шинэчлэл: Эрх зүйн зохицуулалтын үр нөлөө”** сэдвээр тус тус илтгэл тавьж, мэдээлэл өглөө.

Хэлэлцүүлгээр хувийн хэвшлийнхэн санал бодлоо хуваалцаж, өөрт тулгамддаг асуудлуудаа хэлэлцсэн бөгөөд оролцогчдоос гарсан саналуудыг тусган холбогдох байгууллагуудад уламжлахаар шийдвэрлэлээ.

4.2. Эдийн засгийн эрх зүйн хорооны Удирдах зөвлөлийн гишүүн хуульч, өмгөөлөгч Б.Баяраагийн “Үндэслэлгүй хэт өндөр тогтоосон татварын дарамтын улмаас аж ахуйн нэгжүүд ээлж дараалан үүд хаалгаа барьсаар байна” ярилцлагыг 2025 оны нэгдүгээр сарын 22-нд холбоны www.mglbar.mn цахим хуудаст нийтэллээ.

4.3. "Компани өөрийн хөрөнгөөс хувь нийлүүлсэн хөрөнгөө нэмэгдүүлэхэд ногдол ашгийн татвар төлөх үү?" сэдэвт хэлэлцүүлэг:

Монголын Хуульчдын холбооны Захиргааны эрх зүйн хорооноос санаачлан Эдийн засгийн эрх зүйн хороотой хамтран 2025 оны нэгдүгээр сарын 31-ний өдөр “Компани өөрийн хөрөнгөөс хувь нийлүүлсэн хөрөнгөө нэмэгдүүлэхэд ногдол ашгийн татвар төлөх үү? Улсын дээд шүүхийн шийдвэр, тусгай саналын жишээн дээр” сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгууллаа.



Тус хэлэлцүүлгээр Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн 2024 оны нэгдүгээр сарын 03-ны өдрийн 21 дугаартай шийдвэр, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2024 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн 353 дугаартай магадлал, Улсын дээд шүүхийн Захиргааны хэргийн хяналтын шатны шүүх хуралдааны 2024 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 84 дугаартай тогтоол, мөн тогтоолд бичсэн Улсын дээд шүүхийн шүүгчийн тусгай саналтай кэйсийг тойрч хөндлөнгийн бөгөөд мэргэжлийн агуулга бүхий хэлэлцүүлгийг өрнүүллээ.

Мөн тухайн кэйст санхүүгийн тайлагнал, нягтлан бодох бүртгэлийн үүднээс хөндлөнгийн судлаачийн байр сууриа дүгнэлтийн хэлбэрээр Санхүү эдийн засгийн их сургуулийн ахлах багш Ч.Өнөржаргал танилцуулсан.

Эдийн засгийн эрх зүйн хорооны тэргүүн, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн санхүү, татварын эрх зүйн багш Б.Баасандорж тус хэлэлцүүлгийг дүгнэж хаалаа. Тэрээр Захиргааны эрх зүйн хороонд талархлаа илэрхийлж, хууль тогтоомжийн шинэчлэлийг хийхэд Монголын Хуульчдын холбооны хувь нэмэр чухал болохыг онцолж хуульчдын хамтын ажиллагааг өргөжүүлэхийг хичээж ажиллахаа илэрхийлсэн.

Хэлэлцүүлгийг дүгнэж хаасан үгийн хувьд санхүү, татварын салбарын эрх зүйн хэм хэмжээг тайлбарлахад мэргэжлийн бүртгэл, олон улсын стандартын ач холбогдол өндөр учир

хэм хэмжээг хэрэглэхдээ хуулийн зорилго, үгийн утгыг харгалзахын зэрэгцээ цаад системийг давхар харахын чухлыг онцолсон. Мөн татварын эрх зүйд аналог буюу төсөөтэй хэрэглэх нь зөвшөөрөгдөхгүй бөгөөд энэ нь татварыг зөвхөн хуулиар ногдуулах Үндсэн хуулийн зарчмаас урган гардаг болохыг тэмдэглэж татварын хууль тогтоомж дахь материаллаг хэм хэмжээг татварын эрх зүйн үүднээс хөгжүүлэхгүй бол татвар төлөгчийн эрх ашиг зөрчигдсөн хэвээр байхыг дурдаж хэлэлцүүлгийг хаалаа.

Цаашид Захиргааны эрх зүйн хороо болон Эдийн засгийн эрх зүйн хороо хамтран энэ чиглэлээр цуврал хэлэлцүүлгийг зохион байгуулахаа илэрхийлэв.

4.4 Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцүүлэг:

Монголын Хуульчдын холбоо, Эдийн засгийн эрх зүйн хорооноос УИХ-ын гишүүн Б.Түвшингийн Ажлын албатай хамтран Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцүүлгийг хуульчид, хувийн хэвшил, бизнес эрхлэгч, иргэдийн дунд 2025 оны дөрөвдүгээр сарын 08-ны өдөр зохион байгууллаа. Хэлэлцүүлгийн хүрээнд Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг УИХ-ын гишүүн, хуульч санаачлагч Б.Түвшин танилцуулж, чиглүүлэгчээр Монголын Хуульчдын холбооны Тамгын газрын дарга Ш.Жолбарс, хуульч Б.Төрболд нар ажиллаж, хэлэлцүүлэгчээр хуульч Б.Солонго, П.Баттулга нар оролцсон. Мөн хэлэлцүүлгийн үеэр Монголын Хуульчдын холбооны Эдийн засгийн эрх зүйн хорооны тэргүүн Б.Баасандорж хуульчдаас ирүүлсэн саналыг танилцуулж, мэдээлэл өгсөн.

Хувь хүн, хуулийн этгээдийн ажил, бизнес, үйл ажиллагаа чөлөөтэй эрхлэх таатай орчныг бүрдүүлэх, ачааллыг бууруулах, ашиг орлого, өрсөлдөх чадвар, ажлын байр нэмэгдүүлэх, цаашлаад далд эдийн засгийг ил болгож, чөлөөт зах зээлийн харилцааг тэлэх, үүний үр дүнд татвар, нийгмийн даатгалын сангийн орлогыг нэмэгдүүлэх зэрэг үр дүн, бодит хэрэгцээ, шаардлагыг тус тус харгалзан Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулжээ.



Тодруулбал, өмчийн бүх хэлбэрийн хуулийн этгээд, хүнтэй Иргэний хуулийн ажил гүйцэтгэх гэрээ, хөлсөөр ажиллах гэрээ болон тэдгээртэй адилтгах гэрээ байгуулан ажил, үйлчилгээ эрхлэх хүнийг нийгмийн даатгалд албан журмаар даатгуулагчаас хасаж, эдгээр гэрээний орлогыг нийгмийн даатгалын шимтгэл ногдох орлогын бүрэлдэхүүнээс хасах, ажил олгогч ажилтанд олгох хоол, унаа, орон сууцны ашиглалтын төлбөр, түлээ, нүүрс худалдан авахад

зориулан мөнгөн хэлбэрээр олгосон хөнгөлөлтийг цалин, түүнтэй адилтгах орлого болон нийгмийн даатгалын шимтгэл ногдох орлогын бүрэлдэхүүнээс хасах, мөн ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөх сарын цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын дээд хэмжээг ажилтны төлж буйн нэгэн адилаар тухайн үед мөрдөж байгаа сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү хэмжээгээр тогтоохоор, түүнчлэн ажил олгогч хөдөлмөр эрхлэлтийн харилцааны шинжтэй харилцаанд хүнийг хөдөлмөрийн гэрээгээр бус, түүнээс өөр гэрээ байгуулан ажиллуулж, цалин хөлс олгосон тохиолдолд тухайн хугацаанд ногдох нийгмийн даатгалын шимтгэлийг ажил олгогчоор нөхөн төлүүлэх зохицуулалтыг хуулийн одоогийн холбогдох зохицуулалтын нэмэлтээр тусгахаар төсөлд тусгасан байна.

Тус хэлэлцүүлэгт хуульч, бизнес эрхлэгч, хувийн хэвшил, иргэдийн төлөөлөл болсон 100 гаруй хүн оролцож, өөрсдийн байр суурь, саналаа хуваалцлаа.

4.5 "Дампуурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл" сэдэвт өглөөний уулзалт:




Эдийн засгийн эрх зүйн хорооны зүгээс Улаанбаатар хотын худалдааны танхимтай хамтран Хууль зүй, дотоод хэргийн яамнаас боловсруулсан Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуулийн үзэл баримтлал, төслийн хүрээнд өглөөний уулзалт, чөлөөт хэлэлцүүлгийг 2025 оны тавдугаар сарын 08-нд зохион байгууллаа.

ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ХОРОО



1. Олон Улсын Эрх Зүйн Хорооноос санаачлан 2025 оны 3 дугаар сарын 27-ны өдөр **“ОЛОН УЛСЫН ХУУЛИЙН СУРГУУЛИЙН ОЮУТНУУДЫН ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЧИГЛЭЛИЙН ГЛОБАЛЬ ТЭМЦЭЭНҮҮД: ХУУЛЬЧИЙН УР ЧАДВАР БА ГЛОБАЛЬ КАРЬЕР”** сэдэвт ярилцлага, хэлэлцүүлэг зохион байгууллаа.



Ярилцлага-хэлэлцүүлгээр МУИС Хууль Зүйн Сургуулийн Дэд Профессор Э.Байгаль (PhD), ахлах багш Б. Нинжин (PhD), “Withersworldwide” ОУ-ын хуулийн фирм (Hong Kong)-ын Партнер Vis East Moot Foundation-ний Гүйцэтгэх Захирал Sherlin Tung, Тайландын ОУ-ын Арбитрын экс-Нарийн Бичгийн Дарга Dario Simone Palmiotti, Монголын Хуульчдын Холбооны Олон улсын эрх зүйн хорооны Тэргүүн Х.Наранбулаг нар олон улсын хуулийн сургуулиуд ба хуулийн оюутнуудын дунд олон улсын ямар тэмцээнүүд, хэзээ, хаана зохион байгуулагддаг, Хуулийн оюутнууд эдгээр олон улсын тэмцээнүүдэд хэрхэн хамрагдах, оролцох, тэдгээрийн шалгуур ба шаардлагын талаар мөн эдгээр олон улсын хуулийн тэмцээнүүдэд оролцох нь мэргэжлийн ямар ур чадвар хөгжүүлэхэд, ирээдүйн чадварлаг хуульч болоход хэрхэн нөлөөлдөг талаар олон улсын туршлага хуваалцаж, мэдээлэл, зөвлөгөө өгч, асуулт, хариултын нээлттэй хэлбэрээр зохион байгуулагдлаа.



2.Ерөнхийлөгч П.Одгэрэл, Олон Улсын эрх зүйн хорооны тэргүүн Х.Наранбулаг нар АНУ-ын Худалдааны яамны дэргэдэх Арилжааны эрх зүйн хөтөлбөрийн Олон улсын зөвлөх хуульч Гришма Прадханыг хүлээн авч уулзсан. Уулзалтаар цаашид хэрэгжүүлэх ажлын талаар санал солилцож, төр хувийн хэвшлийн түншлэл болон хиймэл оюун ухаан, эрчим хүч, дэд бүтцийн чиглэлээр сургалтын хөтөлбөр боловсруулж хамтран ажиллахаар тохиролцсон юм.



3. Олон улсын Улаан загалмай хороо, Монголын улаан загалмай нийгэмлэг, Нийслэл дэх Захиргааны хэргийн Анхан шатны шүүх, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн Тамгын газар, Монголын хуульчдын холбооны Олон Улсын эрх зүйн хороо, Монголын өмгөөлөгчдийн холбоо хамтран Олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн шүүхийн мэтгэлцээний тэмцээнийг 2025 оны 11 дүгээр сарын 15-16-ны өдрүүдэд амжилттай зохион байгууллаа.

Шүүхийн мэтгэлцээний тэмцээнд Монгол Улсын Их Сургууль, Дотоод хэргийн их сургууль, Санхүү, Эдийн Засгийн Их Сургууль, Их Засаг Их Сургууль, Рояль Олон Улсын Их Сургууль, Отгонтэнгэр их сургууль, Шихихутуг Их сургуулийн нийт 17 багийн 54 оюутан оролцов.

Тэмцээнийг Олон улсын эрүүгийн шүүхийн дүрмээр Англи хэл дээр зохион байгуулсан ба оюутнууд тэмцээнд оролцсоноор олон улсын эрх зүйн мэдлэгээ бэхжүүлж, англи хэл дээр мэтгэлцэх чадвартай болох юм.

Тэмцээний тэргүүн байранд Монгол Улсын Их Сургуулийн Хууль, зүйн сургуулийн Б.Ариунзаяа, Э.Хонгорзул, Ж.Энхтөгөлдөр, хоёрдугаар байранд Санхүү, Эдийн Засгийн Их Сургуулийн Д.Ууганзаяа, Э.Номин, Г.Нанзадсүрэн нар орлоо. Тэмцээний тэргүүн байранд орсон баг нь дараа оны 3 дугаар сард Олон улсын Улаан загалмай хороо, Хонгконгийн улаан загалмай хамтран зохион байгуулах Ази-Номхон далайн бүсийн Олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн шүүхийн мэтгэлцээний тэмцээнд Монгол Улсыг төлөөлж оролцох юм..

ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ХОРОО

1. Хэлэлцүүлэг зохион байгууллаа

Монголын Хуульчдын холбооны Эрүүгийн эрх зүйн хороо, Прокурорын хороо, Шүүгчдийн хороо, Өмгөөлөгчдийн хороо хамтран “Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцүүлгийг 2025 оны 03 дугаар сарын 13-ны өдөр зохион байгууллаа. Хэлэлцүүлгийг Монголын Хуульчдын холбооны Ерөнхийлөгч П.Одгэрэл нээж, тус хуулийн төсөлтэй холбоотой өөрийн саналыг хуваалцсан.

Хэлэлцүүлэгт Улсын Их хурлын гишүүн Х.Тэмүүжин оролцож, Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн танилцуулгыг хийсэн бөгөөд эрүүгийн хариуцлагатай холбоотой зохицуулалтыг ял, албадлагын арга хэмжээ болгож өөрчлөх болон худал мэдээлэл тараах, мөрдөн шалгах ажиллагааны нууцыг задруулах гэмт хэргийн шинжийг өөрчлөх талаар мэдээлэлдээ дурдсан.

Хэлэлцүүлгийн чиглүүлэгчээр Монголын Хуульчдын холбооны судалгааны төвийн эрхлэгч Г.Оюунболд, хэлэлцүүлэгчээр Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин, Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны тойргийн шүүхийн шүүгч Л.Галбадар, Улсын Ерөнхий Прокурорын газрын дэргэдэх Сургалт, судалгааны хүрээлэнгийн Сургалтын албаны дарга, ахлах прокурор, О.Алтангэрэл, МУИС-ийн ХЗС-ийн Нийтийн эрх зүйн тэнхимийн багш, доктор, дэд профессор Т.Золбоо, Монголын Хуульчдын холбооны гишүүн хуульч, өмгөөлөгч Б.Мэргэн нар оролцож хуулийн төслийн талаар санал солилцлоо.

Монголын Хуульчдын холбооны гишүүн шүүгч, прокурор, өмгөөлөгч, бусад хуульчид болон иргэдийн төлөөлөл болсон нийт 68 хүн тус хэлэлцүүлэгт оролцож санал, шүүмжээ хуваалцсан бөгөөд Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа судалгаа, шинжилгээнд үндэслэж, шинжлэх ухаанчаар хандах, хуулийн үзэл баримтлалыг алдагдуулахгүйгээр

ардчилсан нийгмийн үнэт зүйлийг хамгаалах алхмаас ухрахгүй байхад анхаарах талаар тодорхой байр суурийг илэрхийлсэн.

Энэхүү хэлэлцүүлэгт оролцогчдоос гаргасан саналыг нэгтгэн хууль санаачлагчдад хүргүүлсэн.



2. Эрүүгийн хэргийн шүүхийн мэтгэлцээний тэмцээн зохион байгуулав.

Эрүүгийн эрх зүйн хороо, Шүүгчдийн хороо, Шинжлэх ухааны хороо, Нийслэлийн Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны тойргийн шүүхтэй хамтран Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүрэгт шүүх байгуулагдсаны 60 жилийн ойд зориулан Эрүүгийн хэргийн “Мок триал” шүүхийн мэтгэлцээний тэмцээнийг 2025 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр зохион байгууллаа.



Монголын Хуульчдын холбооны Эрүүгийн эрх зүйн хороо, Шүүгчдийн хороо хамтран Ерөнхийлөгчийн нэрэмжит тус тэмцээнийг 10 дахь жилдээ зохион байгуулж байгаа бөгөөд энэ удаагийн тэмцээнд МУИС-ийн Хууль зүйн сургууль, Санхүү эдийн засгийн их сургууль, Дотоод хэргийн их сургууль, "Рояаль" Олон Улсын их сургууль, Олон Улсын "Улаанбаатар"

их сургууль, "Глобал удирдагч" их сургууль, "Шихихутуг" их сургууль, "Зохиомж" их сургууль, "Их засаг" Олон Улсын их сургууль, "Отгонтэнгэр" их сургуулийн 15 баг өрсөлдсөн.

ӨМГӨӨЛӨГЧДИЙН ХОРОО

1. “Эрүү шүүлтгүй монгол улс-өмгөөлөгчийн оролцоо” сэдэвт өглөөний уулзалт зохион байгуулагдсан



Өмгөөлөгчдийн хороо, Үндсэн хуулийн эрх зүйн хорооноос санаачлан Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үндэсний ажиллагаа, Монголын Өмгөөлөгчдийн холбоо, Монголын Криминологичдын холбоотой хамтран өмгөөлөгчдийн дунд “Эрүү шүүлтгүй Монгол Улс-Өмгөөлөгчийн оролцоо” сэдэвт өглөөний уулзалтыг зохион байгуулсан.

Уулзалтад Үндсэн хуулийн эрх зүйн хорооны тэргүүн, хууль зүйн ухааны доктор, профессор, гавьяат хууль Ш.Цогтоо, ХЭҮК-ын Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүн Я.Цэлмэн, Монголын Өмгөөлөгчдийн холбооны ерөнхийлөгч Л.Данзанноров, Монголын Криминологичдын холбооны тэргүүн, хууль зүйн ухааны доктор Б.Батзориг, Шихихутуг их сургуулийн дэргэдэх, Харьцуулсан эрх зүйн

судалгааны хүрээлэнгийн захирал Т.Мөнх-Эрдэнэ, Үндсэн хуулийн эрх зүйн хороо, Өмгөөлөгчдийн хорооны Удирдах зөвлөлийн гишүүн Ч.Өнөржаргал болон хуульч, өмгөөлөгч, эрдэмтэн, судлаачдын төлөөлөл оролцсон.

Өглөөний уулзалтад Монголын Криминологичдын холбооноос “Эрүүдэн шүүх гэмт явдлын шалтгаан нөхцөлийг тогтоох” судалгааны дүнг танилцуулсан бөгөөд тус судалгаа нь анх удаа хийгдэж байгаа учир өмгөөлөгч, хууль нарыг өөрсдийн үзэл санаа, зөвлөмжөө идэвхтэй өгч хамтран ажиллахыг уриалав.

2. Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцүүлээ

Эрүүгийн эрх зүйн хороо, Прокурорын хороо, Шүүгчдийн хороо, Өмгөөлөгчдийн хороо хамтран “Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэлэлцүүлгийг 2025 оны 03 дугаар сарын 13-ны өдөр зохион байгууллаа. Хэлэлцүүлгийг Монголын Хуульчдын холбооны Ерөнхийлөгч П.Одгэрэл нээж, тус хуулийн төсөлтэй холбоотой өөрийн саналыг хуваалцсан.



Тус хэлэлцүүлэгт Улсын Их хурлын гишүүн Х.Тэмүүжин оролцож, Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн танилцуулгыг хийсэн бөгөөд эрүүгийн хариуцлагатай холбоотой зохицуулалтыг ял, албадлагын арга хэмжээ болгож өөрчлөх болон худал мэдээлэл тараах, мөрдөн шалгах ажиллагааны нууцыг задруулах гэмт хэргийн шинжийг өөрчлөх талаар мэдээлэлдээ дурдсан. Тус хэлэлцүүлгийн чиглүүлэгчээр Монголын Хуульчдын холбооны судалгааны төвийн эрхлэгч

Г.Оюунболд, хэлэлцүүлэгчээр Улсын Их Хурлын гишүүн Х.Тэмүүжин, Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны тойргийн шүүхийн шүүгч Л.Галбадар, Улсын Ерөнхий Прокурорын газрын дэргэдэх Сургалт, судалгааны хүрээлэнгийн Сургалтын албаны дарга, ахлах прокурор, О.Алтангэрэл, МУИС-ийн ХЗС-ийн Нийтийн эрх зүйн тэнхимийн багш, доктор, дэд профессор Т.Золбоо, Монголын Хуульчдын холбооны гишүүн хуульч, өмгөөлөгч Б.Мэргэн нар оролцож хуулийн төслийн талаар санал солилцлоо.

Монголын Хуульчдын холбооны гишүүн шүүгч, прокурор, өмгөөлөгч, бусад хуульчид болон иргэдийн төлөөлөл болсон нийт 68 хүн тус хэлэлцүүлэгт оролцож санал, шүүмжээ хуваалцсан бөгөөд Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа судалгаа, шинжилгээнд үндэслэж, шинжлэх ухаанчаар хандах, хуулийн үзэл баримтлалыг алдагдуулахгүйгээр ардчилсан нийгмийн үнэт зүйлийг хамгаалах алхмаас ухрахгүй байхад анхаарах талаар тодорхой байр суурийг илэрхийлсэн. Энэхүү хэлэлцүүлэгт оролцогчдоос гаргасан саналыг нэгтгэн хууль санаачлагчдад хүргүүлэх болно.

3. Сонгогчдын санал худалдан авалт: эрх зүйн орчин, тулгамдсан асуудал хэлэлцүүлэг зохион байгуулав



Сонгуулийн үр дүнд хууль бусаар нөлөөлөх зорилготой сонгогчдын саналыг худалдан авах асуудалтай тэмцэх, түүнийг хязгаарлах нь шударга сонгууль явуулах үндэс байдаг. УИХ-ын гишүүн Ж.Баярмаа санаачлан сонгуулийг шударга явуулахад шаардлагатай хууль тогтоомжийг шинэчлэх, тулгамдсан асуудал, шийдэх гарц, шийдлийг тодорхойлох зорилгоор улс төрийн нам эвсэл, улс төр судлаач, эрдэмтэд, Сонгуулийн байгууллага, хууль хэрэгжүүлэгч байгууллага, хуульчид, хууль хяналтын байгууллага, иргэний нийгэм зэрэг байгууллагын дунд хэлэлцүүлэг зохион байгуулсан.

4. “Спортын арбитр ба хүний эрх” сэдэвт өглөөний уулзалт зохион байгууллаа



Өмгөөлөгчдийн хорооноос “Спортын арбитр ба хүний эрх” сэдэвт өглөөний уулзалт зохион байгууллаа. Уулзалтын зочноор Монголын Хуульчдын холбооны Зөвлөлийн гишүүн, Монголын Олон улсын ба үндэсний Спортын арбитрын Ерөнхийлөгч Г.Батзаяа оролцож, спортын эрх зүйн хүрээнд шүүхийн бус журмаар маргаан зохицуулах үйл ажиллагааны онцлог, үүсэл хөгжил, хуульчдын оролцоо зэрэг асуудлаар хуульчдад сонирхолтой мэдээлэл өгч, оролцогчдод Спортын арбитр ба Допинг эрх зүйн баримт бичгийн эмхэтгэлийг дурсгалаа.

5. Хуульчийн мэргэжлийн шалгалтын зохион байгуулалтын комисст нэр дэвшиж ажиллах хүсэлтэй 3 өмгөөлөгчийн мэдээллийг нийт өмгөөлөгчдийн дунд нээлттэй зар явуулах ажиллагаа хийгдсэн, нийт ирсэн хүмүүсийн дотроос Өмгөөлөгчдийн хороо хуралдаж 3 хүний нэрсийг Шалгалтын хороонд нэрсийг хүргүүлсэн.
6. Хуульчийн мэргэжлийн шалгалтын хорооноос Хуульчийн мэргэжлийн шалгалтын Бодлого дүгнэх комисст эрүүгийн эрх зүйд 4, иргэний эрх зүй 5, захиргааны эрх зүйд 5 өмгөөлөгчийн нэрсийг ирүүлэх ажлын хүрээнд Өмгөөлөгчдийн хорооноос 2 удаа хурал зарлан нийт өмгөөлөгчид руу цахим хаягаар мэдээлэл хүргэж нийт ирүүлсэн анкетыг бэлтгэж өмгөөлөгчдийн хороо хуралдаж санал хураалтын дагуу дээр дурдсан тоогоор өмгөөлөгчдийн нэрсийг хүргүүлсэн.
7. Монголын Хуульчдын холбооны Хяналтын зөвлөлийн 1 гишүүний хугацаа дууссантай холбогдуулж Өмгөөлөгчдийн хороо Монголын Хуульчдын холбооны цахим хаяг дээр зар мэдээ байршуулж Хяналтын зөвлөлд ажиллах хүсэлтэй өмгөөлөгчдийн мэдээлэлтэй танилцаж цахим хурал хийж Монголын Хуульчдын холбоонд Хяналтын зөвлөлд орох 1 өмгөөлөгчийн нэрийг илгээж, Удирдах зөвлөлийн хурлаар сонгогдсон.
8. Монголын Хуульчдын холбооноос жил бүр зохион байгуулагддаг “Хуульчийн про боно-2025” өдөрлөгт Өмгөөлөгчдийн хорооны Удирдах зөвлөлөөс оролцсон.
9. Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооноос зохион байгуулж буй Иргэний шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн эрх зүйн орчныг боловсронгуй болгох нь сэдэвт олон улсын онол, практикийн хуралд Өмгөөлөгчдийн хорооны Удирдах зөвлөлийн гишүүн Д.Оросоо оролцсон.
10. Хуульчийн мэргэжлийн ёс зүйн зөрчил шалгах ажлын хүрээнд: Хуульчдын холбоонд ирүүлсэн хүсэлтийн дагуу хуульчид холбогдох ёс зүйн зөрчлийг шалган 11 дүгээр сарын 20-ны байдлаар 75 хуульч, 3 байгууллагад холбогдох хуульчдын ёс зүйн зөрчлийг шалган тодорхойлолтыг гарган ажиллав.
11. Өмгөөлөгчийн туслахаар бүртгэх ажлын хүрээнд: Холбоонд ирүүлсэн материалыг үндэслэн хуульч, өмгөөлөгчийн туслахаар ажиллагсдыг бүртгэлжүүлж 11 дүгээр сарын 20-ны өдрийн байдлаар өмгөөлөгчийн туслахыг шинээр бүртгэн үнэмлэх олгож, сунгаж 575 өмгөөлөгчийн туслахын үнэмлэхийг гаргасан.
12. Монголын Өмгөөлөгчдийн холбооноос жил бүр зохион байгуулагддаг Хөл бөмөгийн спорт тэмцээнд Монголын Хуульчдын холбоог төлөөлж Монголын Хуульчдын холбооны Өмгөөлөгчдийн хороо баг бүрдүүлж оролцсон.
13. Монголын Хуульчдын холбооны Ерөнхийлөгчийн нэрэмжит 2025 оны шатрын тэмцээнд Өмгөөлөгчдийн хорооны баг тамирчид оролцсон.

ХУУЛЬЧИЙН НИЙТЭД ТУСТАЙ МЭРГЭЖЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЭЛСЭН ХОРОО

Нэг. Хорооны хурал

Тайлант хугацаанд хороо 2 удаа буюу 02 дугаар сарын 27, 04 дүгээр сарын 12-ны өдөр тус тус хуралдаж дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн.

1. Хуульчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагааны бодлогын баримт бичиг;
2. Азийн Пробоно-той чуулга уулзалттай холбоотой хийгдэх ажлууд;
3. Хорооны төлөвлөгөөнд туссан ажлуудын талаар;
4. “Хуульчийн Про боно өдөр-2025”-ыг зохион байгуулах төлөвлөгөө батлах тухай.

Мөн Азийн Про боно чуулга уулзалтыг зохион байгуулах бэлтгэл ажлын хүрээнд тус хорооноос байгуулагдсан Ажлын хэсэг нийт 12 удаа хурал, уулзалт зохион байгуулсан ба чуулга уулзалтыг санаачлан зохион байгуулагч Babseacle байгууллагатай 7 хоног бүр цахим уулзалтыг зохион байгуулж, чуулганы бэлтгэл ажлын талаар мэдээлэл солилцсон.

Хоёр. Хорооноос зохион байгуулсан ажил

Хуульчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх хороо нь 2025 онд дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

2.1 Иргэдэд хууль зүйн зөвлөгөө, мэдээлэл өгөх чиглэлээр

Нийслэлийн Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай хамтран нийслэлийн үйлчилгээний нэгдсэн төвийн 6 цэг, тусгай дугаарын 4 утсаар дараах өдрүүдэд иргэдэд зөвлөгөө өгөх өдрийг зохион байгуулав:

1. 01 дүгээр сарын 15-ны өдөр нийт **79** иргэнд;
2. 02 дугаар сарын 19-ний өдөр нийт **69** иргэнд;
3. 03 дугаар сарын 19-ний өдөр нийт **130** иргэнд зөвлөгөө мэдээлэл өгсөн ба дээрх үйл ажиллагаанд Эрүү, Иргэний хялбар ажиллагааны анхан шатны тойргийн шүүхийн Тамгын газар, Өмгөөллийн Цогц өмгөөлөл, Компас консалтинг, Легас атторнийз хуулийн фирмүүд;
4. 04 дүгээр сарын 16-ны өдөр **106** иргэнд;
5. 05 дугаар сарын 01-ний өдөр нийт **69** иргэнд;
6. 06 дугаар сарын 18-ны өдөр нийт **84** иргэнд зөвлөгөө мэдээлэл өгсөн ба дээрх үйл ажиллагаанд Хүний эрхийн үндэсний комисс, Монгол Үйлдвэрчний эвлэлийн холбооны өмгөөлөгчид;
7. 09 дүгээр сарын 17-ны өдөр **56** иргэнд;
8. 10 дугаар сарын 15-ны өдөр **62** иргэнд;
9. 11 дүгээр сарын 19-ний өдөр **46** иргэнд тус тус зөвлөгөө, мэдээлэл өгсөн байна.



Мөн 2025 оны 02 дугаар сараас эхлэн Хууль зүйн сургуулиудын Клиник сургалтын төвүүдтэй хамтран оюутнуудад дадлага олгох зорилгоор дээрх төвүүдэд МУИС-ийн Хууль зүйн сургууль, Санхүү эдийн засгийн их сургуулийн Хууль зүйн сургууль, Отгонтэнгэр их сургууль, УБЭИС, ИЗОУИС, Глобал удирдагч их сургууль, МҮИС, Сити их сургуулийн 90 орчим оюутныг хамруулсан.

Дээрх хугацаанд Нэгдсэн үйлчилгээний төвүүдэд нийт **701** иргэнд, тусгай дугаарын утсаар **130** орчим иргэнд хууль зүйн анхан шатны зөвлөгөө, мэдээлэл өгөх ажлыг зохион байгуулсан.


2.2 Хэлэлцүүлэг, өглөөний уулзалт зохион байгуулах чиглэлээр



1. Нэгдүгээр сарын 28-ны өдөр “Бизнесийн үйл ажиллагаанд тулгамдаж буй хөдөлмөрийн болон нийгмийн даатгалын хуулийн зохицуулалтын асуудлууд” сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгуулав. Хэлэлцүүлгийн илтгэгчээр ХНТМҮАЭХорооны Удирдах зөвлөлийн гишүүн Б.Энхчимэг “Хөдөлмөрийн тухай хууль болон Нийгмийн даатгалын тухай хуулийн шинэчлэлийн өнөөгийн нөхцөл байдал (Бизнес эрхлэгчдэд нөлөөлж буй танхимын гүйцэтгэх захирал Б.Хаш-Эрдэнэ,

ХНТМҮАЭХорооны Удирдах зөвлөлийн гишүүн О.Билгүүн нар “Хөдөлмөрийн хуулийн ажил амралтын цаг, цалин хөлсний зохицуулалтын талаарх хэлэлцүүлэг” сэдвээр хэлэлцүүлэг өрнүүлсэн.

Мөн Хуульч, Хуулийн төслийн ажлын хэсгийн гишүүн Б.Солонго “Нийгмийн даатгалын ерөнхий хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хууль”-ийн танилцуулгыг хүргэж, “Нийгмийн даатгалын хуулийн үр нөлөө” сэдвээр Улаанбаатар хотын худалдааны танхимын гүйцэтгэх захирал Б.Хаш-Эрдэнэ, Өмгөөллийн “Онч нүүдэл” ХХН партнер Ө.Эрдэнэ-Очир, ММНБИ-ийн УЗ-ийн гишүүн С.Баярхүү нар хэлэлцүүлэг өрнүүлсэн.



Хэлэлцүүлэгт төрийн болон хувийн байгууллагуудын хүний нөөц, хуулийн асуудал хариуцсан мэргэжилтэн, хуульч өмгөөлөгч бүхий 40 гаруй хүн оролцсон. Тус хэлэлцүүлгээс гарсан санал, зөвлөмжийг Улсын Их хурлын Тамгын газар, Улсын Их Хурлын Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэнд хүргүүлсэн.

2. Азийн Про боно чуулга уулзалтыг санаачлан зохион байгуулагч Babseacle байгууллагатай хамтран 04 дүгээр сарын 16-ны өдөр “Хуульчийн Про боно үйл ажиллагааны хөгжил, дэлхийн чиг хандлага – өнгөрсөн, одоо, ирээдүй” сэдэвт хэлэлцүүлгийг хуульчдын дунд зохион байгуулав. Хэлэлцүүлэгт 50 гаруй хуульч оролцсон.





2.3. Өглөөний уулзалт



Хорооноос Хуульчийн Про боно өдрийг угтан 04 дүгээр сарын 30-ны өдөр “Хуульчийн про боно үйл ажиллагааны чиг хандлага-өнгөрсөн, одоо, ирээдүй” сэдвээр өглөөний уулзалт зохион байгуулсан. Уулзалтад хорооны тэргүүн Г.Цагаанбаяр, Удирдах зөвлөлийн гишүүн Ц.Одонжав нар оролцож мэдээлэл өгсөн.

2.4 Хуульчийн Про боно өдөр зохион байгуулах

Жил бүрийн 05 дугаар сарын 01-ний өдөр зохион байгуулдаг Хуульчийн Про боно өдрийг 7 дахь жилдээ Сүхбаатарын талбай болон 21 аймгийн төв талбай,

Нийслэлийн нэгдсэн үйлчилгээ төв, алслагдсан хороод, тойргийн шүүх, хялбар ажиллагааны шүүхийн гадна талбайд зохион байгуулсан.



Сүхбаатарын талбайд зохион байгуулсан өдөрлөгт Монголын Хуульчдын холбооны гишүүн хуульчид болон Хууль зүй, дотоод хэргийн яам, Шүүхийн Ерөнхий зөвлөл, Баянзүрх, Чингэлтэй, Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны тойргийн шүүх, Улсын Ерөнхий прокурорын газар, Нийслэлийн Прокурорын газар, Хан-Уул дүүргийн Прокурорын газар, Чингэлтэй дүүргийн Прокурорын газар, Сонгинохайрхан дүүргийн Прокурорын газар, Налайх, Багахангай дүүргийн Прокурорын газар, Баянгол

дүүргийн Прокурорын газар, Сүхбаатар дүүргийн Прокурорын газар, Тээврийн прокурорын газар, Хүний эрхийн Үндэсний Комисс, Цагдаагийн Ерөнхий газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Нийгмийн даатгалын ерөнхий газар, Санхүүгийн зохицуулах хороо, Гадаадын иргэн, харьяатын газар, Архивын ерөнхий газар, Хууль зүйн туслалцааны төв, Хууль зүйн үндэсний хүрээлэн, Монголын Өмгөөлөгчдийн холбоо, Монголын Нотариатчдын танхим, Өмгөөллийн "Легал гайд" ХХН, "Сноухилл консалтанси" ХХН, Өмгөөллийн "Цогц өмгөөлөл" хууль зүйн фирм, Өмгөөллийн Легал полиси ХХН, "Легас атторнийз" хуулийн фирм, "Легал сервис" ХХН, "Эм Жи Эл атторнийз" хуулийн фирм, "Чирха өвгөн" ХХН, "Компасс консалтинг" хууль зүйн фирм, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Клиник сургалтын төв, "Анбаунд Монгол" ТББ, Монголын Барилгын Үндэсний Ассоциаци зэрэг 20 гаруй байгууллага оролцож иргэдэд хууль, эрх зүйн анхан шатны зөвлөгөө мэдээлэл өгч, төрийн зарим үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлсэн.



Мөн Про боно өдрийг угтаж Нийслэл болон 21 аймгийн Ерөнхий боловсролын 8-11 дүгээр ангийн сурагчдад "Цахим орчны зохистой хэрэглээ" сэдвээр нийт **72** сургуулийн **7906** сурагчид сургалт зохион байгуулсан.

Сургалтаар гэмт хэргийн тухай ойлголт, цахим гэмт хэрэг, түүний хохирогч болохоос урьдчилан сэргийлэх болон цахим донтолтын талаар сурагчдад таниулан, мэдээлэл өгсөн.

Хуульчийн нийтэд тустай мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх ажлын хүрээнд тус сургалтад орон нутгийн шүүхийн шүүгчид, Нийслэл, дүүрэг, орон нутгийн Прокурорын газрын прокурорууд, хуульч, өмгөөлөгч, улсын өмгөөлөгч, 21 аймгийн салбарын зохицуулагчид нийлсэн нийт 76 хүн сургагч багшаар ажилласан.



Хуульчийн Про боно өдрийн хүрээнд Нийслэл болон орон нутгийн хэмжээнд нийт **13,378** иргэнд хууль зүйн, зөвлөгөө мэдээлэл өгсөн байна.

2.5 Алслагдсан хороодын иргэдэд зөвлөгөө өгөх

Нийслэлийн алслагдсан хороод буюу хүн ам ихээр оршин суудаг, амьжиргааны түвшнээс доогуур орлоготой иргэд төвлөрсөн Сонгинохайрхан дүүргийн 21, 32, 19, 33-р хороо, Баянзүрх дүүргийн 9, 11, 13, 20, 21, 35-р хороо нийт 10 хороонд 11 хуульч, өмгөөлөгчид 10:00 -16:00 цагийн хооронд иргэдэд хууль, эрх зүйн анхан шатны зөвлөгөө мэдээлэл өгсөн.





Мөн Сонгинохайрхан дүүргийн алслагдсан хороодын иргэдэд хууль зүйн анхан шатны зөвлөгөө мэдээлэл өгөх, сургалт зохион байгуулах чиглэлээр тус дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралтай хамтран ажиллах санамж бичгийг 07 дугаар сарын 07-ны өдөр зурсан. Хамтран ажиллах санамж бичгийн хүрээнд хийх ажлын төлөвлөгөөг боловсруулж байна.

2.6. Азийн Пробоно чуулга уулзалт зохион байгуулах бэлтгэл ажлын хүрээнд

Чуулга уулзалтын бэлтгэл ажлын хэсгийн дараах уулзалтуудыг зохион байгуулав.

1. 01 дүгээр сарын 08-ны өдөр ажлын хэсгийн гишүүд уулзалт хийж чуулганы сэдвийн талаар ярилцаж, нэгдсэн болон салбар хуралдааны 24 сэдвийг сонгов.
2. 02 дугаар сарын 05-ны өдөр ажлын хэсгийн гишүүд, Babseacle-тэй зүүм уулзалт зохион байгуулж, чуулганы сэдэв, зохион байгуулах газрын талаар мэдээлэл солилцов.
3. 02 дугаар сарын 12-ны өдөр ажлын хэсгийн уулзалт зохион байгуулж, чуулганд хэрэглэгдэх техник хэрэгсэл, төрийн болон бусад байгууллагатай хэрхэн хамтран ажиллах талаар ярилцав.
4. 03 дугаар сарын 07-ны өдөр ажлын хэсгийн гишүүд, Babseacle-тэй ээлжит зүүм уулзалт зохион байгуулж, тус байгууллагын тэргүүн Брус Ласки, гишүүн Вэнди нар Монгол Улсад 04 дүгээр сарын 13-20-ны өдрүүдэд айлчлах үеэр хийх ажлын талаар ярилцав.
5. Babseacle байгууллагын үүсгэн байгуулагч тэргүүн Брус Ласки, гүйцэтгэх захирал Вэнди Морриш нар 04 дүгээр сарын 14-18-ны өдрүүдэд Монгол Улсад ажлын айлчлал хийж, 10 дугаар сард Монгол Улсад зохион байгуулагдах Азийн 13 дахь удаагийн Про боно чуулга уулзалтын талаар Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Шүүхийн Ерөнхий зөвлөл, Улсын Ерөнхий прокурорын газар, Азийн сан, IDLO, Нээлттэй нийгэм форум, Ханнс Зайделийн сан, Хуулийн этгээдүүдийн төлөөллүүд, Хуульчдын холбооны ажлын хэсгийнхэнтэй тус тус уулзалт хийсэн. Уулзалтад хорооны Удирдах зөвлөлийн гишүүн Ц.Одонжав, Л.Энхсайхан, О.Билгүүн нар оролцсон.





6. 09 дүгээр сарын 02-ны өдөр 21 аймгийн салбар зохицуулагч нарт чуулга уулзалтын талаар мэдээлэл өгөх зүүм хурлыг зохион байгуулав. Тус хурлаар орон нутгаас Азийн про боно чуулга уулзалтад хэрхэн хуульчдыг оролцуулах талаар нэгдсэн мэдээллийг өгсөн.

2.7. АЗИЙН 13 ДАХЬ УДААГИЙН ПРО БОНО ЧУУЛГА УУЛЗАЛТ

2025 оны аравдугаар сарын 01-07-ны өдрүүдэд “Хувьчилсан, төрөлжсөн, байгууллагын тогтсон бүтэц бүхий про боно” сэдвийн дор 30 улсын 310 орчим хуульчид, зохион байгуулагч 50 гаруй хүн, нийт 360 оролцогчдыг хамруулан эх орондоо амжилттай зохион байгуулсан.



Тус чуулга уулзалтад Солонгос, Австрали, Америк, Англи, Япон, Малайз, Филиппин, Сингапур, Хонгконг, Пакистан, Орос, Хятад, Тайланд, Швед зэрэг Азийн болон бусад 30 улс орны 140 гаруй хуульч, төлөөлөгч Монгол Улсаас шүүгч, прокурор, өмгөөлөгч, нотариатч,

бусад хуульч, Хууль зүй, дотоод хэргийн яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын хуульч, мэргэжилтний төлөөлөл бүхий 160 гаруй хуульч хамрагдсан.

Шударга ёсны хүртээмжийн тухай салбар хэлэлцүүлгүүд зохион байгууллаа

Азийн Про боно чуулга уулзалтыг угтаж шударга ёсны хүртээмжийн талаарх салбар хурлууд 10 дугаар сарын 01, 02, 06-ны өдрүүдэд зохион байгуулагдсан.

1. Эхний өдөр буюу 10 дугаар сарын 01-ний өдөр “Хуульчийн ёс зүй ба мэргэжлийн хариуцлага-бизнесийн эрх зүйн практик туршлагууд” сэдвээр хэлэлцүүлэг зохион байгуулсан ба уг хэлэлцүүлэгт Монгол, Тайланд, Австрали, Лаос, Канад, Япон, Сингапур, Англи зэрэг орны 60 гаруй оролцогч оролцож туршлага солилцсон.

Хэлэлцүүлгээр хуульч нь үйлчлүүлэгчээ хэрхэн таних, хуулийн нийцэл болон хориг хэрхэн нөлөөлдөг, бизнесийн эрх зүйн нарийн төвөгтэй асуудлуудыг хэрхэн шийдвэрлэх, компанийн болон арилжааны салбарын хуульчид шударга ёсны хүртээмжид ямар чиг хандлагыг баримталж байна зэрэг агуулгын хүрээнд ярилцаж, өөр өөрсдийн орны сайн туршлагуудын талаар санал солилцсон.




2. Хоёр дахь өдөр буюу 10 дугаар сарын 02-ны өдөр 2 сэдвээр хэлэлцүүлэг зохион байгуулсан ба “Хууль зүйн клиник боловсролын чиглүүлэг” хэлэлцүүлэгт хуульчид, хууль зүйн мэргэжилтнүүд, хууль зүйн их дээд сургуулийн багш нар оролцож, хууль зүйн клиникийн боловсролын ач холбогдол, чиглүүлэх үйл ажиллагаа, чиглүүлгийн загвар, чиглүүлэгчийн төлөв хандлага, арга техникууд, тулгардаг бэрхшээл зэрэг өргөн сэдвийн хүрээнд ярилцаж, туршлага солилцсон. Мөн “Про боно долоо хоног” сэдвийн хүрээнд улс орнууд про боно долоо хоногийг хэрхэн хэрэгжүүлдэг, үр дүнд хүрсэн сайн туршлагуудыг хуваалцсан. Про боно долоо хоног гэдэг нь жил бүр олон улс оронд зохион байгуулагддаг, хуульчдын сайн дурын үйлчилгээ болон нийгмийн хариуцлагыг түгээн сурталчилдаг олон улсын үйл ажиллагаа юм.



3. 10 дугаар сарын 06-ны өдөр “Про боно үйл ажиллагааг дэмжихэд Хуульчдын холбооны үүрэг” сэдвээр хэлэлцүүлэг зохион байгуулсан. Хэлэлцүүлгийн илтгэгчээр Bruce Lasky (BABSEACLE байгууллагын үүсгэн байгуулагч, захирал),

Mark Woods(Австралийн Хууль зүйн зөвлөлийн Хууль зүйн хүртээмжийн хорооны дарга), Tanguy Lim(“Pro Bono SG”-ийн Гүйцэтгэх захирал), Pramnath Vijayakumar(“Pro Bono SG”-ийн Олон нийтийн хууль эрх зүйн үйлчилгээний хэлтсийн дэд захирал), Sadhana Rai(“Pro Bono SG”-ийн Төлөөлөгчийн газрын тэргүүн) нар оролцсон.

Хэлэлцүүлгээр Хуульчдын холбоо болон хуульчдын мэргэжлийн байгууллагууд нь шударга ёсны хүртээмжийг дээшлүүлэхэд хэрхэн манлайлан оролцож, про боно үйл ажиллагааг дэмжих боломжтой талаар сайн туршлагуудыг хуваалцаж байгаа бөгөөд оролцогчид хуульчдын холбоодын үүрэг, хамтын ажиллагааны ач холбогдол болон нийгмийн өмнө хүлээсэн хариуцлагаа хэрэгжүүлэхэд про боно нь чухал хэрэгсэл болохыг онцлон тэмдэглэсэн.



Азийн 13 дахь удаагийн Про боно чуулга уулзалт (10 сарын 03-05)

Чуулга уулзалтын Нэгдсэн хуралдаан 10 дугаар сарын 03-ны өдөр эхэлж “Хувьчилсан, төрөлжсөн, байгууллагын тогтсон бүтэц бүхий про боно” сэдвээр зохион байгуулагдсан хуралдааныг нээж “Вабсикл” байгууллагын үүсгэн байгуулагч Брюс Ласки, Монголын Хуульчдын холбооны Ерөнхийлөгч П.Одгэрэл, Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Мягмар нар үг хэлсэн.

Хуралдааны үеэр хувь хүн рүү чиглэсэн, хувьчилсан, төрөлжсөн болон байгууллагын тогтсон бүтэцтэй (institutional) про боно илтгэлүүд танилцуулагдаж, олон улсын болон дотоодын хуульчид, мэргэжилтнүүд өөрсдийн туршлага, санаачилга, шийдлүүдийг хуваалцсан.

Нэгдсэн хуралдааны хэлэлцүүлгийн гол панелистуудаар:

1. Pavina Thephithuck – Лаос улсын “Lingle House” байгууллагын төлөөлөгч;
2. Joanita Britto Menon – (“TrustLaw Thomson Reuters” хуулийн фирмийн Ази дахь эрх зүйн хөтөлбөрийн ахлах менежер);
3. Ж.Хунан - Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний комиссын гишүүн;

4. Б.Уранзаяа – (Lawyer Mommy-ийн үүсгэн байгуулагч, хуульч) нар оролцож, про боно хөдөлгөөний олон улсын чиг хандлага болон Монгол Улсад нутагшуулах боломжийн талаар санал бодлоо солилцсон.

Мөн өдрийн салбар хуралдаанаар дараах сэдвүүдийн хүрээнд хэлэлцүүлэг зохион байгуулсан.

1. Чимээгүй нэгнийг сонсох нь: Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг дэмжих хуулийн болон сэтгэлзүйн про боно стратеги;
2. Про боно-ын нөлөөг хэмжих нь: Өөрийн нөлөөг үнэлж танилцуулах арга замууд;
3. Про боно үйл ажиллагаагаар залуучуудыг дэмжих нь.



Чуулганы эхний өдөр чуулганд оролцогчдыг хүлээн авах оройн Соёлын арга хэмжээг зохион байгуулсан бөгөөд уг арга хэмжээг нээж Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч Х.Нямбаатар мэндчилгээ дэвшүүлж үг хэлсэн.



Үндсэн чуулганы хоёрдахь өдөр 10 дугаар сарын 04-ний өдөр болж дараах салбар хуралдаанууд зохион байгуулагдсан. Үүнд:

1. Про боно Бизнесийн тохиолдол;
2. Хүчирхийлэлд өртсөн ахмад настнуудад үзүүлэх про боно үйл ажиллагаа;
3. Шударга шүүхээр шийдвэрлүүлэх эрхийг бэхжүүлэхэд Про боно дэмжлэг;
4. Нөлөө бүхий Про боно: Нийтийн ашиг сонирхлын маргааныг шийдвэрлэх нь;
5. Про боно үйл ажиллагаанд тэгш хамтын түншлэлийг бэхжүүлэх нь;
6. Олон салбарын оролцоотой Пробоно: Өнгөрсөн, одоо, ирээдүй – Монголын туршлага;
7. Шүүхийн танхимаас анги руу: Про боно үйл ажиллагаагаар дамжуулан өсвөр насны хүүхдүүдийг шүүмжлэлтэй сэтгэж, хууль эрх зүйн мэдлэгтэй үйлдэл хийхэд бэлтгэх;
8. Бизнесийн эрх зүйн практикт мэргэжлийн хариуцлага, хууль ёсны ёс зүйг бэхжүүлэх зорилгоор үргэлжилсэн хууль эрх зүйн боловсролд үзүүлэх про боно дэмжлэг;
9. Шударга ёсны төлөө хамтын ажиллагааны хүрээ: Сингапурын Нийтийн Хамгаалагчийн Алба ба Pro Bono SG хоорондын олон талт түншлэл;
10. Тогтвортой хөгжлийн төлөө Про Боно: Хууль зүйн чадавхижуулалтын дэлхийн чиг хандлага;
11. Дуугүй хүмүүсийг чадваржуулах: Хүйс ба гэр бүлийн хүчирхийлэлд өртөгсдийг өмгөөлөх про боно ба бага төлбөртэй үйлчилгээний стратеги.



“Олон салбарын оролцоотой Пробоно: Өнгөрсөн, одоо, ирээдүй – Монголын туршлага” сэдэвт салбар хуралдаанд Монголын талаас Монгол Улсын Их хурлын гишүүн, хуульч Х.Баасанжаргал, Улсын Ерөнхий прокурорын газрын дэргэдэх Сургалт, судалгааны хүрээлэнгийн прокурор, доктор, профессор Б.Өнөрмаа, Шүүхийн Ерөнхий зөвлөлийн гишүүн, хуульч Н.Баасанжав, МУИС-ийн Хууль зүйн сургуулийн Клиник сургалтын төвийн захирал, доктор, профессор С.Болормаа, Монголын Хуульчдын холбооны гишүүн хуульч, өмгөөлөгч Э.Амархүү нар илтгэл хэлэлцүүлж, мэдээлэл өгсөн бол Монголын Хуульчдын холбооны Тамгын газрын дарга Ш.Жолбарс тус хэлэлцүүлэгт чиглүүлэгчээр оролцсон.





Мөн “Тогтвортой хөгжлийн төлөөх Про боно” сэдэвт хэлэлцүүлэгт Монгол Улсын Их Хурлын гишүүн Х.Баасанжаргал, Монголын Хуульчдын холбооны гадаад харилцааны зөвлөх, хуульч Ц.Одонжав нар оролцож илтгэл хэлэлцүүлсэн. Чуулганы 3 дахь өдөр буюу 10 дугаар сар 05-ны өдөр Дэлхийн Про боно хөдөлгөөн буюу өглөөний гүйлт, алхалтаар чуулганд оролцогчид нэгдэж, дараах салбар хуралдаанаар чуулган үргэлжилсэн.

1. Про боно үйл ажиллагааг дэмжихэд Хуульчдын холбооны үүрэг;
2. Про боно үйл ажиллагаанд ёс зүйн мэдлэгийг дээшлүүлэх;
3. Ялгаварлалын эсрэг: Жендэрийн тэгш байдлыг хангаж эмэгтэйчүүдийг хүчирхэгжүүлэх хөтөлбөрийг Про боно хуульчид хэрэгжүүлсэн нь;
4. Тэмцлийн ард: Про боно дэмжлэгийн үр нөлөөг дээшлүүлэх арга зам;
5. Шударга ёсны боловсрол ба Про боно;
6. Хууль зүйн хэрэглэгдэхүүний стратегиар дамжуулан шударга ёсны хүртээмжийг өөрчлөх, Про боно практикийг нэмэгдүүлэхээр сэдвээр зохион байгуулагдсан.

Сүүлийн өдрийн Нэгдсэн хуралдаан “Шударга ёсыг бэхжүүлэх нь: Засгийн газрын институцичлагдсан хүний эрхийн хөтөлбөрүүдийг өөрчлөхөд Про боногийн хүчийг ашиглах нь - Бүс нутгийн болон дэлхийн чиг хандлага” сэдвээр зохион байгуулагдаж чуулган амжилттай өндөрлөж, Азийн 14 дэх удаагийн Про боно чуулга уулзалтыг Япон улсад зохион байгуулахаар шилжин явах тугийг хүлээлгэн өгсөн.



ТӨЛБӨРИЙН ЧАДВАРГҮЙ ИРГЭДЭД ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦАА, ӨМГӨӨЛЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ АСУУДАЛ ЭРХЭЛСЭН ХОРОО

Төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн тусалцаа, өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх асуудал эрхэлсэн хорооны Удирдах зөвлөлийн хурлыг 2025 оны 01 сарын 24, 04 дүгээр сарын 28, 12 дугаар сарын 03-ны өдөр тус тус зохион байгуулав.

Төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх асуудал эрхэлсэн хорооны үйл ажиллагаа явуулах чиг үүргийн хүрээнд:

Хорооны гишүүдийг идэвхжүүлэх зорилгоор 2025 оны 04 дүгээр сарын 28-ний өдөр “Төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх асуудал эрхэлсэн хорооны нийт гишүүдийн өдрийн цайны уулзалт”-ыг зохион байгуулж. Уулзалтаар Монголын Хуульчдын холбооны зөвлөлийн 2014 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн хурлаар баталсан, “Төлбөрийн чадваргүй иргэнд хууль зүйн туслалцаа үзүүлэх түр журам”-ыг өөрчлөн шинэчлэх талаар хэлэлцэн, гишүүдээс холбогдох саналыг авч холбооны Удирдах зөвлөлийн хурлаар оруулахаар тогтсон, мөн хорооны нийт гишүүдэд холбоо, хорооноос зохион байгуулж буй үйл ажиллагааг цаг алдалгүй хүргэх, тэдний оролцоог идэвхжүүлэх зорилгоор гишүүдийн нэгдсэн вайбер групп чат үүсгэж байна.

“Хуульчийн про боно өдөр-2025” өдрийн хүрээнд иргэдэд хууль, эрх зүйн зөвлөгөө, мэдээлэл өгсөн

Монголын Хуульчдын холбооны Ерөнхийлөгчийн тушаалаар жил бүрийн тавдугаар сарын 01-ний өдрийг “Хуульчийн про боно өдөр” болгон зарласан. Энэ жил Монголын Хуульчдын холбоо нь Нийслэлийн Засаг даргын Тамгын газартай хамтран “Хуульчийн про боно өдөр”-ийг долоо дахь жилдээ зохион байгуулсан бөгөөд Сүхбаатарын талбай болон 21 аймгийн төв талбай, Нийслэлийн нэгдсэн үйлчилгээ төв, алслагдсан хороод, тойргийн шүүх, хялбар ажиллагааны шүүхийн гадна талбайд “Хуульчийн про боно-2025” өдөрлөгийг зохион байгуулсан. Тус өдөрлөгөөр Төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх асуудал эрхэлсэн хорооны тэргүүн Р.Булгамаа, хорооны удирдах зөвлөлийн гишүүн өмгөөлөгч Ц.Долгорсүрэн, Г.Ганбаяр, хорооны удирдах зөвлөлийн гишүүн, улсын өмгөөлөгч С.Энх-Эрдэнэ, хорооны гишүүн өмгөөлөгч Р.Уранчимэг нар иргэдэд хууль эрх зүйн зөвлөгөө, мэдээлэл өглөө.



Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад сургалт орлоо

Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд хууль эрх зүй, гэмт хэрэг, эрх зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Нийслэлийн ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад “Төрөөс хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй үзүүлэх хүрээ, тогтолцоо”, “Хууль зүйн туслалцаа авах эрх”, “Эрүүгийн хууль, Зөрчлийн хуулийн ялгаа, хууль зүйн ойлголт”, “Хүүхдийн эрх, хүүхэд хамгаалал”, “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” зэрэг сэдвээр 2025 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр ерөнхий боловсролын 92 дугаар дунд

сургуулийн 9 дүгээр ангийн 100 сурагчид, Баянзүрх дүүргийн 16 хорооны “Өнөр бүл хүүхдийн төв”-ийн 40 хүүхдэд, 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр Ерөнхий боловсролын 92 дугаар дунд сургуулийн 7 дугаар ангийн 33 сурагчид, 11 ангийн 120 сурагчид, 2025 оны 05 дугаар сарын 05-ны өдөр Ерөнхий боловсролын 53 дугаар дунд сургуулийн 10 дугаар ангийн 8 бүлгийн 240 сурагчдад тус тус “Эрх зүйн мэдлэг олгох” сургалтыг зохион байгуулж, нийт **533** сурагчид хамрагдсан байна.

Тус сургалтын сургагч багшаар Монголын Хуульчдын холбооны гишүүн хуульч, улсын өмгөөлөгч С.Энх-Эрдэнэ ажилласан.



Зураг 1. 2025.04.28 өдөр ЕБС-ийн 92 -р дунд сургуулийн 9 ангийн 100 сурагчдад “Эрх зүйн мэдлэг олгох” сургалт



Зураг 2. 2025.04.29 өдөр ЕБС-ийн 92 -р дунд сургуулийн 11 ангийн 120 сурагчдад “Эрх зүйн мэдлэг олгох” сургалт



Зураг 3. 2025.04.29 өдөр ЕБС-ийн 92 -р дунд сургуулийн 7 ангийн 33 сурагч сурагчдад “Эрх зүйн мэдлэг олгох” сургалт



Зураг 4. 2025.05.05 өдөр ЕБС -ийн 53 -р дунд сургуулийн 10 ангийн 8 бүлгийн 240 сурагчдад “Эрх зүйн мэдлэг олгох” сургалт



Зураг 5. 2025.04.28 өдөр БЗД-ийн 16 хорооны “Өнөр бүл хүүхдийн төв”-н 40 хүүхдэд “Эрх зүйн мэдлэг олгох” сургалт

Мөн хорооны Удирдах зөвлөлийн гишүүн, өмгөөлөгч Ц.Долгорсүрэн Нийслэлийн ерөнхий боловсролын 84 дүгээр сургуулийн 8 болон 12 дугаар ангийн сурагчдад “Хүүхдийн эрх”, “Гэмт хэрэг, зөрчлийн талаар сургалт орсон.



Төлбөрийн чадваргүй иргэдээс гаргасан өргөдөл, хүсэлтийг шийдвэрлэсэн байдал

Төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх асуудал эрхэлсэн хороо нь төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг идэвхтэй хийж гүйцэтгэж байна.


2025 онд **38** иргэн, **15** шүүх, цагдаагийн байгууллагаас “Өмгөөлөгч томилуулах тухай” хүсэлт гаргаснаас, **27** иргэнд өмгөөлөгч томилсон, **4** иргэн гаргасан хүсэлтээсээ татгалзсан, **6** иргэний хүсэлтийн дагуу өмгөөлөгчтэй холбож өгсөн боловч өмгөөлөгчийн зүгээс хэрэг маргаан дээр ажиллах эсэх нь тодорхой болоогүй байна.

Байгууллагуудаас ирүүлсэн “Өмгөөлөгч томилуулах тухай” албан бичигтэй танилцаад, харьяаллын дагуу Хууль зүйн туслалцааны төв рүү **7** хүсэлтийг шилжүүлж, **3** хэрэг дээр өмгөөлөгч томилж шийдвэрлэсэн, **4** хэрэг дээр өмгөөлөгч томилох ажиллагаа хийгдэж байна.


Тодруулбал, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссоос Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа 461 дүгээр хорих ангид хоригдож буй 2 иргэнд, тухайн байгууллагад өрийн эрхийг зөрчигдсөн талаар гомдол гаргаж, өмгөөлөгч авах хүсэлт гаргасан 2 иргэний хүсэлтийг тус тус ирүүлсэнийг хүлээн авсанаас 2 иргэний хүсэлтийг шийдвэрлэх ажиллагаа хийгдэж байна.

Дундговь аймгийн прокурорын газраас тус байгууллагад яллагдагчаар татагдаад буй эрүүгий хэргийн яллагдагчид өмгөөлөгч томилуулахаар ирүүлсэн албан бичигтэй танилцахад тус аймгийн Улсын өмгөөлөгч нь тухайн хэрэгт харицан эсрэг сонирхолтой яллагдагчийг өмгөөлж байгаа тул хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэсэн болно.

Өмгөөлөгч томилуулахаар хүсэлт гаргасан **1** иргэн төлбөрийн чадваргүй гэдгийг нотлох баримт бичгийг хуурамчаар үйлдсэн тул хүсэлтийг хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэсэн байна.



2025 онд иргэдээс өмгөөлөгч томилуулахаар гаргасан хүсэлтийн **69** хувь нь иргэний хэрэг, **13** хувь нь эрүүгийн хэрэг, **9** хувь нь зөрчил, **9** хувь нь захиргааны хэрэг маргаан байна.



Бусад үйл ажиллагаа:

Хүүхдийн эсрэг үйлдэж буй гэмт хэргийн мөрдөн шалгах ажиллагааны чанар, хүртээмжийг дээшлүүлэхэд хамтран ажиллана



Төлбөрийн чадваргүй иргэдэд хууль зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээ үзүүлэх асуудал эрхэлсэн хорооны тэргүүн, өмгөөлөгч Р.Булгамаа, Захиргааны эрх зүйн хорооны дэргэдэх Хүүхдийн эрхийн дэд хорооны зохицуулагч, өмгөөлөгч М.Хандармаа болон бусад хуульч, өмгөөлөгчдийн төлөөлөл Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын албаны дарга Л.Нямгэрэл болон хууль сахиулах байгууллагуудын төлөөлөлтэй уулзлаа. Уулзалтын үр дүнд Гэмт хэргээс урьдчилан

сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн Ажлын алба, Цагдаагийн ерөнхий газар, Шүүх шинжилгээний ерөнхий газар, Монголын Хуульчдын холбоо хамтран мөрдөгч, өмгөөлөгчдийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх, хүүхдийн эсрэг үйлдэж буй гэмт хэргийн мөрдөн шалгах ажиллагааны чанар, хүртээмжийг дээшлүүлэх чиглэлээр хамтран ажиллахаар болсон.

НОТАРИАТЫН ХӨГЖЛИЙГ ДЭМЖИХ ХОРОО


Нэг. Хуульчдын холбооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, оролцох хамтран ажиллах ажлын хүрээнд:



1.1. Монголын Хуульчдын холбоо нь Монголын Нотариатчдын танхимтай хамтран ажиллах гэрээ байгууллаа. Хамтран ажиллах гэрээг Монголын Хуульчдын холбооны Ерөнхийлөгч П.Одгэрэл, Монголын Нотариатчдын танхимын Ерөнхийлөгч Ч.Баянжаргал нар 2025 оны есдүгээр сарын 16-нд үзэглэж, цаашид хамтран хэрэгжүүлэх ажлын талаар солилцлоо. Монголын Хуульчдын холбоо болон Монголын Нотариатчдын танхим нь Хуульчдын ордонд үйл ажиллагаа явуулах болсонтой холбогдуулан

талууд бие биеийнхээ үйл ажиллагааг дэмжих, хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилгоор өргөн хүрээнд хамтран ажиллахаар энэхүү гэрээг байгуулсан. Монголын Хуульчдын холбоо нь чиг үүргээ хороодоор дамжуулан хэрэгжүүлдэг. Энэ хүрээнд Нотариатчдын танхимын гишүүд нь Нотариатын хөгжлийг дэмжих хороог байгуулж, Хуульчдын холбооны үйл ажиллагаанд идэвхтэй оролцож ирсэн билээ.

1.2. Монголын Хуульчдын холбооны Ерөнхийлөгчийн нэрэмжит шатрын 2025 оны тэмцээнд Монголын Нотариатчдын танхим буюу Нотариатын хөгжлийг дэмжих хорооноос орсон баг тусгай байр буюу 4-р байрт орж, Шилдэг эмэгтэй шатарчин-хуульч, нотариатч С.Анударь тодорсон амжилт үзүүлсэн.



1.3. Монголын Нотариатчдын танхим гишүүн нотариатчдын мэргэжил, ур чадварыг дээшлүүлэх зорилгоор 2025 оны 05 дугаар сарын 14-ний өдөр мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх цахим сургалтыг зохион байгуулсан. Тус сургалтад Цагдаагийн ерөнхий газар, Улсын ерөнхий прокурорын газар, Монголбанк Санхүүгийн мэдээллийн албаны төлөөллүүд оролцож, мэдээлэх үүрэг бүхий 145 нотариатч хамрагдсан.

1.4. 2025 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр Монголын Нотариатчдын танхим, Улсын бүртгэлийн газар, “Интерактив” ХХК-тай хамтран цахим нотариатын системд зуучлалын модуль нэвтрүүлэхтэй холбоотой сургалтыг зохион байгуулсан. Сургалтад Ерөнхийлөгч Ч.Баянжаргал, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч У.Болдхүү, Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн газрын дарга Б.Ариунболд, “Интерактив” ХХК-ийн ерөнхий захирал Б.Ууганбаяр нар хүрэлцэн ирж, цаг үеийн асуудал, хамтын ажиллагааны талаар мэдээлэл хүргэлээ. Сургалт цахим болон танхимаар зохион байгуулагдаж, 220 гаруй нотариатч, улсын бүртгэгч, нотариатчийн туслах ажилтан хамрагдав.

1.5. 2025 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр Монголын Нотариатчдын танхимын Ерөнхийлөгч Ч.Баянжаргал Төв аймгийн нотариатчийн үүрэг гүйцэтгэгчид буюу сумдын Тамгын газрын дарга болон хууль эрх зүйн мэргэжилтнүүдэд “Нотариатын үйлдэл гэрчлэх арга зүйн” сургалт явуулж, тэдгээрийн сонирхсон асуултад хариулан мэдээлэл солилцов. Энэхүү сургалтад 40 гаруй албан хаагч хамрагдсан бөгөөд сумдад амьдарч буй иргэдэд нотариатын үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай мэдээлэл өгсөн.

1.6 “Хуульчийн про боно өдөр-2025” өдөрлөгт оролцов

“Хуульчийн про боно өдөр-2025” өдөрлөгт Монголын Нотариатчдын Танхимын гишүүд нотариатын үйлдэлтэй холбоотой эрх зүйн үнэ төлбөргүй зөвлөгөө өгч, баримт бичгийн хуулбар гэрчлэн оролцсон.



Хоёр. Нотариатчдын дунд болон хуулийн төв байгууллагуудын дунд спортын тэмцээн зохион байгууллаа

2.1. Монголын Хуульчдын холбооны Булган аймаг дахь салбар, Булган аймгийн Нотариатын салбартай хамтран "Нотариатын байгууллага үүсэж хөгжсөний 100 жилийн ой"-г тохиолдуулан Хууль, хүчний байгууллагын албан хаагчдын дунд спортын 🎯🏓🏏 3 төрөлт тэмцээнийг зохион байгууллаа. Уг тэмцээнд



🎯 Дартсын төрөлд

1-р байр Шүүхийн шинжилгээний хэлтэс, ТЕГ-ын Булган аймаг дахь хэлтсийн хамтарсан баг,
2-р байранд Булган аймгийн Онцгой байдлын газар
3-р байранд Булган аймаг дахь Шүүхийн Тамгын газар;

🏓 Ширээний теннис төрөлд

1- р байр Д.Төрболд, Т.Өнөржаргал
2-р байр Д.Төгсбаяр, Б.Чулуунцэцэг
3-р байр П.Цогбадрах, Б.Алтанцэцэг

🏏 Гар бөмбөгийн төрөлд

1-р байр Булган аймгийн Цагдаагийн газар,
2-р байр Шүүхийн шинжилгээний хэлтэс, ТЕГ-ын Булган аймаг дахь хэлтсийн хамтарсан баг,

3-р байранд Булган аймгийн Онцгой байдлын газар тус тус байр эзэллээ.

Мөн 3 төрлийн нийлбэр дүнгээр Булган аймгийн Цагдаагийн газар тэргүүлж, шилжин явах цомын эзэн боллоо.



2.2. 2025 оны 10 дугаар сарын 05-ны өдөр Монголын Нотариатчдын танхимын нэрэмжит хуулийн төв байгууллагуудын дунд жил бүр зохион байгуулагддаг шатрын тэмцээн "Хуульчдын ордон"-д болж, өндөрлсөн байгаа. Уг тэмцээнийг Нотариатын хөгжлийг дэмжих хороо хамтран зохион байгуулагчаар ажилласан.

Энэ удаагийн шатрын тэмцээн Монгол Улсад Нотариатын байгууллага үүсэж хөгжсөний түүхт 100 жилийн ойн баярын хүрээнд хийгдэж буйгаараа онцлогтой бөгөөд нотариатын байгууллагын үйл ажиллагааг олон нийтэд сурталчлах, хуулийн байгууллагуудын хамтын ажиллагааг бэхжүүлэх,

харилцан туршлага солилцох, шатрын спортыг түгээн дэлгэрүүлэх зорилготой.

Шатрын тэмцээнд Монголын Хуульчдын холбооноос 3 баг, Монгол Улсын Их Хурлын Тамгын газар, Улсын Дээд Шүүх, Улсын Ерөнхий Прокурорын Газар, Монголын Өмгөөлөгчдийн Холбоо, Авлигатай Тэмцэх Газар, Цагдаагийн Ерөнхий Газар, Тагнуулын Ерөнхий Газар, Шүүхийн Шийдвэр Гүйцэтгэх Ерөнхий Газар, Дотоод хэргийн их сургууль, Шихихутуг их сургууль зэрэг байгууллагын 20 багийн 80 тамирчид оролцож, шилдгүүдээ тодрууллаа.

Нэгдүгээр байр: Монголын өмгөөлөгчдийн холбоо (М.Мөнгөнхүү, Б.Баасансүрэн, Т.Сайнбаяр, Б.Ургамалцэцэг);

Хоёрдугаар байр: Улсын их хурлын тамгын газрын 2-р баг (Г.Алтан-Оч, Ё.Баярсайхан, Г.Чулуун, У.Лхамсүрэн);

Гуравдугаар байр: Цагдаагийн ерөнхий газар 1-р баг (Д.Гандуулга, Г.Идэрбаатар, С.Батзориг, М.Хишигбаяр);

Ширээ бүрийн шилдэг тамирчдаар:

1-р ширээ: Цагдаагийн ерөнхий газрын 1-р багийн тамирчин Д.Гандуулга;

2-р ширээ: Улсын Их Хурлын Тамгын газрын 2-р багийн тамирчин Ё.Баярсайхан;

3-р ширээ: Монголын Хуульчдын холбооны 2-р багийн тамирчин Д.Ганхөлөг;

4-р ширээ: Улсын Их Хурлын Тамгын газрын 2-р багийн тамирчин У.Лхамсүрэн



Гурав. Нотариатын хөгжлийг дэмжих хорооны зохион байгуулалтын ажлын хүрээнд:



3.1 Олон Улсын Нотариатын Холбооны Азийн Хэрэг Эрхлэх Комиссын гишүүд 2025 оны 03 сарын 06-ны өдөр цахимаар хуралдлаа. Хурлыг тус комиссын Ерөнхийлөгч Ч.Баянжаргал удирдаж, Хятад, Индонез, Япон, Казакстан, Солонгос, Узбекистан, Вьетнам, Лебанон Улсын нотариатын байгууллагын Ерөнхийлөгчид болон холбогдох албаны хүмүүс оролцлоо.

“Нотариатын үйлдэл гэрчлэх ажиллагаа ба практик” сэдвээр гишүүн байгууллагууд илтгэл хэлэлцүүлж, харилцан туршлага судлав. Энэ нь нотариатын үйлдлийг хууль тогтоомжид нийцүүлэн гэрчлэх ажиллагааг боловсронгуй болгох практик ач холбогдолтойгоос гадна харьцуулсан судалгаа хийх онолын ач холбогдолтой юм. 2025 оны 6 сард Улаанбаатар хотноо зохион байгуулагдах Азийн Хэрэг Эрхлэх Комиссын 15 хурлаар шинэ Ерөнхийлөгчийг сонгож, түүний бүрэн эрхийн хугацааг баталгаажуулах буюу “Нотариатчдын форум-2025” арга хэмжээг зохион байгуулах талаар хязлэлцсэн.

3.2 Азийн хэрэг эрхлэх комиссын 15 дахь их хурал буюу НОТАРИАТЧДЫН ФОРУМЫГ зохион байгууллаа



“Нотариатын эрх зүйн хөгжлийн чиг хандлага” олон улсын семинарыг 06 дугаар сарын 25-ны өдөр зохион байгуулсан. “Нотариатын үйл ажиллагаанд хиймэл оюун хэрэглэх нь” Германы холбооны Нотариатчдын танхимын Олон улсын харилцааны зохицуулагч, Хуулийн зөвлөх Kim Brisevas, “Нотариатч эвлэрүүлэн зуучлагчаар ажиллаж буй Францын туршлага” Нотариатч, Францын Нотариатын дээд зөвлөл Corinne Dessertenne-Brossard, “Нотариатч эвлэрүүлэн зуучлагчаар ажиллаж буй

Узбекистаны туршлага” Узбекистаны Нотариатчдын Танхимын Ерөнхийлөгч Dilshod Ashurov., “Нотариатын актыг гүйцэтгэх тухай” Олон Улсын Нотариатын Холбооны ОУ-ын хамтын ажиллагааны комиссын дарга Германы холбооны Нотариатчдын Танхимын ОУ-ын Харилцааны тэргүүн Richard Bock., “Нотариатын үйлдлүүдийг гүйцэтгэх Хорват улсын журмууд” Загреб дахь нотариатч, Хорватын нотариатчдын ОУ-ын хорооны ерөнхийлөгч Tihana Sudar., “Нотариатын мэдэгдэх хуудас бичих онол, практикийн асуудал” сэдвээр Монголын Нотариатчдын танхимын Ерөнхийлөгч Ч.Баянжаргал нар илтгэл хэлэлцүүлсэн.



Олон улсын нотариатын холбооны Азийн хэрэг эрхлэх комиссын 15 дахь хурлыг 06 дугаар сарын 26-ны өдөр Shangri-La зочид буудалд зохион байгуулж “Зайн гэрчлэлтийн эрх зүйн зохицуулалт, практик сэдвээр Олон Улсын Нотариатын Холбооны Азийн хэрэг эрхлэх комиссын гишүүн байгууллагын төлөөлөгчид “Зайн гэрчлэлтийн эрх зүйн зохицуулалт, практик” сэдвээр илтгэл хэлэлцүүлсэн. Мөн Хятад, Япон, Казкастан, Индонез, Солонгос, Узбекистан, Вьетнам, Монгол төлөөлөгч нар үйл ажиллагааны 2024 оны тайлангаа тавьсан.

Азийн хэрэг эрхлэх комиссын 15 дахь их хурал буюу “Нотариатчдын форум”-ыг зохион байгуулах арга хэмжээнд Монголын Хуульчдын холбоо, Монголын Хуульчдын холбооны Нотариатын хөгжлийг дэмжих хороо хамтран зохион байгуулсан.



Монгол Улсад Нотариатын байгууллага үүсэж хөгжсөний түүхт 100 жилийн ойн хүндэтгэлийн арга хэмжээ 06 дугаар сарын 27-ны өдөр Төрийн ордонд зохион байгуулагдсан.

4. Бусад үйл ажиллагаа



4.1. Монголын Нотариатчдын танхим нь 2025 оны 10 сарын 08-ны өдөр “Хуульчдын ордон”-д байрлах шинэ байрныхаа нээлтийн үйл ажиллагааг зохион байгууллаа. Нээлтийн үйл ажиллагаанд Монголын Хуульчдын холбооны Ерөнхийлөгч П.Одгэрэл, Тамгын газрын дарга Ш.Жолбарс, Монголын Нотариатчдын танхимын удирдлагын багийн болон гишүүн нотариатчид оролцов.

4.2. Нотариатчдын эрүүл мэндийг хамгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд 2025 оны 10 дугаар сарын 10-ны өдөр Монголын Нотариатчдын танхим, Монголын Хуульчдын холбооны Нотариатын хөгжлийг дэмжих хороо Монос групптэй хамтран нотариатч нартаа эрүүл мэндийн үзлэг шинжилгээ, оношлогоо хийлгэсэн.

4.3. Монгол Улсад нотариатын байгууллага үүсэж хөгжсөний түүхт 100 жил, Монголын Нотариатчдын танхим үүсгэн байгуулагдсаны 28 жилийн ойг тохиолдуулан 2025 оны 03 дугаар сарын 15-ны өдөр нийт гишүүдийн дунд “NOTARY’S GOT TALENT” арга хэмжээг зохион байгууллаа. Энэхүү арга хэмжээнд 22 үзүүлбэр толилуулагдсанаас 3 шилдэг үзүүлбэрийг шалгаруулсан.